# ГЭРТ ТАНЬ ХҮРГЭЖ ӨГӨХӨӨР БИ ИРЛЭЭ



Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн тавьсан ном,
ишлэлийн түүвэр

ГЭРТ ТАНЬ ХҮРГЭЖ ӨГӨХӨӨР БИ ИРЛЭЭ
Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн тавьсан ном, ишлэлийн түүвэр

# ГЭРТ ТАНЬ ХҮРГЭЖ ӨГӨХӨӨР БИ ИРЛЭЭ

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн тавьсан ном,
ишлэлийн түүвэр

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Олон Улсын
Нийгэмлэгийн Хэвлэлийн ХХК

**Зохиогч:** Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай
**Дүрс ба дуу бичлэг**: Видео баг
**Сийрүүлсэн**: Формосагийн лекц сийрүүлэх баг
**Орос хэлнээс орчуулсан:** Б.Төмөрбаатар
**Англи эхтэй нь тулгаж хянан тохиолдуулсан:** Д.Алтанзаяа
**Эмхтгэсэн:** Софи Лапер ба Памела Андерсон
**Хавтасны дизайныг:** Эн Сө Янг
Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн бүтээл "Японы алимын цэцэрлэг" уран зураг
**Хэвлэсэн газар**: Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн
Олон Улсын Нийгэмлэгийн Хэвлэлийн ХХК.
No. 236 Songshan Road, Taipei, Formosa, R.O.C.
Утас: 886-2-87873935 Факс: 886-2-87870873
И-мэйл: smchbooks@Godsdirectcontact.org
ROC Postagiro:19259438

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай©2009
Анхны хэвлэл: 2009 оны 1 сар
Хоёрдахь хэвлэл: 2009 оны 4 сар

ISBN: 978-986-6895-39-5

Энэхүү номын бүх эрх зохиогчийн эрхийн хуулиар хамгаалагдсан болно.
Зохиогч болон эрхлэн хэвлүүлэгчээс зөвшөөрөл авсны дараа энэ номыг олшруулж хэвлэж болно.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Олон Улсын Нийгэмлэг нь дэлхий даяар бясалгалын төвүүдтэй бөгөөд эдгээр төвүүд нь шашин шүтлэг, үндэс угсаа харгалзалгүй Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн уламжилсан Аръяабалын номын цогц хэмээх бясалгалын өнө эртний аргатай танилцан суралцахад нь хүмүүст тусалдаг юм.

# АГУУЛГА

Өмнөх үг ........................................................................ 7

Хайр энэрлийн замаар замнахуй................................................ 9

1. Дэлхий дээрх амьдрал........................................................... 13
- Дэлхий дээрх бидний зорилго........................... 15
- Ирээдүй бидний гарт........................................ 17
- Газар дэлхийн хайраас хальж гарахуй.................. 23
- Бурханлаг хайр.................................................. 30

2. Саадыг гэтлэхүй .................................................................. 35
- Хорт мууг гэтлэхүй........................................... 45
- Шалтгаан үр дагаварын хууль ............................ 48
- Төрөл арилжихуй ............................................. 52
- Үхэл ба үхэхүй. ..................................................56

3. Шашин суртахуунаас оюун санааны ухааралд хүрэхүй ... 63
- Шашин суртахуунаас хальж гарахуй.................. 66
- Христын мартагдсан илгээлт............................. 67
- Есүс ба бясалгал ............................................... 71
- Эзэн Бурханаас тусгаарлагдахуй ........................ 72
- Гэртээ харихуй .................................................. 74

4. Гэрлийг олохуй .................................................................. 83
- Дотоодын Бурханы Орон .................................. 83
- Эзэн Бурханыг ухаарахуй.................................. 86
- Гэгээрэл буюу агуу их сэхээрэл ......................... 90
- Туулан гэтэлгэх гурван зам мөр ......................... 92
- Агшин зуурын гэгээрэл ...................................... 93
- Энэ ертөнцийн чанадад....................................... 97

5. Багш нар гэж хэн бэ?..........................................................101
- Жинхэнэ Багшийг хэрхэн таних вэ?.................103
- Гурван янзын багш ............................................106
- Бидэнд яагаад амьд сэрүүн Багш хэрэгтэй вэ? .109
- Амьд сэрүүн Багшийг хайрлахуй.......................117
- Их Багш нарын зам мөр .....................................118

6. Авшиг ....................................................................................123
- Авшиг хүртэхүй..................................................123
- Авшиг хүртэхийн ач тус ....................................125
- Шавилахуй .........................................................127
- Таван сахил........................................................131
- Мацаг хоол .........................................................139

7. Бясалгал ...............................................................................144
- Бясалгалын жинхэнэ утга учир .........................146
- Хэрхэн яаж бясалгах вэ?....................................148
- Аръяабалын бясалгалын арга ............................154
- "Үг" хэмээх дотоод хэлбэлзэл ...........................157

Хавсралт

а) Лекцийн жагсаалт ........................................................162

б) Хэвлэл ...........................................................................167

в) Бидэнтэй хэрхэн холбогдох вэ .....................................174

# Нэмэлт тайлбар

Эзэн Бурхан болоод Дээд Оюун Санааны тухай ярихдаа Эзэн Бурхан эр эсвэл эм хүйстэй алин болох маргаанаас зайлсхийж, хүйсний ялгаа заадаггүй оригинал нэр томьёо хэрэглэж байхыг Багш бидэнд зөвлөсөн юм.
She + He = Hes  (Bless гэдэгтэй адил дуудна.)
Her + Him = Hirm (Firm гэдэгтэй адил дуудна.)
Hers + His = Hiers (Dear гэдэгтэй адил дуудна.)
Жишээлбэл: Эзэн Бурхан хүсвэл юмыг Тэрээр (Hes) Өөрийн (Hirmself) таалллаар, Түүний (Hiers) хүсэл зоригт нийцэж байхаар хийдэг юм.

---

Оюун санааны багш, уран бүтээлч дизайнер Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай дотоодын гоо сайхныг илэрхийлсэн бүхий л зүйлд дуртай байдаг юм. Тиймээс ч Тэр Вьетнамыг “Ау Лак”, Тайванийг “Формоса” хэмээн нэрлэдэг. Ау Лак гэдэг нь эртний вьетнам хэлээр аз жаргал гэсэн үг бол Формоса буюу үзэсгэлэнтэй гэсэн үг нь Тайваний арлын байгаль болоод ард түмний сайхныг бүрэн дүүрэн илэрхийлнэ. Эдгээр нэрийг хэрэглэх нь тухайн нутаг орон ард түмэнд нь аз жаргал, оюун санааны дэвшил авчирна гэж Их Багш үздэг юм.

# Өмнөх үг

Тэнсэлгүй үнэхээр туулсан, номлолоо айлдаж буй Багштай учран ариун холбоо тогтоох хувь зохиол хүн бүхэнд тохиодог гэж үү? Ийм зүйрлэшгүй эрхэм нандин аз завшааныг "Гэрт чинь хүргэж өгөхөөр би ирлээ" хэмээх энэ дээдийн ном олгож байна. Тэнсэлгүй туулсан Багш Чин Хайн тайлсан ном лекц, ярилцлага, албан бус ярианаас нэгэн шавь нь өөртөө тэмдэглэж авсан хувийн цуглуулгаас энэ номын эхлэл тавигдсан ажээ. Англи хэл дээр тайлсан ном сургаалыг сийрүүлэн бичсэн болон өөр бусад олон хэлнээс орчуулгыг үйлдсэн чин сэтгэлт шавь нарынх нь тус дэмжлэгээр Их Багшийн адислалт номын сэдвүүдийг та бүхний таалалд толилуулж байна.

Дотооддоо орших бурхан чанараа бүрэн дүүрэн таньсан Их Багш нар гэдэг хэн бүхний дотоодод орших хамгийн эрхэм ариун бурханлаг чанарын төгс төгөлдөр толь нь болдог. Тэд өөрсдийн ашиг тусын төлөө биш эх болсон зургаан зүйлийн хамаг амьтныг зовлонгоос гэтэлгэхийн төлөө Гэгээрлийн зам мөрөөр буцалтгүй замнадаг юм. Их Багш Чин Хай бол ийм тэнсэлгүй үнэхээр туулж гэгээрсэн Багш нарын нэг юм. Өнө эртнээс Их Багш нар энэ замбативд залрах үедээ хүмүүст уламжилж байсан, дотоодын Гэрэл ба Аялгуу ажихуй хэмээн нэрлэгдэх бясалгалын арга буюу Арьяабалын номын цогцсыг Тэрээр бидэнд уламжлан дамжуулж, төгс гэтэлгэх мөрийг зааж өгдөг.

"Гэрт тань хүргэж өгөхөөр би ирлээ" хэмээх дээдийн номын бүлэг сэдэв бүр нь Тэнсэлгүй үнэхээр туулсан Их Багшийн билгүүн ухааны эрдэнэсийн сангаар таны оюун санааг бүхий л талаар гийгүүлэн, арвин их асуудлыг тайлбарлан тодотгож өгөх болно. Номын ихэнх сэдэв асуулт хариултын хэлбэрээр орсон нь агуулгыг илүү тодорхой болгохын сацуу

Аръяабалын бясалгал болон Их Багшийн айлдсан бусад сургаалын олон талыг гүн гүнзгий ойлгох боломж олгоно.

Бясалгагч шавь нар нь энэ номыг та бүхэнд өргөн барихдаа Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн эх сургаалын мөн чанарыг хадгалахыг чармайн, хамгийн чухал гэж үзсэн номлолуудын гол санааг онцлон багтаахыг хичээсэн билээ. Ийнхүү ном маань товчлон сийрүүлсэн шинж чанартай болохоор зарим үгс, түүнээс үүдээд утга санаа нь Их Багшийн жинхэнэ үгнээс ялгаатай байж мэдэх юм. Их Багш шавь нарынхаа чинхүү сэтгэл зүтгэлийг нигүүлсэн ойлгож, төгс төгөлдөр болж хараахан чадаагүй байж болох энэ номыг хэвлэн нийтлэхийг зөвшөөрсөнд бид баяртай байна.

Түүнчлэн Тэнсэлгүй Үнэхээр Туулсан Их Багш Чин Хай ном айлдах үедээ бичлэг хийхийг зөвшөөрч, дуу бичлэг, дүрс бичлэг нь олон хэлбэрээр бидэнд хүрэх боломжтой байдаг нь маш их аз завшаантай хэрэг юм. Эд бүхний ач буянаар, Тэнсэлгүй Туулсан Бурханы тайлсан номын увдисыг цаашид хүртье гэсэн уншигч хэн боловч эл номын ишлэлийн ном зүйн удирдамжийг ашиглан гүнзгийрүүлэн судлах боломжтой.

Та бүхнийг харанхуй мунхагийн манангаас Аугаа Их Сэхээрэл, Гэгээрэлд хүрэх замд тань Үнэний Мөр, Үнэний Хөтөч замчлах болтугай.

# ХАЙР ЭНЭРЛИЙН ЗАМААР ЗАМНАХУЙ

Эдүгээ үеийн Төгс Гэгээрсэн Их Багшийн амьдралын зам мөр

Хайр нигүүлслийг гололгүй, чамлалгүй
Хаа ч явсан хайн эрнэ, бид
Ханагар дэлхийн хэвлий дээрх
Хамаг амьтантай хуваалцья юу гэсэн юм.

Уулзан учирч ухаарч гэгээрэхийн хувь тохиосон хүн бүхэнд Тэнсэлгүй үнэхээр туулсан Их Багш Чин Хай хэмээн хүндлүүлэн өргөмжлөгдсөн Тэрбээр хайр энэрлийн замаар хэрхэн замнахын үлгэр дуурайл юм.

Нэрд гарсан хүмүүнлэг энэрэнгүй үзэлтэн, уран бүтээлч, оюун санааны хөтөч энэ билгүүн ухаантны хайр энэрэл, тус дэмжлэг нь соёл суртлын болоод арьс өнгөөр ялгаварлах хориг саадыг даван дэлхийн өнцөг булангийн сая сая хүмүүст хүрдэг. Үүний заримаас дурдахад: орон гэргүй ядуус, ДОХ болон хорт хавдар судлалын хүрээлэнгүүд, АНУ-ын дайнд оролцсон ахмад дайчид, доройбуурай амьдралтай өндөр настнууд, хөгжлийн бэрхшээлтэй ба оюуны хомсдолтой хүмүүс, дүрвэгсэд, газар хөдлөлт, үер, түймэр зэрэг байгалийн гамшигт нэрвэгдэгсдийг нэрлэж болно. Дээрх үйл ажиллагаагаар улбаалан билэг төгөлдөр халамжит эмэгтэйн бурханлаг чанар, Түүний нигүүлсэхүй сэтгэлийн үлгэр дуурайллаар үүссэн Олон Улсын Буяны Сангийн энэрлийн тоолж баршгүй олон жишээг мэдэж болно.

“Бидэнд бусадтай хуваалцаж болох сайн зүйл юу л байна, түүнийгээ бид найрсгаар хуваалцдаг. Тэгээд бидний дотоод мөн чанарт маш нарийн өөрчлөлт гарч, ухамсар оюун маань улам их хайр энэрлээр бялхдаг юм. Тэр цагт бид нэг зүйлийг мэдэрдэг. Тэр бол эхлэл нь. Бид үнэн ёсонд суралцан, өсч хөгжихийн тулд, энэ дэлхийнхээ хаана ч амьдарч байлаа гэсэн түүнийгээ диваажин

болгохын төлөө, өөрсдийн дотор орших мөнхийн хайр, мөнхийн билгүүн ухаан, бүтээн туурвихын сэтгэгдэшгүй их хүчээ ашиглаж сурахын төлөө энд ирсэн юм."

## Их Багшийн бага идэр нас

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай Вьетнам улсын төв хэсэгт мэндэлжээ. Тэрбээр хүүхэд ахуй цагаасаа мацаг хоол идсэн байна. Сурагч байхдаа эмнэлгийн өвчтөнүүдийг асран сэтгэл санааны дэмжлэг үзүүлж, ядарч зүдэрсэн хүмүүс, шархадсан зовсон амьтдад өчүүхэн биеийнхээ чадлын хэрээр үргэлж тусалдаг байжээ. Насанд хүрмэгцээ Европт очиж суралцан, дараа нь тэндээ Улаан загалмайн нийгэмлэгт орчуулагчаар ажиллаж байв. Энд ажиллаж байхдаа хүмүүний зовлон шаналал гэдэг дэлхийн аль ч үндэстэн ястан, аль ч өнцөг буланд адилхан байдаг юм байна гэдгийг төдөлгүй ухаарч, энэ эмгэгийг илааршуулах арга замыг эрж олох нь Түүний амьдралын хамгийн эн тэргүүний зорилго болсон юм. Энэ үед Тэр нэгэн герман эрдэмтэн эмчтэй гэр бүл болж, аз жаргалтай амьдарч байсан бөгөөд ургийн холбоогоо салгаж, тус тусийн зам мөрийг хөөх гэдэг хэн хэнд нь хатуу бэрх шийдвэр байсан хэдий ч Түүний чин үнэн хүсэл эрмэлзлийг мэдэх нөхөр нь удаан бодсоны эцэст зөвшөөрчээ. Ийнхүү Тэр Билгүүн ухааныг эрэлхийлэн аяндаа гарсан нь хоёр жил хэртэй үргэлжлэв.

## Гималайн нуруунд дияанчилсан нь

Мянган уул давааг давж, түмэн гол усыг гатлан, олон улс орноор аялан Үнэнийг эрсний эцэст Тэр Энэтхэгийн Гималайн нурууны гүнд хүрч, дотоодын гэрэл ба аялгууг бясалгадаг Аръяабалын номын цогцсын бурханлаг дамжлагыг өөрт нь уламжилж өгөх Гэгээрсэн Их Багшаа олсон байна. Хэсэг хугацаанд битүүмжлэн бясалгасны дараа Өөрөө төгс гэгээрэлд хүрчээ.

Гималайгаас эргэж ирснийхээ дараахан үеэс эргэн тойрныхоо хүмүүсийн ихэд хичээнгүйлэн хүссэнээр Аръяабалын бясалгалын аргыг тэдэнтэй хуваалцан авшиг хүртээж, тэднийг өөрсдийн агуу их хүчээ дотоодоосоо эрж олоход нь дэмжин зоригжуулж эхэлсэн юм. Амьдралын янз бүрийн замаар замнаж

яваа хүмүүс шашин шүтлэг, нийгмийн гарал, арьс өнгийг үл харгалзан Гуань Инь бясалгалын ач тусаар өдөр тутмын амьдралдаа үлэмжийн их сэтгэл ханамж, аз жаргал, амар амгаланг олж авснаа ухаарсан билээ. Удалгүй АНУ, Европ, Ази, Өмнөд Америк зэрэг дэлхийн өнцөг бүрээс, мөн НҮБ-аас Чин Хай Багшийг ном тайлж өгөхийг хүссэн урилгууд ар араасаа хүрэлцэн ирлээ.

## Амьдарч буй гариг дэлхийгээ үзэсгэлэн төгөлдөр болгохуй

Их Багш Чин Хай сүнс сэрлийн болон хүмүүнлэг туслалцааны эрхэм үлгэр дуурайл болохын зэрэгцээ хүмүүст амьдарч буй энэ дэлхийгээ гоо сайхан болгох урам зориг хайрлаж байдаг. Аръяабалын номын цогцсыг бясалгаж, төгс гэгээрэлд хүрснээр Чин Хай Багшийн дотоодын билгүүн ухаан, хүч чадал бүрэн дэлгэрч, олон авьяас билгээ нээсэн юм. Тэр уран зураг, яруу найраг, хөгжмийн бүтээл туурвил, үнэт эдлэл, хувцасны загвараараа дамжуулан, өөрийн мэдэх үндэстэн ястан олны дотоод сэтгэлийн болоод гаднахь гоо сайхныг илэрхийлэн харуулдаг билээ. Олон нийтийн хүсэлтээр 1995 онд Чин Хай Багш хувцасны загваруудаа Лондон, Парис, Милан, Нью-Йорк зэрэг хотуудаар олон улсын алдартай загварынхны хүрээнд аялан толилуулжээ. Их Багшийн уран бүтээлийн орлого нь Эзэн Бурханы үр хүүхдүүдийг ядарч зүдрэхэд нь ивээн туслах Түүний эрхэм ариун үүргийг хэрэгжүүлэхэд нь тус болох хүмүүнлэгийн зорилготой сангийн бие даасан эх үүсвэр болж чадсан юм.

## Их Багшийн гавьяа шагнал ба Түүний мөрөөдөл

Чин Хай Багш хэдийгээр алдар нэр, талархал шагналыг огтоос хүсэмжилдэггүй ч дэлхийн олон орны төр засгийн болон хувийн байгууллагуудаас Түүний бие сэтгэл харамгүй их үйлсийг нь үнэлж өдий төдий цол, шагналуудаа олгосоор ирсэн юм. Үүнд:

Дэлхийн Энх Тайвны Шагнал, Дэлхийн Оюун Санааны Удирдагчийн Шагнал, Хүний Эрхийг Дэмжигчийн Шагнал, Дэлхийн Хүмүүнлэг Иргэний Шагнал, Хүн Төрөлхтний Гарамгай Зүтгэлтэн, 2006 оны Гузийн Энх Тайвны Шагнал, Лос Анжелосын Хөгжмийн Долоо Хоногийн Шагнал, асар өндөр нэр хүндтэй Телли-ийн 27 дахь жилийн шалгаруулалтын Нэгдүгээр Мөнгөн Эрдэнийн шагнал зэргийг дурдаж болно. Түүгээр ч үл барам 10-р сарын 25 ба 2-р сарын 22-ныг АНУ-д Чин Хайн Өдөр болгон тэмдэглэдэг уламжлал тогтжээ. Хонолулу хотын Захирагч асан Франк Фасигийн хэлсэнчлэн "Тэр бол агуу их гэрэлт хүмүүн, бид бүхнийг өршөөн нигүүлсэгч сахиулсан тэнгэр юм". Чин Хай Багш бол сайн сайхан ирээдүйгээ бүтээн босгоход нь олонд туслагч, хүн төрөлхтөнд өөрийгөө үнэнээсээ зориулагч, манай эриний агуу их хүмүүсийн нэг мөн билээ. Түүхэн дэх агуу их хүмүүст бүгдэд нь хүсч мөрөөдөж явдаг зүйл байсан. Чин Хай Багшид ч бас тийм хүсэл мөрөөдөл буй. Тэр Өөрөө:

*"Дэлхий ертөнц маань энх амгалан болоосой гэж*
*би мөрөөддөг.*
*Аливаа аллага хядлага зогсоосой, хүүхэд бүхэн амар*
*амгалан, эв найртай амьдраасай гэж би хүсдэг.*
*Бүх үндэстэн гар гараа барилцан, бие биенээ харилцан*
*хамгаалж, тусалж байгаасай.*
*Манай үзэсгэлэнт гариг дэлхий маань бүү устаж*
*сүйрээсэй гэж би хүсдэг.*
*Энэ гариг маань бүрэлдэн тогтоход мянга түмэн тэрбум*
*жил шаардагдсан билээ.*
*Дэлхий маань маш үзэсгэлэнтэй, гайхамшигтай*
*шүү дээ.*
*Энэ дэлхийгээ би хойшдоо байсаар байх болно, ингэхдээ*
*энх амгалан, гоо үзэсгэлэн, энэрэл хайр дээр оршин*
*тогтносоор байх болно*
*хэмээн хүсч мөрөөддөг юм"*

гэж өгүүлж байна.

# Дэлхий дээрх амьдрал

Цаглашгүй Их Багш Чин Хайн тавьсан лекцээс

Бидний амьдрал яг л сэрж амжаагүй зүүд мэт бөгөөд бид хэчнээн удаан унтсан байсан ч хамаагүй, сүнс маань сэрмэгц л өөрсдийн жинхэнэ мөн чанараа нээдэг юм. Гэгээрэх үедээ бид оршихуйн дээд түвшинд хүрч, амьдралыг огт өөр талаас нь харах бөгөөд энэ бүхэн нь үтэр түргэн, ямар ч хүч чармайлт, догдлол хямралгүйгээр болж өнгөрдөг. Яг л кинонд хэн нэг нь үхэхэд энэ чинь ердөө л кино шүү дээ гэж бид мэдэж байдагтай адил юм .[17]

Бид бүгдээрээ кино од, харин дэлхий бол асар том тайз билээ. Бид төрлөөс төрөл дамжин заримдаа эхнэр, нөхөр, сайд дарга эсвэл хатан хааны дүрд, хааяа нэг их тааламжтай биш дүрд ч тоглодог. Бид мэдэхгүй, дүрдээ тоглосоор л, яагаад

би энэ дүрд тоглох ёстой, яагаад хаан ширээнд өөр хэн нэг нь сууж байхад би ердөө нарийн бичгийн дарга төдийхөн байна вэ гэж өөрөөсөө асуудаг. Нойрноосоо нэгэнтээ сэрчихсэн хүмүүс бол ертөнцийг бидний суралцахад болон хүсэл, хэрэгцээгээ биелүүлэх, төгс төгөлдөрт улам ойртоход зориулсан тайз төдий юм гэдгийг мэднэ” [14]

“Олонхи хүмүүсийн амьдралын хэв маяг нь хараахан бүрэн дүүрэн бус, аз жаргал болоод билгүүн ухааныг олоход тийм ч их зохимжтой бус байна. Оршихуйн олон түвшин байдаг бөгөөд эхнийх нь материаллаг, биет түвшин. Хүмүүсийн ихэнх нь идэх, унтах, бие махбодын бүх төрлийн таашаалд дурлах зэрэг мэдрэхүйн цэнгэл жаргал хөөцөлдөхийг гол зорилгоо болгож, залхуурал назгайралд автах хандлагатай энэ түвшинд амьдралаа өнгөрүүлдэг. Тэд амьдралынхаа хэрэгцээг хангахын тулд л зөвхөн ажил хийдэг бөгөөд эрхэм эрмэлзэл, сэтгэл зүрхээ ажилдаа зориулдаггүй. Амьдралаа боломжтой байлгахын тухайд л биш бол тэд ер нь ажил хийх дургүй, бүх хүн төрөлхтний төлөө ажиллах гэдэг тэдний хувьд хэцүү хэрэг байдаг.

Хоёр дахь нь сэтгэл хөдлөлийн гэж нэрлэгддэг түвшин. Энэ түвшний хүмүүсийн үзэл бодлын байр суурь их хүчтэй, эзэрхэг эсвэл дарангуйлагч зантай гэж хэлж болно. Үргэлж л тэдний зөв байх бөгөөд тэд аливаа зүйлийг бусад хүмүүс тэдний жишгээр хийхийг хүсч байдаг. Олон ч дарангуйлагч, хэт даврагч хөдөлгөөний их удирдагч гэгдэгсэд энэ түвшинд хамаарна. Сайн санаатай хэдий ч алдаа хийчихээд түүнийгээ хүлээн зөвшөөрдөггүй, тухайн байдлаа засахыг хичээдэггүй хүмүүс ч хүртэл энэ түвшинд багтана. Уян хатан чанар дутвал ийм аюултай байдаг юм.

Гурав дахь түвшинд бол бүгдийг бичиж авч чаддаг ч түүнийгээ тунгаан бодолгүйгээр сэлгэн гүйлгэж байдаг компьютер төдий махбод болох тархи (ингэж хэлэхэд харамсалтай байна), оюун ухаан дотор бид амьдардаг. Гэтэл уг нь сүнсний билгүүн ухаанаас ангид тархи бол ердөө л автомат машин юм шүү дээ. Энэ түвшний хүмүүс ерөнхийдөө өөрөө

өөртөө явцуурч, ямар ч хамаагүй нэг үзэл санаанд бүрэн автсан байна. Тэд энэ дэлхийд болж байгаа зүйлийн тухайд санаа зовдоггүй, түүнийг сайжруулах юм уу өөрсдийгөө өөрчлөх үнэн хүсэл төрдөггүй, нэг талаар гацчихсан улс. Тэд өөрсдийгөө байгаа тэр хэвээрээ л төгс төгөлдөр гэж тооцдог бөгөөд олон хүн үүнийгээ гэгээрэл хэмээн эндүүрэх нь бий.

Дараачийнх нь оюун санааны түвшин буюу өөрийгөө төгөлдөржүүлэх түвшин мөн бөгөөд учир нь энд бид өөрсдийгөө сүнстэйгээ адилтган үздэг. Бид бол бидний аз жаргал, урам зоригийн эх булаг болсон сүнстэйгээ угтаа адил, нэгдмэл цогц юм, бид энэ бие махбод биш юм гэдгээ ойлгоно. Бид дэлхийдээ болон өөрсдөдөө туслах гэж эрмэлзэнэ. Гэхдээ энэ нь хамгийн дээд түвшин биш, учир нь бидний “би” гэх үзэл байсаар, тэр нь өөрийн чадлаа ч бас мэдэж байдаг. *“Би Эцэгтэйгээ нэгдмэл юм”* гэж хэлэхэд хүртэл хоёулаа болчихож байгаа нь бас л хэт олдож байна! /Инээлдэв/

Үүний дараа Оройн Дээд Эзэн Бурханы түвшин, Бурханлаг ухамсар хийгээд ухаарлын түвшин байдаг. Эзэн Бурхан гэдэг бид болохоос өөр юу ч бус юм. Бид өмнөх түвшинд байхдаа Эзэн Бурхан биднээс тусгаар оршдог гэж бодож байсан. Тайлбарлахад хэдий амаргүй ч, энэ түвшинд бид хамгийн анх удаа юу ч бодолгүй, тэр байтугай хийж байна гэдгээ ч мэдэлгүй юмыг хийдэг. Бид үйлийн үр хураалгүй бүхнийг бүтээгч болдог. Энэ нь Есүс *“Би хийгээгүй - миний Эцэг хийж байгаа юм“* гэж тайлбарлаж байсан тэр санаа мөн.[28]

## *Дэлхий дээрх бидний зорилго*

“Гагцхүү Бурханлагийг ойлгож ухаараг гэж л бид бүхэнд хүний амьдрал заяасан юм. Хэрвээ энэ үүргээ үл тоомсорловол, бид одоогийн болоод дараа дараачийн бусад олон төрөлдөө хэзээ ч аз жаргалтай байж чадахгүй. Үнэнийг хэлэхэд энэ бол хүн төрөлхтний зовлон гамшгийн цорын ганц шалтгаан бөгөөд өөр шалтгаан байхгүй. Хэрэв бид

төрөхийнхөө өмнө эхийн хэвлийд байхдаа хэрхэн зовж тэмцэж байсан, урьд насныхаа алдаанд хэрхэн гэмшиж, энэ амьдралаа нэн утга учиртайгаар Эзэн Бурханд үйлчлэхийн тулд ашиглана гэж хэрхэн Түүнд амласнаа мэддэгсэн бол нэг хормыг ч өөр юм бодож, дэмий үрэлгүй, харин Бурханлагийг ойлгож ухаарахын тулд чөлөө зав бүхнээ зориулах байсансан!

Гэвч бид энэ дэлхийд төрмөгцөө л бүгдийг мартчихдаг. Учир нь хүмүүс ингэж мартдаг нь материаллаг ертөнцийн жам юм. Тиймээс аль нэгэн Багш залран ирж, эхийн хэвлийд байхдаа Эзэн Бурханд юу гэж амласнаа санах хүртэл маань бидэнд дахин дахин сануулж байх шаардлагатай болдог билээ. Бид бие махбодынхоо уураг тархиар санахгүй байж болох хэдий ч билгүүн ухааныг агуулагч сүнс маань санах болно." [31]

"Эзэн Бурхан биднээр дамжуулан газар дэлхийг адислахыг хүсдэг учраас бурхны орон ба газар дэлхийн хооронд холбоос болохын тулд бид бууж ирсэн билээ. Гэвч бид тун удаан хугацааны туршид чадлаа барж, ядарсны улмаас өөрсдийн агуу их үүрэг даалгаврыг мартчихжээ. Бидний жинхэнэ уг чанарыг сануулах гэж үе үе Багш ирдгийн учир энэ юм. Бидний энд байгаагийн учир ч энэ юм." [55]

"Авшиг хүртэх үедээ заалгасан дасгал сургуулиа чин сэтгэлээсээ хийж байх юм бол бид бурхны орон болоод газар дэлхийн хооронд тэнцвэртэй оршиж, дэлхий дээрх үүргээ ч биелүүлж, Бурханлаг Вант Улсыг ч мөн танин мэдэж чадна. Бидэнд газар дэлхийд биелүүлэх ёстой олон зүйлийн үүрэг байх тул түүнийгээ чадахын хэрээр гүйцээж дуусгах ёстой. Гэхдээ бидний дэлхий дээрх эн тэргүүний үүрэг бол дэлхийгээ бурхны орон болгохын төлөө, хамаг амьтан таатай сайхан амьдрахын зэрэгцээ өндөр дээд ухамсар луу алхам алхмаар дэвшихийн төлөө дэлхийгээ адислах явдал юм. Өөрөөр хэлбэл бид дотооддоо байх Бурханлаг хүчээ сэрээн ашигласнаар орчлон ертөнцийн өөрчлөлт хөгжилтөнд тус дэм үзүүлж байдаг юм.

Дэлхийдээ дээд зэргийн тусыг бүтээхийн тулд даруй ашиглаж болох хүч чадлыг бидэнд хайрлах тэрхүү агшин зуурын гэгээрэлд хүргэх сэтгэлийн авшиг бидэнд хэрэгтэй байдгийн чухамхүү учир энэ билээ. Зөвхөн бие махбодын буюу материаллаг хүчийг хөгжүүлэн хэрэглэж, дэлхийдээ зориулах нь хангалттай биш. Хүн төрөлхтөн илүү өндөр хөгжил, дөмөг сайн дэлхийг мөрөөдсөөр ирсэн ч чухам үүнээс л болж дэлхий маань эдүгээ ийм байдалд байгаа билээ. Дэлхийн маань амьдрал сайжран өөрчлөгдөж, ирээдүй үеийнхэн маань илүү таатай орчинд өсч торнихын төлөө бид дотооддоо байх энэ агуу их хүчийг аль болох түргэн эргэн нээх цаг нэгэнт болжээ. Хорвоо дэлхийн өнөөгийн золгүй байдлыг бид хараад зөвхөн өөрсдийн ашиг тус, өнөө үеийнхний ашиг тусын төлөө бус хойч үедээ хамгийн сайн сайхныг өвлүүлж үлдээхийн төлөө үтэр түргэн гэгээрэхийн зайлшгүй чухлыг бид улам ч сайн ухамсарлаж байна. Энэ бол жинхэнэ үйлч бүтээлч хайр мөн билээ.”[57]

## *Ирээдүй бидний гарт*

“Энэ дэлхийн мөхлийн тухайд хүн болгон л санаа зовдог. Зарим нь бүр дэлхийн мөхлийг зөгнөн хэлж олон түмнийг түгшээж байна. Гэхдээ дэлхий мөхлөө ч гэгээрсэн хүмүүст тэвдэх шалтгаан үгүй, учир нь тэд ертөнц гэж юу болохыг мэддэг, мөн нэг л өдөр энэ үгүй болно, харин мөнх амьдрал бол хэзээд үргэлжилж, түүнд юу ч нөлөөлж чадахгүй гэдгийг мэддэг. Мөнх амьдрал гэдэг бид өөрсдөө юм, билгүүн ухаан гэдэг бидэнд буй юм, хайр бол бидний уг чанар юм, үүнийг ямар ч хөнөөгч бөмбөгөөр яагаад ч огт сүйтгэх аргагүй юм. Энэ бол орон зай, цаг хугацаагаар хязгаарлагдашгүй. Тийм болохоор Багш нар орон зай, цаг хугацаанаас үл хамааран шавь нартаа авшиг хүртээдэг юм. Багш нь шавь нарынхаа байгаа газарт байнга байх шаардлагагүй, гэхдээ тэд шавь нартаа тусалж, адислаж чаддаг. Шавь нар нь багш

болохоороо бас тийн чаддаг болно.” [50]

“Зовлон гамшигт ихээхэн нэрвэгдсэн энэ цаг үед бид агуу их итгэл найдварыг ч бас өвөрлөсөөр байна. Учир нь Эзэн Бурхан манай дэлхий рүү олон гэгээнтнийг илгээгээд байгаа бөгөөд тэдний сургаал номлол нь бараг л адилхан байна. Тэд юуны түрүүн бид Бурханы Орныг эрж олох ёстой, тэгвэл бусад бүх юм жам ёсоороо болно гэж хэлж байна. Ер нь бол бид эхлээд ертөнцийн асуудлаа шийдвэрлэн, бүхнийг гартаа авч, орчлонг эзэгнэхийг оролдож байдаг. Гэвч бид байнга л сэтгэл гонсгор байна. Улс төрийн хамгийн шилдэг удирдагч байсан ч хүмүүсийн санааг түр зуур л амрааж, тэдэнд зөвхөн материаллаг тав тухыг л өгч чадна. Зөвхөн улс төрийн ур чадвар юм уу бусад авьяасаа хэрэглээд бид даян дэлхийг арчлан харгалзаж чадахгүй. Асуудал үүнд л байгаа юм. Хэчнээн сайхан санаа зорилго өвөрлөвч бид юуны түрүүнд дотооддоо орших тэр дээд хүч, Эзэн Бурханы Вант Улсыг эрж олох шаардлагатай, түүнтэйгээ бид холбоотой ч байдаг. Тиймээс *“Эзэн Бурхан хүнийг Өөрийнхөө дүр төрхөөр бүтээсэн“* гэж хэлдэг. Дүр төрх гэдэг нь бидний царай зүс, бие махбод юм уу амьдралын хэв маягийг хэлж байгаа юм биш. Бидний бүтсэн тэр үл үзэгдэх эрчим хүчний дүр төрхийг хэлж байгаа юм.” [47]

“Бид гэгээрчихсэн байсан ч энэхүү ертөнцийг өөрчлөн хувиргаж чадахгүй. Бид зөвхөн хүмүүсийг итгүүлэн үнэмшүүлж, өөрөө өөрсдийгөө өөрчлөхөд нь хөтлөн авчирч чадна. Тиймээс бид өөрсдөөсөө эхлэх учиртай юм. Бид ид шид тохиолдохыг хүлээгээд суугаад байж болохгүй. Ертөнцийг хэн ч өөрчилж чадахгүй, мянган Будда, сая Есүс байлаа ч чадахгүй. Чадах байсан бол тэд үүнийг аль хэдийн хийчих байсан. Үйлийн үр байгаа газарт ид шид ингэж тохиолддоггүй. Бид өөрсдийгөө ариусгах ёстой. Бид өөрсдийгөө цэвэршүүлэх ёстой. Хамгийн сайн эмч ч гэсэн бидэнд эм өгч л чадахаас биш өмнөөс маань эм уухгүй.” [27]

"Өөрсдийнхөө амьдралыг үргэлжлүүлэх гэж өрөөл бусдыг алж хөнөөж байхын оронд бид газар дэлхийгээ аварч хамгаалж чадна. Амьдралынхаа хэв маягийг өөрчилж, ёс суртахуунтай аж төрж, мацаг хоолтон болж, өөрсдийхөө бие сэтгэлийг хөгжүүлэх ёстой. Ингэсний үр дүн нь тэр дороо гарна. Хорвоо дэлхий маань хоромхон зуур өөрчлөгдөнө! Хэрвээ хүн бүр мод огтлохын оронд тарьж эхэлвэл бид төдөлгүй аврагдах болно. Арван жилийн дотор л дэлхий маань одоогийнхтой адил байхаа больж, ямар ч асуудалгүй болно. Гагцхүү бүгдээрээ хамтран ажиллах юм бол найдвар гарцаагүй бий.[63]

Тиймээс би ертөнцийн хүмүүсийг нойрноосоо үтэр түргэн сэрнэ байх гэж найдаж байна. Та бүхэн газар дэлхийгээ хамтран аврах хэрэгтэйг хүмүүст хэлээсэй, энэ мэдээг бүгдэд дамжуулаасай гэж би хүсч байна. Эс тэгвэл бид өөр юу хийх билээ? Бурханы оронд зөвхөн буянтай хүмүүс л сууж болно. Хэрвээ дэлхий ертөнц оршин тогтнохоо боливол, тийм ч өөдтэй биш хүмүүс бүгд хаа очих хэрэг вэ? Тийм учраас тусгүй улсын төлөө ч гэсэн бид бага сага зүтгэх ёстой болж байна. Энэ гариг дэлхий маань маш их үнэ цэнэтэй. Хэрэв Эзэн Бурхан энэ дэлхийг залхаан шийтгэж, эвдэн нураахыг хүсэх юм бол бид Түүний хүсэл зоригт захирагдахаас өөр юу ч хийж чадахгүй билээ. Гэхдээ Дэлхийг аварч болмоор бол бид түүнийг аврах ёстой. Яагаад гэвэл энэ дэлхий бол олон олон сүнс сурч хөгжихөөр ирж болох маш сайн сургууль юм."[63]

"Бид бол Эзэн Бурханы хамтран зүтгэгчид. Бид одоохондоо Эзэн Бурханы билгүүн ухаанд хүрч чадаагүй байгаа болохоор Түүний төсөл төлөвлөгөөг хүндлэх ёстой. Яагаад гэвэл тэр бол "Дээд Эзэн" юм. Юуг нь үлдээх, юуг нь зайлуулах, юуг нь засах хийгээд юуг нь нураахаа Тэр мэднэ. Тэр ямар нэг юм эвдэн сүйтгэсэн ч түүнийгээ дахин бүтээдэг; харин бид ямар нэгэн юмыг эвдэн сүйтгэчихвэл түүнийгээ дахин бүтээж чадахгүй. Учир начир нь үүнд байгаа юм. Бид хангалттай хүчтэй, хангалттай ухаантай биш учраас ийм юм

болж байгаа хэрэг. Хэрвээ бид хэзээ нэгэн цагт Бурханы хутагт хүрдэг юм бол тэр цагт л өөрийнхөө гараар эвдэх, бүтээх тухай ярьж болох магадгүй юм.“ [21]

“Эзэн Бурхан үнэндээ зөвхөн энх амгаланг л хайрлаж байдаг. Хэрэв энэ мөчид Тэр биднийг зовлон гамшигт учруулж буй бол тэр нь энэ ертөнцийн мөнх бусыг сануулах, аюул зовлонгүй цайз хэрэм болох Эзэн Бурханы Орон луу бид буцаж очих ёстой гэдгийг сануулахын тулд юм. Эзэн Бурханыг дахин мартах бүрт Тэр бидэнд сануулж байх болно. Бурхан эхлээд зөөлхөн сануулна. Хэрвээ бид энэ аядуу зөөлөн зөвлөгөөг нь сонсохгүй бол Тэр бидэнд хүчтэйхэн сануулна, тэгээд эцэст нь бүр маш хүчтэй шахаж шаардана. Иймд хэрэв та одоохондоо Бурханы шахалтанд их хүчтэй ороогүй байгаа бол Түүнийг хүчтэй шахалт үзүүлэхийг битгий хүлээгээрэй. Харин Тэр танд хүчтэй шахалт хэдийнээ үзүүлчихээд байгаа бол Бурханы Оронд түргэхэн эргэн ирж, тэнд Түүний хайрласан амар амгаланг эдлэн жаргаарай.” [7]

А. Зарим хүн энэ дэлхий рүү асар их гай зовлон ойртож байгаа, сая сая хүн үхэх нь гэдгийг харж байна хэмээдэг. Энэ үнэн үү? Та юу гэж бодож байна?

Б. Хэрвээ дэлхий дээр оршин суугчдын дийлэнх олонхи нь сэрэхгүй, дотоод дахь авралын хүчээ ашиглахгүй бол ийм юм бодитой болно. Эзэн Бурхан бидэнд амьдралыг аврагч хүчийг өгсөн боловч олонхи маань үүнийг ашиглахгүй байна. Үүссэн бүхэн цагаа болохоор устах нь мэдээж. Үүнийг сэргээн босгоход хүрэлцэхүйц бүтээлч хүчийг бид эзэмшихгүй юм бол энэ нь эвдэрч сүйрнэ. Яг л байшинтай адил. Байшин баригдчихсан байгаад, хэрэв бид түүнийг засч додомдохгүй бол, гэрт хэчнээн багаж зэвсэг, будаг, тоног төхөөрөмж байгаад, тэдгээрийг ашиглахгүй бол байшин маань аяндаа нурж сүйрэх болно. Гэхдээ байшин маань нурж сүйрсэн байсан ч бидэнд аваарын гарц бий. Хэрэв бид ийм гарц байдгийг мэдэхгүй, ашиглахгүй бол мэдээжийн хэрэг аюулд өртөнө. Тийм учраас би, хэрэв

хэрэг явдал иймдээ тулвал ядаж л өөрийгөө аврах энэ боломжийг та нарт санал болгох гэсэн юм. Гэвч хэчнээн хүн намайг сонсох бол? Энэ бол ямар нэг нөхцөл болзол шаардахгүй, маш энгийн зүйл. Та ердөө л суугаагаараа унтаж байгаа юм шиг биеэ сулруулан тайвшир, тэгмэгц танд эрч хүч бүхэн хүрээд ирнэ, өнгөрсөн ой санамжаас тань бүх мэдлэг ухаан хүрээд ирнэ, амьдралын бүх ур чадвар хүрээд ирнэ, тэгэхдээ энэ нь тун энгийн.

Гэтэл хэчнээн хүн үүнийг дагаж байгаа билээ дээ? Дэлхийн эцэс төгсгөлийн тухай та нар надаас үргэлж л асуух юм. Биднийг үхэхээр дэлхий ч ямар нэг хэлбэрээр төгсөнө. Тэгэхээр бид сүнсээ аваръя. Мөн энэ дэлхийгээ авармаар байвал өөрсдийн хүч, Дээд хүчээр хувь нэмэр оруулах ёстой юм. Бид энэ хүчээ өөрсдөдөө эргүүлж авч, хэргийг нь гаргах ёстой. Эс бөгөөс хэн тэгж чадах юм бэ? Сахиулсан тэнгэрүүдэд өөрсдийнх нь ертөнц, өөрсдийнх нь үүрэг бий. Есүс хаа нэгтээ, манай дэлхийгээс илүү дэвшилтэй өөр газарт ном тайлж байгаа. Бурхан Багш өөрийнхөө ажил хэргээр Бурхадын орон луугаа явчихсан. Энд зөвхөн бид л өөрсдийгөө аврахаар байж байна. Хэрвээ та бүхэн сүйрлээс айж байгаа бол гэгээрч, орон байшингаа засч, дэлхий ертөнцөө илүүхэн ёс суртахуунтай, илүүхэн гэгээрсэн гариг болгон сэргээгтүн. Ингэвэл бидэнд ямар ч сүйрэл мөхөл тохиолдохгүй. Эс бөгөөс, ирээдүйн тухай би юу ч мэдэхгүй байлаа ч “Тийм ээ, юу ч тохиолдож мэднэ” гэж хэлнэ. Хэрвээ дэлхий маань дээр нь амьдрах аргагүй, тэгтлээ үжирсэн, танаггүй газар болж байвал Эзэн Бурхан түүнийг эвдэж нураагаад шинийг бүтээх болно.”[47]

А Зөрчилт нийгэмд амьдарч байгаа гэгээрсэн хүн нь тэрхүү зөрчлийг арилгахад хэрхэн туслах боломжтой вэ?

Б. Энэ бол маш хэцүү. Бид гагцхүү өөрийнхөө дотоодод байгаа зөрчлийг л арилгаж чадна. Хүн болгон тэгчихвэл, нийгэмд арилгаад байх зөрчил байхгүй болно. Тийм ч учраас Есүс, Бурхан хоёр тийм агуу их байсан атлаа

өөрсдийн хил хязгаар доторхи зөрчлийг арилгаж чадаагүй, зарим үед өөрсдийнх нь амьдралд ч гай зовлон тохиолдож байсан. Энэ нь дэлхийн хүмүүсийн олонхи нь гэгээрч сэхээрээгүй, амар амгалан бус байснаас болсон юм. Тийм учраас гэгээрэл бол энэ ертөнцийн бүхий л өвчин эмгэг, дайн тулаан, зөрчил тэмцэлд хэрэгтэй цорын ганц зүйл мөн, өөр юу ч хэрэггүй.[51]

А. Багш аа, халдлага түрэмгийлэлд өртөж, дайнд нэрвэгдсэн улс орон, зовлон хүчирхийлэл амсаж байгаа хүүхэд, эмэгтэйчүүдийг харахаараа би ямар байр суурь баримтлахаа мэдэхгүй болчихдог. Та ямар нэг зөвлөгөө өгнө үү?

Б. Таны энэ асуултыг бусдад анхаарал халамжтай олон хүн тавьдаг. Хэрэв хүмүүс өөрөө өөрсдийгөө л эмчлэхгүй юм бол өөр ямар ч эмчилгээ байхгүй. Та бүхэн үйлийн үрийн хуулийг мэднэ. Та алуурчдыг зайлуулж, эмэгтэйчүүдийг хамгаалахад амжилт оллоо гээд бодъё. Гэвч та бүх дэлхий даяар ингэж хэрхэн чадах вэ? Бас зарим үед гэм буруугүй хүн нь тийм ч цэвэр ариун биш, алуурчин нь цорын ганц хариуцлага үүрэх этгээд биш байж болно. Нийгэм бүхлээрээ, дэлхий даяараа хариуцлага хүлээнэ. Тийм болохоор бид хэрхэн яаж чадах билээ? Та тэр нэг хүнийг шоронд суулгаж болно, гэтэл өөр хүн гараад ирнэ. Хэрвээ хүмүүс өөрчлөгдөхийг хүсэхгүй л юм бол бид дэлхийг өөрчилж чадахгүй. Гэхдээ бид оролдоод үзэх ёстой.

Тийм ч учраас Багш нар хүмүүст өөрсдийгөө өөрчил гэж хэлэн, амь насаараа дэнчин тавьж хэрэн явдаг юм. Тэгэхээр та тэнд харамсаж халаглан суухын оронд бас нэгэн дэнлүү асааж, тэдэнтэй нэгдэн нийлж яагаад болохгүй гэж? Ямар нэг юм хийгээч. Та арвыг аварч мэднэ, харин өөр хүн хорийг аварч магад. Ингэж бид бага багаар даян дэлхийг аварч чадах юм. Амьдралын хэвшлээ хэрхэн өөрчлөхийг нийгэмд зааж хэлэхээс өөрөөр хүмүүсийг өөрчлөх ондоо арга байхгүй. Зөвхөн хохирогчийг нь төдийгүй нийгмийг бүхэлд нь өөрчлөх хэрэгтэй. Бид зовлон гамшгийг бүхэлд нь зогсоож чадахгүй юм гэхэд ядахдаа зарим хэсгийг нь

зогсоож чадна; энэ бол хэдийнээ том ололт мөн. [25]

А. Таны бодлоор энэ гариг дээр яавал энх амгалан тогтож болох вэ?

Б. Хэрвээ хүн бүхэн өөрийн Бурхан чанартаа эргэж хандан; зөвхөн буян хийж, сайхныг бодож, сайныг яривал тэр цагт энх амгалан болно. Өөр шийдэл байхгүй. Өөр ямар ч амьтан танд амар тайвныг өгч чадахгүй. Бид өөрсдийгөө амарлингуй аясаар хөглөж, амгалан амьдарч, амар тайвны үлгэр дуурайл болох ёстой. Бид дэлхий дээр энх амгалангийн амьд дүр болбол энх тайвныг хэрхэн тогтоох тухай ярих хэрэгцээ цаашид байхгүй болно. [24]

## *Газар дэлхийн хайраас хальж гарахуй*

“Дэлхий маань заримдаа тэвчихийн аргагүй болчихдог. Энэ биднээс өөрсдөөс маань л болдог. Тэгэхээр одоо энэ байдлыг сайжруулах, дэлхий гэрээ, тасалгаа бүр нь үндэстэн ястан болдог энэ олон өрөө байраа засахын тулд, хорон муугаас зайлсхийж болдог юм шүү гэдгийг бид мэдэх ёстой. Сайн үйл хийж, сахил сахиж, хөрш олноо хайрласнаар хорон муугаас зайлж болно. Гэвч бидний сэтгэл *“амийг амиар, цусыг цусаар“* гэдэг зарчимд дэндүү дасчихсан тул, хийх ёстой гэж боддог зүйлээ хийж, бусдад маш элгэмсэг дотно хандахад хэцүү байдаг. Тиймээс сэтгэж үйлдэх дадал зуршлаас маань татан гаргаж туслах бүр илүү хүч бидэнд хэрэгтэй болдог юм.

Чухамдаа бол энэ ертөнцийн бүх юмс, тэр бүү хэл хорон муу тал нь ч бидэнд тустай сайн гэж хэлж болно. Хорон муу зүйл бол бидний алдаа. За, тийм юм байж. Гэтэл тэглээ гээд бид алдаатайгаа мөнхөд зууралдах албагүй. Яах вэ, алдаа биднийг ядаж л цочролд оруулах юм даа. Алдааныхаа горыг амсахаараа бид зүй зохистой зүйл хийгээгүйгээ ухаарч цочирно. Тэгээд гутарч зовно. Түүнээсээ болоод ч бид эргэцгээдэг. Түүнчлэн энэ дэлхий дээрх сайн сайхан, баяр баясгалан бүхэн ч гэсэн дотоодод маань, жинхэнэ гэрт маань

үнэн аз жаргал байдгийг сануулахын тулд л байдаг юм шүү дээ.

Тиймээс Эзэн Бурхан бидэнд зориулан бүтээсэн зүйлсийг эдэлж цэнгэх нь нүгэл биш. Харин эдгээр зүйлст цаг үргэлж хэт их шунаад байх юм бол Эзэн Бурхан бидэнд энэ чинь зөв биш шүү гэж сануулна. Тийм ч учраас заримдаа бид хамгийн их хайрлан нандигнадаг зүйлээсээ болж гуниг, зовлонд унадаг.

Энэ дэлхийг үгүйсгэх нь буруу. Гэхдээ бас зөвхөн дэлхийн явдалд гүнзгий автаж живэх нь зөв биш. Учир нь ингэвэл бид энэ ертөнцийн өгч чадах аливаа бүхнээс хавьгүй их аз жаргал өгдөг, амьдралын нөгөө илүү сайхан хэсэг болох сүнс, оюун санааны талыг мартаж орхино. Энэ ертөнцөд байгаа бүх зүйл нь бидний мэдвэл зохих, олж авбал зохих жинхэнэ аз жаргал, жинхэнэ алдар, жинхэнэ амьдралын тухай сануулга төдий билээ. Учир нь бид үүнийг мартчихсан юм.

Олон хүн надаас эрэгтэй, эмэгтэй хүний хоорондын харилцаа, бэлгийн амьдралын ханамж зэргийн талаар асуудаг юм. Энэ нь нүгэл үү гэж асуудаг. Би “Нүгэл биш ээ” гэдэг. Гэхдээ та бүхэн үүнээс ч илүү сайхан таашаал ханамж олон байдгийг мэдэх хэрэгтэй. Бэлгийн таашаал ханамж бол ердөө л та өөрөө өөртэйгээ нэгдэж, таны доторх эмсэг, эрсэг тал, дотоод дахь хоёр энерги нэгдэж нийлэх үеийн тэр жинхэнэ таашаал ханамжийн дуураймал төдий л юм. Эр, эм хүний хоорондох холбоо бол ердөө түүний дуураймал л юм.

Тэгэхээр, Эзэн Бурхан биднийг энэ ертөнцөд Бурханы Орныг сануулах ямар ч хэрэгсэлгүйгээр илгээсэнгүй. Гагцхүү бид энэ бүхэн нь зөвхөн сануулах зориулалттай зүйлс гэдгийг мартчихжээ. Бид жинхэнэ зүйлийг нь мартчихаад ердөө хуулбарт нь дурладаг. Чухам энэ л бидний амьдралыг аз жаргалгүй болгож байгаа юм. Бүр хуулбарынх нь ч хэргийг гаргаж бүрэн дүүрэн жаргаж чаддаггүй. Тиймээс эрэгтэй, эмэгтэй хүний хоорондын харилцаа тогтворгүй байх нь олонтаа, бэлгийн харилцаа нь тийм ч эрхэм ариун бус, бие биенээ нэг ч их хүндлэхгүй, харин заримдаа бүр доромжлол ч

болж, цөхрөл гутралаа тайлах хэрэгсэл мэт болдог байна. Тийм учраас хэрэв бид энэ амьдралдаа жинхэнээсээ жаргая гэж хүсч байгаа бол бидний мэддэг газар дэлхий дээрх амьдралаас түм буман хувь илүү сайхан тэр жинхэнэ амьдралаар амьдарч жаргах ёстой юм. Тэр чанагуухи амьдралыг мэдсэнээр бид энэ амьдралдаа ч бас жаргаж чадна." [50]

"Бясалгал хөөсөн олон хүн Багшгүй юм уу, эсхүүл авшиг хүртээгүй, зөв зүйтэй ойлголт аваагүй, эсхүүл бясалгалаа зөв зүйтэй хийж хараахан сураагүйгээсээ болоод бясалгагч болъё гэвэл бүхнийг хаяж, хүний аливаа харилцаа холбоонд хөндий хүйтэн хандах ёстой гэсэн буруу үзэл бодолтой байдаг. Энэ буруу шүү, буруу. Тийм учраас Лууз "Дао Те Чинг" номдоо "Ердийн санаа бол Дао" гэсэн байдаг. Дао буюу гэгээрэлд хүрэх цагт та хэдий чинээ их гэгээрсэн байна төдий чинээ амгалан, төдий чинээ энэрэнгүй болно. Хүнтэй бие махбодын харилцаатай байх шаардлагагүй болж болох авч, байдгаараа л байж, үүргээ биелүүлнэ. Гэхдээ үүнийг ойлгоход амаргүй байгаа л даа. Гэвч цаг нь болохоор та ойлгоно. Эзэн Бурхан биднийг эхнэр нөхрөө дассан сурснаараа энхрийлж хайрлахыг хориглохоор тийм явцуу санаатай биш.

Эзэн Бурхан Өөр дээрээ хүрч ирүүлэхийн тулд хайртай хосуудыг хагацаан салгахаар тийм хатуу харгис ч биш. Бид Эзэн Бурханыг хайрлахын тулд зүрх сэтгэлээ уужим болгож, бас хамаг амьтан түүний дотор гэр бүлийнхнээ багтаах ёстой. Хэрэв бид өөрсдөөсөө хол хөндий, үл таних бусад төрөлтнүүдийг хайрлаж чадаж байгаа бол яагаад хамгийн ойр дотнын, гэр бүлийнхээ хүмүүсийг хайрлаж болохгүй байх билээ? Гагцхүү байгаагаараа байж, урьд өмнөхөөсөө улам илүү хайрлагтун, тэгэх юм бол гэр бүлийнхээ эв зохицлыг хадгалж чадна. Эс бөгөөс, хань ижил тань аз жаргалгүй байхад өөрөө аз жаргалтай байна гэдэг хэцүү.

Үнэндээ эрэгтэй, эмэгтэйчүүд гэрлэхдээ зөвхөн бие махбодын талаар ойр дотно байхын тулд бус харин хайр халамжийн төлөө гэрлэдэг, тийм болохоор та нар бясалгалаас

болж ямар ч шалтгаар нэгнийгээ гаргуунд нь хаях ёсгүй. Учир нь бусдад халамж, хайр гаргах нь та нарын үүрэг, та нар энэ үүргийг өөртөө хүлээсэн, тиймээс үүнийг хийх ёстой. Өрөөл бусдыг хайрлах нь хүндтэй хэрэг, ахиц дэвшил мөн болохоос ухарч унаж буй хэрэг биш. Ойлгож байна уу? Бие махбодын холбоо байсан ч байгаагүй ч, та нар нэг нэгнийгээ Багш та нарыг яаж хайрладаг, тэгж хайрлах ёстой." [37]

А. Дорно дахины олон шашинд бие махбодыг бараг хог новш мэт гаргуунд хаях ёстой гэж үзэх хандлага байдаг. Би энэ биед төрөл авахдаа энэ ертөнцөд амьдрах боломжоор нь хангахын тулд түүнийг чадлын хэрээр арчилж тордох үүрэг хүлээсэн мэт санагддаг. Хүнд сэтгэлийн хүч ба Бурханлаг хүч байдаг. Бид нэгэнтээ хоёр ертөнцийн аль алинд нь амьдарч байгаагаас хойш, хаа хаана нь аятай байхыг чармайх тэнцвэртэй хандлага гэмээр зүйл шаардлагатай бус уу?

Б. Тийм ээ, тийм байх ёстой. Бүр илүү тэнцвэртэй болох учиртай. Шашны ном судварт өгүүлсэн зүйл бол бид бие махбодынхоо хүсэл, мэдрэмжид хэт автаад сүнсээ мартах ёсгүй гэдгийг л хэлж байгаа юм. Заримдаа энэ нь зөвхөн тухайн үеийн хэн нэгэн хүн юм уу, хэсэг хүмүүс, өөрөөр хэлвэл ийм үг сонсвол зохих хүмүүст л зориулагдсан байдаг. Сүүлдээ энэ нь нийтлэг заавар болж хувираад утга санаа нь алдагдсан хэрэг. Хэлсэн тэр үедээ энэ нь тун хүчтэй, үнэн зөв зүйл байжээ. Гэвч дараа нь бичиж тэмдэглэгдэн, өөр хэсэг хүмүүст дамжин өгөгдөж, зөвөө больсон байна. Тийм болохоор юу хиймээр байна түүнийгээ хий, гэхдээ бие махбодын хүсэл шуналдаа хэт автах хэрэггүй. Бие махбодоо хэн яаж мартах вэ? Биеэ өлсгөж хаяад бясалгалаа хийнэ гэж байхгүй. Биеэ хайрлаж додомдох ёстой, гэхдээ цаг үргэлж махбодынхоо тухайд санаа тавиад сүнсэндээ цаг гаргахгүй байж болохгүй. Зарим хүмүүс тэгдэг, тиймээс энэ заалт тэдэнд л хамаарна. Есүс мөн адил сүнснийхээ төлөө бие махбодыг хаях хэрэгтэй гэж хэлсэн. Гэвч Тэрбээр шаардагдах хэмжээнд биедээ санаа тавьж, хооллож байсан билээ. [30]

А. Би бие махбодоосоо болон эсрэг хүйсийн хүнийг хүсэх, хайрлахаас яаж зайлсхийх вэ?

Б. Үүнээс зугтах хэрэггүй, эс бөгөөс бид ерөөсөө хүүхэдгүй болно шүү. Зүгээр тайван байж, нэг л хүнтэй харьцаж бай. (Инээлдэв) Ганц л хүнтэй бай, за юу? Хэрэв өөрт тань нийцсэн заяаны хань байдаг, бие махбод, сэтгэл санаа, оюун ухааны гурван хэмжээст хайр байгаа бол сайхан хэрэг. Хэрвээ та гэрлэлт юм уу, тогтвортой харилцаагаар махбодын хүслэн гэгчийг зохицуулаад байвал тэр чинь сүүлдээ танд тийм их хүчтэй нөлөөлөхөө больчихно. Тиймээс санаа зовох хэрэггүй, эхэн үедээ л ийм байдаг юм.[51]

А. Гэгээрэлд хүрэхийн тулд бэлгийн эрч хүчтэйгээ тэмцэх буюу энэ талаар ямар нэг арга хэмжээ авах ёстой юу?

Б. Үгүй, үгүй, та зүгээр л тайван бай. (Инээлдэв) Бэлгийн хэрэгцээтэйгээ тэмцэхэд зарцуулдаг тэр бүх хүчээ бясалгал хийхэд ашиглавал дээр. Биеэ тэгж тамлаад яах юм бэ? Энэ бол байгалийн жам ёсны үзэгдэл бөгөөд цаг хугацаа өнгөрөхийн хэрээр эрч хүч нь суларна. Гэрлэчихсэн хүний хувьд бүх зүйл, бүр хүсэл тачаал чинь ч хүртэл ихэд багасна. Хэдий чинээ их бясалгана, тэнгэрлэг жаргалыг төдий чинээ их мэдэрнэ. Бэлгийн харьцаа бол тэнгэрлэг жаргалыг ердөө л орлох төдий зүйл. Бидний олонхи нь жинхэнэ таашаалыг мэдэхгүй болохоороо түүнийг доогуур зүйлээр орлуулдаг юм. Гэхдээ бид жинхэнийг нь нэгэнтээ мэдвэл орлуурт нь татагдахгүй. Хүүхдүүд өсч том болмогц хамаг тоглоом, хуванцар машины загварууд нь тэдний хувьд асар их ач холбогдолтой байхаа больдогтой л адил. Яагаад гэвэл тэдэнд одоо Мерседес, Роллс-ройс, Кадиллак ч юм уу эсвэл аль нэг жинхэнэ машин байна. Тэд машинаа илүү хурдан бас хэрэгцээтэй гэдгийг мэднэ. Тийм болохоор бэлгийн харьцааны асуудлыг бодож санаа зовох хэрэггүй, ердөө гэгээрэлд л хүр.

Гэгээрсний дараа хамаг юмнаасаа салчихна гэж санаа зовох хэрэггүй. Харин ч эсрэгээр бүх юманд бүр хүчтэй цэнгэнэ; гэхдээ хэзээ, яаж гэдгээ мэддэг болж, цэнгэл жаргалын хүчийг гэгээрэхээс өмнө байсан шигээ хэтрүүлдгээ болино. Хэрэв та хүсч, таашааж байгаа бол хэзээ ч гэсэн бэлгийн харьцаанд орж болно. Гэхдээ таны амьдралын гол зорилго бол гэгээрэл бөгөөд авшиг хүртсэний дараа гэгээрэл танаас яасан ч холдохгүй. Гэгээрэл таныг үргэлж шахан шавдуулж, та урагшлахгүй байж ердөө чадахгүй, эргээд мунхаг болж чадахгүй болно. Хэрэв та эхнэртэйгээ хааяа жаахан дасгал хийжээ гэхэд үүнээс юу болчих юм бэ? Бурхан энэ талаар нэг их санаа зовнихгүй шүү! (Инээлдэв) Та юм болгоноос дэндүү их айж байна. Нэг жаахан бэлгийн харьцаа ч таныг айлгаж байдаг. Тийм аймаар юм огт байхгүй шүү дээ! [53]

А. Үр хөндүүлэхийг та юу гэж үздэг вэ, сүнс хэдийд биед ордог гэж та бодож байна?

Б. Өө, хүмүүс үр хөндүүлэх ёсгүй. Сүнс биед хэдийд ордог вэ гэдэгт асуудал байгаа юм биш, энэ бол хорон санаа, амь хөнөөх хандлагын тухай л асуудал юм. Ойлгож байна уу? Бид иймэрхүү амь хөнөөх хандлагаас татгалзах ёстой. Сүнс биед хэдийд ордгийг надаас асуухын хэрэг байхгүй. Үр хөндүүлэхийг хүсч байна гэдэг чинь та амь таслахад бэлэн байна гэсэн үг. Үүнийг л бид ор үндсээр нь үгүй хийх хэрэгтэй. Бид нигүүлсэх сэтгэл болон билиг ухаанаа хөгжүүлж, төрөлх чанарынхаа сөрөг талд дийлдэхгүй байвал зохино. Сөрөг талдаа бид хэдий чинээ автана, төдий чинээ доройтож, бид төдий чинээ их уруугаа татагдах болно. Та бясалгал хийж сурах хэрэгтэй, тэгвэл сүнс хэдийд эхийн хэвлийд ордгийг ч бас хэзээ нэгэн цагт мэдэх болно. Үүнд тодорхой цаг хугацаа байдаггүй, орох цагтаа л орно! Сүнс гараад явчихаж болно, тэгээд дахин эргээд ирдэг! Тиймээс тэнд сүнс байна уу, үгүй юү гэдгийг хэзээ ч мэдэх аргагүй. Тэнд одоохондоо сүнс байхгүй байлаа ч гэсэн ялгаагүй бидэнд алах, өөрийнхөө мах цусны тасархайг хөнөөх эрмэлзэл байна шүү дээ, энэ чинь олигтой хэрэг

биш. Хэрэв та дайснаа юм уу махчин араатныг алсан бол танд юутай ч гэсэн өөрийгөө хамгаалсан гэх мэт шалтаг байхсан. Гэтэл та ямар ч гэмгүй сүнсийг хөнөөх тухайд асуух ч хэрэггүй... гэмгүй амьтныг алах нь сайн хэрэг биш. Өөрийгөө дорд муу болгох ийм юм бүү бодож үзээрэй. Нөхцөл байдал хэчнээн муу байлаа ч гэсэн та дөнгөөд аргалж чадна. Бурханд мөргөж залбир, хүүхдээ өнчин хүүхэд асрах газар өгөх ч юм уу, өөр шийдэл ол. Дэлхийд хүүхэд хүсч буй гэр бүл, хосууд олон бий, тэд хүүхэд үрчилж авна. Тиймээс ийм юм битгий бод. [13]

А. Нэгэн зэрэг төгс бурханлаг, төгс хүмүүнлэг чанартай байж болох уу?

Б. Болно, төгс бурханлаг хүн гэдэг бол төгс хүмүүнлэг хүн. Төгс хүмүүнлэг хүн гэдэг бол төгс бурханлаг хүн мөн. Одоо бол бид зөвхөн хагас дутуу хүн төдий байгаа юм. Бид юмыг эргэлзэх сэтгэлээр биеэ дөвийлгөн байж хийдэг ба эдэлж буй жаргал, мэдэрч буй бүхнийгээ Эзэн Бурхан зохицуулж байдаг гэдэгт бид итгэдэггүй. Бид буян нүглийг ялгаж заагладаг. Юухныг ч гэсэн их юм болгон дөвийлгөж, өөрийгөө болон бусдыг түүгээрээ шүүн дүгнэж, тэгснээрээ Эзэн Бурханы юу хийх ёстойг явцуугаар ойлгон зовж шаналдаг.

Үнэндээ Эзэн Бурхан бидний дотор оршиж, харин бид Түүнийг хорьж хязгаарлаж байдаг юм. Өөрсдөө бид цэнгэж жаргах дуртай ч түүнийгээ мэддэггүй. Тэгээд өөртөө “Би ингэх ёсгүй” гэж хэлдэг. Гэхдээ мацаг хоолтон болохын учир юу вэ? Бидний дотоодын Бурхан үүнийг хүсч байгаа учраас л тэр юм. Мацаг хоолтон бус байх нь бидний өөрсдөө хөнөөгдөхийг үл хүсдэг зарчмын эсрэг зүйл юм. Бид өөрсдийгөө алуулахыг хүсэхгүй, эд юмаа хулгайд алдахыг хүсэхгүй шүү дээ. Хэрэв бид бусдын эсрэг тийм зүйлсийг хийж байгаа бол энэ нь өөрсдийнхөө эсрэг хийж байгаа хэрэг мөн бөгөөд ингэх нь биднийг зовлон шаналалд унагадаг. Жишээлбэл, хүн өөрийгөө өлсгөж харангадуулах юм уу эсвэл зодож цохих ёсгүй. Алж хөнөөхийн тухайд ч

мөн адил. Бид хэрхэвч амь хөнөөх ёсгүй, яагаад гэвэл энэ нь амьдралын хууль зарчимд харшилна, мөн биднийг зовоож шаналгах учраас бид ингэх хэрэггүй. Ингэснээрээ бид өөрийгөө хорьж, хязгаарлаж байгаа юм биш. Энэ бол бид амьдралаа зөвхөн хүмүүс төдийгүй амьтад ба амьдралын бүх төрөл хэлбэр хүртэл өргөжүүлэн тэлж байна гэсэн үг. Бидний амьдрал зөвхөн энэ биеэр хязгаарлагдахгүй болж, харин хамаг амьтан, бүхий л амьд юмсыг хамарч өргөжнө. Ингэснээр бид агуу их болж, сүр жавхлангаа эргүүлэн олж авна. [30]

## *Бурханлаг хайр*

Хайр юм бүхнийг угаан ариусгаж, муу бүхнийг эвдэн нурааж, хил хязгаар бүгдийг уусган сарниулдаг. Есүс шавь нарынхаа нүгэл хилэнцийг чухам хайраараа л ингэж цайруулсан билээ. Газар дэлхийд оршин байхдаа Тэрбээр энэ хайрыг биедээ тээж явсан юм. Будда амьд ахуйдаа, биднийг тэр хайрыг эдлэн жаргаг гэж бид Түүний нэгэн адил хайрлаж, хайраа хөгжүүлж, хайраа эргэн чөлөөлөхийн тулд бүх л саад хаалтыг таньж давж сураг гэж энэ хайрыг тээж явсан билээ. Тэд ийнхүү үлгэр дууриайл үзүүлсэн.

Тийм ч учраас хүмүүс Багш нарыг хайрладаг. Багш нарт хайраас өөр юу ч байхгүй, тэд залуухан биш, сайхан биш байж болно. Багш заавал ийм тийм маягийн хүн байх ёстой гэдэг бол утгагүй зүйл. Багш тань бөгтөр нуруутай ч байсан бөгтөрхөн биедээ тээж яваа хайр нь төгс төгөлдөр л байх болно. Хүмүүс энэ хайранд нь л татагддаг юм. Учир нь хүмүүс бид энэ хайрыг дотроо агуулж байдаг. Тэгээд тэр хайртайгаа адил зүйлийг асар их буйг олж харахаараа түүнд шумбан ариусахыг хүсдэг! Хэрэв та энэ эрдэм ухааны авшгийг хүртвэл өөрийнхөө хязгааргүй хайрыг таньж мэдэх болно. Хэрэв та чармайн бясалгаж, итгэл бишрэлтэй байх юм бол Эзэн Бурханы хүсэл зориг, тус дэмээр Есүст байсантай адил тэр хайрыг олж аван, Түүн шиг болно. Та өндөр өсгийт, охорхон банзалтай Есүс болж чадна." [30]

Есүс заларч ирээд, бид дэргэдэх хүмүүсээ хайрлах ёстой, дайснаа бол түүнээс ч илүүтэй хайрлах ёстой гэж сургасан билээ. Будда, Мухамед, Сократ, Лууз бүгд л адилхан зүйлийг сургаж номлосон. Би ч мөн адил, бусдыг хайрлаж чадахын тулд дотроо байгаа энэ агуу их хайраа хэрхэн хөгжүүлэхийг заасан эртний энэ л сургаалыг та бүхэнд сануулах гэж энэ улсад хүрэлцэн ирсэн юм.

Энэ хайр үл үзэгдэх хэдий ч бидэнд мэдрэгдэж, бид үүнийг хүссэнийхээ хэрээр хэрэглэж болохоор тийм агуу их юм. Энэ агуу их дотоод хүчийг яагаад хайр гэж нэрлэдэг вэ? Яагаад гэвэл энэ хайр хамаг л нүгэл хилэнцийг маань уучлан өршөөж, угаан ариусгадаг юм. Бид урьд өмнө нь ямар муу хэрэг хийсэн нь хамаагүй. Бид энэ хайртай холбогдож, энэ хайрыг мэдрэх л юм бол нялх хүүхэд мэт ариусдаг. Тийм учраас л үүнийг хайр гэж нэрлэдэг юм. Хайранд нүгэл хилэнц, зааг хязгаар, өнгөрч улирсан гэж үгүй, зөвхөн одоо л гэж бий. Есүс энэ хайрын хүчээр шавь нарынхаа нүглийг цайруулсан. Будда энэ л хайрын хүчээр хүмүүсийг Бурханы оронд нь буцааж хүргэсэн. Энэтхэгийн Кришна энэ л хайрыг тээж байсан болохоороо энэтхэгчүүдийн хайр бахархлыг хүлээсэн хэвээр байгаа билээ.” [9]

А. Хайрын тухай, хүн болохынхоо хувьд хайрыг энд буулгаж ирэх бидний чадавхийн тухайд та юу хэлэх вэ?

Б. Бурханлаг хайр, жинхэнэ хайрыг уу? Бид Эзэн Бурханыг мэдэхгүй л бол чадахгүй. Бурхан яаж хайрладаг шиг бид тэгж хайрлавал л зөвхөн жинхэнэ хайр болно. Тийм биш бол энэ нь тэр хайрын нэг хэсэг л төдий юм. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хооронд Бурханлаг хайрын нэг хэсэг буй болсноор тэднийг холбож, аз жаргалтай болгодог. Бурханлаг хайрын хэсэг эх, хүүхэд хоёрын хооронд үүссэнээр тэдэнд маш онцгой элгэмсэг холбоог мэдрүүлдэг. Үүнтэй адилаар энэ хайрын хэсэг нь хүмүүн ба хүмүүн бус, аливаа амьтдын хооронд үүссэнээр тэднийг холбож, аз жаргал хайрладаг. Энэ хайр тэр чигтээ бүхлээрээ ертөнц даяар цацран тархаж байгааг төсөөлөөд үз дээ? Тийм учраас хүмүүс Багшаар дамжин цацарч

байгаа ийм Бурханлаг хайрын дэргэд амар амарлингуйг мэдэрдэг юм.

Хүмүүс эрт цагаас ийм Багш нарыг шүтэж ирсний учир энэ юм. Цааз шийтгэлээс үл эмээн хүн бүр Есүсийг дагаж байсны учир энэ юм. Бүгдээрээ Бурхан багшийг бишрэн хайрлаж байсны шалтгаан энэ юм. Түүний хайрыг бүхэлд нь мэдэрч чадахуйц өндөр дэстэй хүмүүс хайранд нь умбан жаргаж, орхиж явахыг хүсдэггүй байсан билээ. Буддаг харах бүртээ тэд Түүнээс харцаа ч салгаж чаддаггүй байжээ. Энэ нь хүн бүрийн дотор байдаг тэр хайраас болсон хэрэг, харин бидний үзэл бодол энэ хайрыг хаан хавчиж байдаг. Бид бүх үзэл бодлоосоо салчих юм бол тэр хайр өсөн цэцэглэх болно.

Бидэнд "Би" үгүй болмогц бид Есүс юм уу Будда шиг тийм их энэрэнгүй болж, мянга мянган хүн бидэнд татагдаж, биднээс холдохыг хэзээ ч хүсэхгүй. Тэгэх зуураа тэдгээр хүмүүс өөрсдийнхөө хайрыг таньж мэдэх чадвараа хөгжүүлдэг юм, ойлгож байна уу? Эхлээд тэд зөвхөн Эзэн Бурханы хайраар тэднийг адислаж өгсөн хүнийг хайрлаж байдаг. Зөвхөн энэ хайрын улмаас л тэд Багшдаа хайртай байдаг. Төгс бүрэн энэ хайрыг Багш биедээ тээж байдаг юм. Гайхамшиг бүхэн ингэж бүтдэг, учир нь хайрын хууль бусад бүх хууль, түүний дотор үйлийн үрийн хуулийг ч даван туулж чаддаг. Тийм болохоор Багш хүн Өөрт нь итгэдэг хүн бүрийг чөлөөлж, бурхдын орныг бүхэлд нь нээж, тамын оронг бүхэлд нь эвдэж чаддаг билээ. [30]



1993, 1994 онуудад АНУ-ын засгийн газар Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайг "Дэлхийн Энх Тайвны Шагнал", "Дэлхийн Оюун Санааны Удирдагч" цолоор шагнаж АНУ-ын "Хүндэт Иргэн" болгон өргөмжилжээ. Мөн түүнчлэн АНУ-ын Хавай болон Төвийн баруун бүсийн 6 мужид 10-р сарын 25 болон 2-р сарын 22-ны өдрүүдийг "Чин Хайн Өдөр" болгон тунхаглажээ.





Их Багш маань бидэнд оюун санааны гэгээрэлд хүрэх замыг заан бэлэглэхийн зэрэгцээ Түүний хайр энэрлийнх нь илрэл болсон тусламж хувь нэмрээ дэлхийн өнцөг булан бүрт түгээн хүргэж байдаг юм. Тэрбээр хаа тусламж хэрэгтэй тэр газарт: ядуу буурай, өвчтэй, дорой, орон гэргүй, өнчирч хоцорсон хүмүүс болон аюул гамшиг, дайнд нэрвэгдэгсэд зэрэг зовж зүдэрсэн хэн бүхэнд тусламжийн гараа сунгадаг. Их Багшийн маань энэхүү амь бие хайргүй зүтгэл нь оюун санааны дадал бясалгалынхаа нэгэн хэсэг болгож дэлхий ертөнцөд тусыг бүтээж өрөөл бусдыг халамжлан энэрэх урам зоригийг бидэнд хайрлаж байдаг юм.

# Саадыг гэтлэхүй

Цаглашгүй Их Багш Чин Хайн тавьсан лекцээс

Саяхан нэг хүн надаас ‘‘Эзэн Бурхан тийм хүчирхэг байтлаа яагаад ийм их зовлон гамшгийг бүтээсэн юм бэ?’ гэж асуусан. Эзэн Бурхан зовлон гамшгийг бүтээгээгүй, хүмүүс бид өөрсдөө толгой мэдэж эд бүгдийг бүтээсэн юм. Эзэн Бурхан буу зэвсэг хийдэггүй. Эзэн Бурхан хэзээ ч атомын бөмбөг бүтээгээгүй. Бид л энэ бүгдийг өөрсдийн гараар бүтээсэн билээ. Тэгэхээр бид л ингэхээ больчихвол гай гамшиг гэж байхаа болино. Ингэхэд, ядуу хөрштэйгээ эд хөрөнгөө хуваалцахыг хүсдэггүй улс чинь бид өөрсдөө л шүү дээ. Үнэнийг дэлгэрүүлэхийн тулд болон, энэрэл нигүүлсэл, тэсвэр хатуужил, буянт үйл, хайрын тухай бусдад дуулгахын тулд хангалттай зүтгэхгүй байгаа улс чинь бид өөрсдөө л юм шүү дээ.”[12]

Эзэн Бурхан зөвхөн гоо сайхан зүйлийг л бүтээдэг. Биднийг харж байг гэж Эзэн Бурхан цэцэгсийг бүтээсэн. Биднийг дулаацуулж, манай дэлхийг гийгүүлж байг гэж Тэр

нарыг бүтээсэн. Ургацыг маань тэтгэх гэж бороог бүтээсэн. Эзэн Бурхан хэзээ ч эвдэн сүйтгэгч зүйлийг бүтээж байгаагүй. Гагцхүү бидний өөрсдийн үйл, сөрөг уур амьсгал л энэ бүх гай гамшгийг авчирдаг.” [12]

“Бид зовлонгийн шалтгааныг ойлгочихвол түүнийг өөрчилж болно. Бид ойлгохгүй байгаагаас л зовлон үргэлжилж байдаг. Үүнтэй адилаар, эмч онош тавиад өвчин юунаас болсныг мэдэж байвал өвчнийг анагааж чадна; гэхдээ хамгийн гол нь өвчтөн өөрөө урт удаан хугацааны туршид эрүүл байхын тулд амьдралын ямар хэв маяг баримтлахаа мэдэж байх ёстой. Бид бие махбодоо энх тунх байлгахын тулд эрүүл ахуйн дүрэм журмыг мэдэж байгуулштай. Олонхи өвчнөөс сэргийлж чадахын тулд ямар хоол идэж, ямар дасгал хийж байх ёстойгоо мэдэх хэрэгтэй. Оюун санааны хувьд эрүүл саруул байхын тулд бид Эзэн Бурханы хууль, Байгалийн хуулийг мэдэж байх учиртай. Бурханлаг билгүүн ухаантай эрүүл саруул байхын тулд бид үүнийг мэдэж байх ёстой юм. Учир нь Эзэн Бурхан хүнийг өөрийнхөө дүр төрхөөр бүтээсэн билээ.” [21]

“Бидэнд амьдралын тухай, гэгээрэл, шашин шүтлэгийн тухай, бид хэрхэн яаж амьдарвал зохих тухай, шашинсаг хүмүүс ямар байвал зохих, гэгээрсэн Багш яаж амьдарч, хувцаслаж, хоолож, тэр ч бүү хэл яаж ярих ёстойн тухайд урьдаас тогтсон олон үзэл баримтлал байдаг. Гэгээрэхээс өмнө ч, дараа нь ч надад бас ийм үзэл олон байсан. Гэгээрэхээс өмнө тийм үзэл их байсан нь мэдээж, харин бага сага гэгээрсний хойно энэ нь багасч, өдөр өдрөөр улам багассаар байна. Эзэн Бурхан намайг өдрөөс өдөрт улам хүлцэнгүй, Түүнийхээс өөрөөр бол өөрийн гэх үзэл бодол үлдэхгүй болтол минь даруу болгосон. Би гагцхүү Түүний хүсч байгаа зүйлийг л хийх ёстой. Та нарын нэгэн адил би алдаан дээрээ суралцахад хүрсэн юм.” [45]

Бид хэчнээн их зүйл мэдэх тусмаа төдий чинээ бага юм ойлгодог. Ертөнцийн ердийн мэдлэг хэт ихэдсэнээс болж бид жинхэнэ билгүүн ухааныг ойлгодоггүй. Зай завсаргүй амьдралын маань байдал энэ юм. Энэ улигт ертөнцөөс олж авсан докторын зэрэг, эрдэм ухаанаараа бид дэндүү бардамнаад өөрсдийгөө тэр бүхнээс хавьгүй дээгүүр гэдгээ мартчихдаг. Бидний хэтэрхий бардам байх нь яг үнэндээ өөрсдийгөө дорд үзэж байгаа хэрэг. Учир нь бид ингэхээргүй агуу улс билээ. Энэ ертөнцийн мэдлэг нь оюун санааны билгүүн чанарт хүрэхэд саад болохгүй нь мэдээжийн хэрэг боловч тэдгээр зүйлсийн хойноос хэт хөөцөлдөх нь бидэнд халгаатай.” [58]

“Оюун санааны хувьд өсч хэрсүүжихийнхээ хэрээр бид улам амарлингүй болж, бодол сэтгэл болоод амьдралыг үзэх үзэл маань улам уужим саруул болдог. Тиймээс ч хүмүүс бидэнд хандаж, юм асуущгаадаг юм. Би тэдний сэтгэлд нийцүүлэхийн тулд үргэлж чадах ядахаараа хичээж ирсэн. Гэтэл хэн хэний маань санаа зорилго хэчнээн сайхан байгаад ч зарим хүний хувьд хариултуудыг минь ойлгоход хэцүү байдаг. Энэ нь бид хязгаарлагдмал тархиа ашиглаж түүнээс гадна оршдог зүйлийг ойлгох гэж оролдож буйгаас болж байгаа юм. Тэдний асуултуудын олонхи нь надад ч гэсэн урьд өмнө тулгарч байсан тул бидэнд хандан ирж юм асууж байгаа хүмүүсийг би сайн ойлгож байна. Ер хэзээ ч хангалттай хариулт авч байгаагүй юм шиг тэдэнд санагдана. Бидний сэтгэл ийм л байдаг юм. Сэтгэл маань цаг үргэлж ийм сониуч болохоор бид үргэлж л сониучирхаж, илүү зан гаргаж байдаг. Сайн мууг ялгаж салгах чадваргүйгээсээ болж тархи маань өдөр бүр сайн муу гэхгүй үй олон мэдээллийг цуглуулж байдаг. Бүх төрлийн мэдээллийг хурааж өмчлөн өөрийн болгодог энэ сониуч тархинаас л бидний зовлон шаналал, сэтгэл хангалуун бус байдал, явцуу үзлийн ихэнх нь, мөн түүнчлэн өөрсдийгөө бусад хүн амьтнаас элдвээр ялгаварлаж тавих үзэл үүдэн гарна.

Тийм ч учраас бид уншиж, сонсож байгаа бүхэндээ болгоомжтой хандах хэрэгтэй. Учир нь хааяа алдаатай ч байж мэдэх бусдын үзэл бодол, гүн ухаан аль бүхнийг шилж сонгож байхгүй бол тархи толгойд маань гүн шингэчихээд өөрийнх маань болж хувирдаг. Тэгээд бид өөрөө л ингэж бодож байна, өөрөө л хүлээн зөвшөөрч байна гэж бодно. Гэтэл хожим нь бидэнд илүү ашиг тустай, илүү үнэн зөв мэдээлэлтэй учрахаараа түүнд эргэлзэх юм уу, үл хэрэгсэх болдог. Учир нь бид сүүлийнхтэй зөрчилдөж буй мэт санагдах тэр үзэл онолыг урьд өмнө нь аль хэдийнээ тархиндаа биччихсэн байдаг. Ингэхлээр юуг ч хүлээж авахдаа, эхлээд, эсвэл үгүй ядаж дараа нь, тэрхүү онол, сургаал, үзэл санаа нь өдөр тутмын амьдрал, оюун санааны дэвшилд маань ямар нэг өгөөж болох эсэхийг шалгаж нягтлах ёстой. Эс бөгөөс бид элдэв үзэл санаа, хэсэг бүлгүүд, сэтгэлгээний янз бүрийн тогтолцоонуудын дунд хүчрэлгүй зүдэрч тун ч их асуудалтай тулгарах болно.” [61]

“Хэрэв өөрсдийгөө угаасаа гайхалтай сайн гэж бодож байгаа бол сэтгэл маань хуурч байж ч мэднэ. Бидний сэтгэл өөрсдийгөө гайгүй сайн шүү хэмээн бодож, алдар нэр, сайшаал магтаал, хий мөрөөдөлд дурладаг. Нөгөөтэйгүүр, сэтгэл маань биднийг бас доройтуулах нь ч бий. Сэтгэл санаа биднийг гүн хямралд унагаж, өөрийгөө хэт дорд үзэх зуршилтай болгож, бидний сүр жавхланг дардаг.” [36]

“Заримдаа бид өөрсдийгөө бид л энэ ертөнцөд хийж бүтээдэг нь гэж бодчихоод хамаг хүнд хүчрийг мөрөн дээрээ үүрцгээдэг. Тийм л учраас бид заримдаа хүч чадлаа барчихаад юу ч хийж гүйцээж чаддаггүй билээ. Хэрвээ бид гэгээрээд, түүнийгээ ашиглах юм бол мэднэ. Хэрвээ бидний дотор хэдийнээ орших тэр хамгийн агуу хүчийг яаж хэрэглэхээ мэдчих юм бол, бид түүнээс л үүсч, түүн рүү л эргэн очиж, түүн дотор л амьдарч байгаа болохоор, төөрч будлих маань өдөр бүр улам улам багассаар зүрх сэтгэл маань ямар ч төөрөгдөлгүйгээр гагцхүү Дээрхийн хүсэл зоригийг биелүүлдэг болно. Есүс Христ бас энэ тухай *“Тиймээ, би хийдэг, гэхдээ Би биш, миний дотор орших Эцэг маань хийж байгаа юм”*

гэсэн билээ. Хинду шашинд ч мөн *"Би биш, харин Та"*-г байнга дурддаг. [45]

Гэгээрэхээс өмнө миний бодол санаа мэдээж хэрэг шүүмжлэмтгий байлаа. Мөн хүмүүс амьдралаа хэрхэн авч яваа тухайд миний санаанд нийцэх нийцэхгүй зүйлс байдаг байв. Хэдийгээр миний санааг зовоогоогүй, надад ямар ч хор учруулаагүй, ерөөс надтай огт хамаагүй байсан ч би энэ ертөнцийн олон олон юмны тухайд өөрийн гэсэн санал бодолтой байсан билээ. Тэр бүү хэл тэдгээр зүйлсийг шүүмжлэхийг оролдож, эсвэл засч залруулах ч гэдэг байлаа. Бидний амьдрал ингээд л завгүй байгаад байдаг юм шүү дээ. Ертөнцийг шүүмжилж, хүмүүсийг засах гэж оролдсоор бүр залхаж ядарсныхаа эцэст миний засч залруулбал зохих хүн нь ганцхан би өөрөө л юм байна, тэгвэл бусад бүх юм хэв журмандаа орчих юм байна гэдгийг ойлгосон. Бурхан бидэнд алдаан дээрээ сурах боломж олгож, бусдын болон өөрсдийн маань жишээгээр сургамж өгдөг. Тийм л болохоор надтай яваа хоёр гурван хүний ядаж нэг нь миний багш, эсхүл багш болж чадахуйц байдаг гэж эртний Хятад зүйр үг хэлдэг биз. Өнөөг хүртэл миний ойлгож мэдсэн үнэн бол энэ. Учир нь бусдын алдаа нь бас бидний дотоод дахь зарим ой дуртгалыг сэргээдэг. Тэдгээр нь бидний магадгүй урьд өмнө хийчихсэн бөгөөд хэзээ ч мартах ёсгүй тэр зүйлийг сануулж байдаг. Бид өөрсдийгөө сайжруулахын тулд эдгээр зүйлсээс суралцах учиртай бөгөөд харин бусдыг хэзээ ч шүүмжлэх ёсгүй." [45]

"Гэхдээ өөрсдийгөө өршөөж уучилж бай гэж хэлье. Өөрийгөө хэзээд уучилж өршөөж байгаарай. Юу ч хийсэн гэсэн Эзэн Бурханд зориулж даатгаад л орхичих, үр дүн нь ямар байна тийм л байг. Учир нь бид юутай ч энэ бие цогцос биш. Бид үйлдэл ч биш. Энэ ертөнц дээрх аль ч юмны бүтээгч нь бид биш. Бид бүтээгч нь байсан байлаа ч гэсэн бас л өөрсдийгөө уучилж өршөөх ёстой юм. Алдаа гаргах үедээ юм уу, уур хилэн эсвэл хааяа шунахай зан, тачаангүй хүсэл гэх мэт дадал зуршлаа барьж чадаагүй үедээ өөрийгөө өршөөж уучлах хэрэгтэй. Энэ бүхэн нь нөхцөл байдлаас урган гарч байдаг. Энэ бүхнийг хүсээд байдаг чинь бидний жинхэнэ Мөн

Чанар биш, жинхэнэ сүнс биш билээ. Тийм болохоор, хэрэв бид өөрсдөдөө уур хүрч байвал, сурсан зан, дадал зуршилдаа л уурлавал зохино. Эсвэл буруугаа нөхцөл байдалд өгөхөөс биш, Дээд Билгүүн Ухаан, Жинхэнэ Мөн Чанартаа өгөх ёсгүй. Яагаад гэвэл Жинхэнэ Мөн Чанар бол хэзээ ч андуурч, хэзээ алддаггүй юм." [60]

А. Амьдрал ба ойр орчмынхоо нөхцөл байдлаас чөлөөлөгдөхийг маш ихээр хүсч байгаа бид зовлон болоод сэтгэлийн хөдөлгөөн шаналлаас өөрсдийгөө хэрхэн яаж цагийг нь олж чөлөөлөх вэ? Сэтгэлийн уяатай хүмүүсээс болж үүнийг олж харахад хэцүү байна. Гэхдээ амьдралд биднээс гадна, мөн хаячихаж болохгүй хэн нэгний хайраас гадна илүү их утга учир бий гэдгийг бид мэдэж байгаа.

Б. Ердөө л өөрийгөө уучилж өршөөгөөд дахин нэг оролдоод үз. Бид зарим тодорхой нөхцөлд өөрсдийгөө хянаж чаддаг ч ихээхэн хүч чармайлт гаргах хэрэгтэй болдог, гэтэл заримдаа өөрийгөө хянахыг хүсдэггүй эсвэл хянаж чадахгүй болдог. Ямар ч тохиолдолд тухайн агшинд өөрт юу сайн байна, түүнийгээ л хий. Сэтгэлийн хөдөлгөөний тухайд нэг их санаа зовохын хэрэггүй. Энэ бол зөвхөн далайн гадаргуу дээрх давалгаа юм. Далай үүнд буруутай биш. Дэлхийн эргэлт, салхины аясаар давалгаа үүсдэг билээ. Тийм болохоор далай өөрийгөө цаг үргэлж буруутгаж, давалгаа үүсгэн завь онгоц болон хүмүүс тэргүүтэнд аюул бэрхшээл учрууулж байна гэж хэлж болохгүй. Далай өөрийгөө яаж ч чадахгүй. [60]

А. Муу бодлоос яаж ангижрах вэ?

Б. Тийм ээ, энэ амаргүй. Та угаас заяасан хүчээ ашиглавал зохино. Аръяабалын аргаар бясалгах хэрэгтэй, тэгвэл та аяндаа ариусна. Бидний хувьд энэ тийм хүчир бэрхшээлтэй зүйл байхаа больсон. Өөрсдийгөө угааж, ариусгахын тулд бид өдөр болгон гэрэл, аялгууг ашигладаг. Харин оюун санааны өдрийн тэмдэглэл гэж хяналт маягийн зүйл байдаг. Бие, хэл, сэтгэлээрээ өдрөөс өдөрт хэрхэн улам ариусч байгаагаа өдөр бүр шалгаж болно. Хэр ахицтай

буйгаа харна. [4]

А. Уур хилэн гэж юу юм, яагаад энэ бидний дотор буцалж байдаг юм бэ, түүнийг яаж гаргах вэ?

Б. Заримдаа уураа гадагш гаргах нь тустай. Эхнэр нөхөр, эцэг эх, үр хүүхдийн хооронд хааяа дарамттай хүнд байдал үүсдэг, бүгдээрээ хамтарч учрыг нь олсны дараа уур амьсгал ариусдаг. Ингэх нь бас ашиг тустай. Аяндаа болж байгаа юм болж л байг. Хэрэв та бүр уураа барьж чадахгүй, эсвэл бүрэн гүйцэд хянаж чадахгүй байгаа бол дотроо үзэн ядахгүй байхыг л хичээгээрэй. Юу мэдэрч байгаагаа аль болох аятайхан байдлаар илэрхийлчих. Учир нь уураа хэт барих нь заримдаа биед өвчин үүсгэнэ. Ер нь хамгийн сайн зүйл бол юунаас түрүүнд Бурханлаг буянтан байх хэрэгтэй, тэгвэл бүх уур, шунал, уяа хүлээс аажимдаа арилна.[50]

А. Айдсыг Та юу гэж тодорхойлох буюу тайлбарлах вэ?

Б. Айдас бол Эзэн Бурханд итгэхгүй байгаа хэрэг. Та Эзэн Бурхан аль ч газар, ямар ч нөхцөлд оршиж байдгийг үргэлж мэдэрдэг бол айж эмээх юмгүй. [23]

А. Би "Өөр"-ийгөө үгүйсгэхээс айх сэтгэлтэйгээ яаж тэмцэх вэ?

Б. Би өөрөө үүнийг яаж зохицуулснаа санахгүй юм байна. Өөрөө аяндаа алга болчихдог юм. Бурхантай өөрийгөө холбон нэгтгэснээр танд “өөрөө” гэх юм аяндаа байхгүй болно. “Өөрөө“ аажим аажмаар алга болно. Ийм л юм. Би түүнтэй ороолцолддоггүй. Түүнтэй орооцоолдох нь тун хэцүү, учир нь “өөрөө” гээд байгаа чинь маш том зүйл. Тийм болохоор Эзэн Бурхан л түүний учрыг олог. Манай бясалгалаар хичээллэвэл өөрийгөө мэдрэх нь улам улам бага болж, тэгээд та улам бүр аугаа болсоор байх болно. Бидэнд энэ ойлгогдохын аргагүй учраас энэ бол Эзэн Бурханы гажууд үнэн юм. [4]

А. Эрхэм Багш аа, би хүсээгүй алдаагаа ахин дахин гаргах юм. Дотоодод минь нэг нь сайн, нөгөө нь муу хоёр "би" байгааг мэдэрдэг. Үүнээс яаж салах вэ?

Б. Амьдралдаа та тэнцвэр зохистой байдлыг сурах хэрэгтэй байж мэдэх юм. Ер нь бид үргэлж хэтэрхий сайн байж чадахгүй. Халширч шантарна шүү! Циркэд утсан дээгүүр явагч яадаг билээ? Нэг ийшээ, нэг тийшээ алхах ёстой болдог. Санааг минь ойлгов уу? Тэр энэ тал уруу, тэр тал уруу ээлжлэн хэлбийж явах ёстой. Тэгэхгүй, зөвхөн энэ тал уруу хэлбийгээд байвал уначихна шүү дээ. Амьдралд хоёр тал байдгийн нэг нь эерэг, нөгөө нь сөрөг тал; нэг нь жаргал, нөгөө нь зовлон. Бид зарим үед нэг талаас нөгөө тал уруу хэлбийхээс өөр аргагүй. Байх л зүйл! Өөрийгөө уучил. Чадахаараа хичээ. Чадахгүй бол өөрийгөө уучил.[60]

А. Бидэнд яагаад ийм их азгүйдэл, бэрхшээл тохиолддог юм бэ? Эзэн Бурхан ингэж зохицуулсан юм уу?

Б. Үгүй. Энэ бол бид энэ ертөнцөд амьдардаг учраас тэр, энэ ертөнцөд үйлдэл, хариу үйлдэл гэж байдаг. Бид хувь хувьдаа шалтгаан үр дагаврыг бий болгодог. Мөн нийгэм, ойр орчны нөлөөнд автаж байдаг. Муу энергиэс хамаг л осол, сүйрэл, өвчин, гамшиг үүсдэг. Бидний муу бодол, муу үйл, муу үгнээс муу энерги гардаг. Бүх зүйл энергитэй байдаг. Тийм учраас бид үг хэл, үйл хөдлөл, бодол санаагаараа цэвэр ариун байх ёстой юм. Тийм болохоор л бид орчин тойрноо ариусгахын төлөө Таван Сахил сахих, мацаг хоол идэхийг санал болгож байгаа хэрэг.[56]

А. Хучин, хорт хавдар, золгүй явдлыг та юу гэж тайлбарлах вэ?

Б. Үйлийн үрийн хууль, шалтгаан ба үр дагавар: *“Юу тарина, түүнийгээ л хурааж авна”(6:7 Галацууд)*. Бид өнгөрсөн цаг үе рүүгээ тийм ч хол харж чаддаггүй. Тийм болохоороо л одоо цагийг буруутгадаг. Заримдаа бүх юм бидний буруугаас болдоггүй ч гэсэн шалтгаангүйгээр болдог юм ер байдаггүй юм. Энэ дэлхий маш гунигтай газар. Тиймээс бид гарц хайж олох хэрэгтэй. Зүйрлүүлвэл, та машинтайгаа үргэлж хурдны замаар давхиад тэр замаас гарах гарц олж чадахгүй бол шатахуун тань дуусч мэднэ, эсвэл хэн нэг нь таныг дайрч, осолд орж ч мэднэ.[56]

А. Хүмүүс бидний сэтгэл оюуны орон зайд халдвал чухам ямар үед үүнтэй эвлэрч, ямар үед хамгаалах ёстой вэ?

Б. Хүн бүр өөрийн бие махбодын орон зайтай байх эрхтэйн нэгэн адил сэтгэл оюуны орон зайтай байх эрхтэй. Бусдын сэтгэл оюуны орон зайд хэн ч халдах ёсгүй. Тэгсэн тохиолдолд үүнийг арилаач гэж чин сэтгэлээсээ гуй. Өөртөө туслуулахын тулд дотоод дахь Бурханлаг хүчнээсээ гуй. Өөрийнхөө шашны сүсэг бишрэлээр өөрийгөө хамгаал, гэхдээ хангалттай сайн сүжиглэж, зоригтой бай. Эс бөгөөс бид та бүхэнд сэтгэлийн авшиг өгч болно. Хамгийн агуу хүчийг ашиглавал юу ч зайлж одно. Бурхан байгаа газар буг галзуурч чадахгүй. [46]

А. Хүүхдүүдийг телевизор, мансууруулах бодис, залхуурал, ихэрхэг зан гэх мэт орчин үеийн амьдралын халдвараас хамгаалахын зэрэгцээ тэдний өөрсдийн сонгох эрх чөлөөг гээчийг нь хэрхэн хүндэтгэх вэ?

Б. Телевизийн хөтөлбөр, тэдний орчноос нь хамгийн сайныг нь сонгож өгч тусалж болно шүү дээ. Тэгвэл тэд телевиз үзэх эрх чөлөө байгаа ч гэсэн олиггүй хөтөлбөр сонгох эрх байхгүй гэсэн үг. Шилэлт сонголт хийхэд ухаан нь хүрэхгүй хүүхдүүдийн хувьд эрх чөлөө гэдэг тийм ч сайн зүйл биш. Тэднийг өсч том болохоор нь арай илүүхэн эрх чөлөө эдлүүлж болно. Гэхдээ хамгийн гол нь та өөрөө буянтай, сайн, сайхан хүн бол хүүхдүүддээ үлгэр дуурайл болно шүү дээ. [56]

А. Америкчуудад мансууруулах бодис яагаад ийм нөлөөтэй байна вэ?

Б. Үүнд ил болон далд олон шалтгаан бий. Нэг илэрхий шалтгаан бол америкчуудад материаллаг тав тух хангалттай байвч, тэд сэтгэлийн гүн гүнзгий ганцаардал мэдэрч байдаг явдал. Зарим газраар олон бээрийн зам туулахад ганц ч хүн тааралдахгүй байх нь бий. Эргэн тойронд ой мод, авто зам л үргэлжилнэ. Нүднээс далд ганц нэг байшин энд тэнд харагдах магадгүй, харин өөрөө бараг л элсэн

цөлд байгаа мэт, маш ганцаардмал санагдана. Хөрштэйгээ ер харилцдаггүй шахам болохоор юу хийх ёстойгоо ч мэдэхгүй. Цаг хугацаа зогсчихсон юм шиг санагдаж, та өөрийгөө ч яахаа мэдэхээ болино. Үхэл, амьдралын утга учрыг ойлгож ухаарах хүсэл зүрх сэтгэлийг нь шимшрүүлж, тэсэхийн аргагүй шаналахад, амьдралын бодит байдлыг мартагнуулж, түрхэн зуурын тайвшрал өгдөг мансууруулах бодис хэрэглэхэд хүрнэ. Архи уудаг, мансууруулах юм уу өөр хорт бодис хэрэглэдэг хүмүүс ийм л шалтгаанаас болоод үүнийг хэрэглэдэг. Тийм учраас мансууруулах бодис хэрэглэдэг хүмүүсийг би хэзээ ч буруутгадаггүй. Би гагцхүү тэдэнд туслахыг хүсдэг, тиймээс ч үүнийгээ шийдэх арга зам санал болгохоор энд ирсэн юм.

Хэрвээ та ганцаарддаг бол, хэрвээ таныг хариу нэхэлгүйгээр хайрладаг жинхэнэ найз үгүй бол, та над уруу хэдийд ч ирж болно. Бид үргэлж холбоотой байх учраас та хэзээ ямагт найзтай гэдгээ мэднэ. Та чин сэтгэлээсээ хүсвэл намайг хувилгаан биеэрээ хүрч ирэхийг ч харж мэднэ. Та мөнхийн нөхөрлөлийг олон, баяр хөөр, хүнд хэцүү бүхнээ ямагт хуваалцах зөвлөгчтэй болж, энэ нь үргэлж таны хамгийн сайн сайхны тусын тулд үйлчлэх болно. Та сүнсээ аргадах гэж ийм арчаагүй хямд орлуурыг хэрэглэх шаардлагагүй болно. Бурханы оронд илүү сайн аргууд байдаг бөгөөд авшиг хүртвэл тэдгээр нь таных болно. [19]

А. Бусад хүмүүсийг алахыг нь зогсоохын тулд би алуурчныг хөнөөвөл зөв болох уу, хэрэв тийм биш бол би яавал зохих вэ?

Б. Цагдаад мэдэгд. Учир нь, хэрэв та түүнийг алчихвал өөрөө алуурчин болж, цагдаа нар таныг мөрдөнө шүү дээ! Цагдаад мэдэгд, тэд л оногдсон ажлаа хийг. Энэ бол таны хийх ажил биш, тийм биз? Тэр хүн гэмшиж ч магадгүй учраас түүнд боломж олго. Шоронд байхдаа гэмээ наманчлах юм уу, агшин зуур гэгээрэх тухай ном уншаад (Инээлдэв) амьдралаа өөрчилж ч мэднэ. Хүн яагаад алуурчин болдгийг хэзээ ч мэдэх аргагүй. Өчнөөн олон нарийн түвэгтэй нөхцөл байж мэднэ. Энэ нь нийгмийн нарийн төвөгтэй

байдал, эсвэл тэр хүн орчихоод гарч чадахгүй байгаа ямар нэг занга байж болох юм. Санааг минь ойлгож байна уу? Тийм учраас хүмүүсийн нөхцөл байдал, урьд төрлийн үйлийн үрийн үй олон зангилааг нь авч үзэхгүйгээр зүгээр л шүүх эрхийг гартаа авчихаж болохгүй. Тиймээс бид хааяа хүнийг шударга бусаар шүүж дүгнэдэг. Тэр алуурчин өмнө нь алуурчин байсан хүмүүсийг алахаар ирсэн байж ч мэднэ. Харин та одоо түүнийг алчихдаг юм гэхэд дараа нь тэр таныг алахаар эргэж ирнэ, тэгээд л энэ чөтгөрийн тойрог хэзээ ч дуусахгүй. Тийм болохоор хүчирхийллийн хариуд хүч хэрэглэхгүй нь дээр. [46]

А. Тэгвэл, хэчнээн муу юм хийсэн нь хамаагүй огт найдлагагүй болчихсон хүн гэж үгүй байх нь ээ?

Б. Гэгээнтэн бүрт өнгөрсөн үе бий, нүгэлтэн бүрт ирээдүй бий. Найдлагагүй хүн гэж байхгүй. Гагцхүү тэд агуу их байсан гэдгээ, дахин агуу их болж болно гэдгээ л мэдэхгүй байгаа хэрэг. Хэрэв тэдэнд агуу ихийг нь үзүүлж чадах хэн нэг хүнийг олбол хэн ч гэгээрч чадна. Тэр байтугай, ерэн есөн хүн алчихаад зуу болгохын тулд Буддаг алахаар завдсан хүн Арш болсон билээ. Будда түүнийг хүлээн зөвшөөрч, авшиг хүртээн номондоо багтааж авсны дараа тэрээр Бодьсад болсон юм. [35]

## *Хорт мууг гэтлэхүй*

А. Түрэмгийлэл, хүчирхийллийг эцэс болгох арга зам бий юу?

Б. Үгүй, надад ганцаараа шийдэх тийм арга зам байхгүй. Та нарт байгаа шүү дээ! Хүн бүр ийм чадвартай. Хэрэв бид амьтан алахаа больж, аливаа бүх хүчирхийллийг зогсоовол ертөнц диваажин болж хувирна. Энэ бол зөвхөн миний хариуцлага биш, хүн бүрийн хариуцлага. Танд тэгж бодогдохгүй байна уу? Учир нь хэрэв Багш, аль нэгэн Багш үүнийг хийж чадах байсан юм бол аль дээр үед Есүс үүнийг хийчих байсан, Будда ч хийчих байсан . [56]

А. Хар муу хүчний тухай ойлголт нь бидний сэтгэлд байдаг зүйл үү?

Б. Тийм ээ. Бидэнд сонгох эрх чөлөө бий шүү дээ. Бид хар цагаанаар сэтгэдэг бөгөөд буг чөтгөр ч мөн бидний дотоодод байх тэр Бурханы орноос гарч ирдэг. Бид сайн сайхан болоод амьдралын жинхэнэ зөв зарчмын эсрэг үйл хийхээрээ хар хүчний зэмсэг болж хувирна. Гэхдээ сөрөг хүч ч бас байх л зүйл. Тэр нь амьдралыг сонирхолтой болгож, оршин тогтнуулдаг. Тийм бишсэн бол бид бүгдээрээ л бурхдын оронд унтаж байх байсансан! Хийх ч юмгүй. Гэхдээ бид эсрэг хүчнээс залхаж, гэртээ харихыг хүсмэгцээ харих ёстой. Цаг үргэлж сөрөг талд тоглоод байж болохгүй, бас гэртээ харих хэрэгтэй биз дээ. Миний хэлж байгаа бүхэн чухамхүү тоглож ядраад гэртээ харьж амрахыг хүсч байгаа хүмүүст зориулагдсан юм. Ердөө л энэ. Миний хэлж буйг сонсохыг хүсэхгүй байгаа тэр хүмүүс бол байгаль ертөнцийн сөрөг талд дурлаж татагдсаар л байгаа хүмүүс юм. [30]

А. Там гэж байдаг уу?

Б. Тийм ээ, байдаг. Гэхдээ голдуу сэтгэл нь ноцтой гажиж үймэрсэн хүмүүсийн хувьд л байдаг юм. Буянт үйлстэй, сайн хүмүүс бол хэзээ ч тамд очихгүй. Авшиг хүртсэн хүмүүс бол хэзээ ч очихгүй. Там гэдэг бол сэтгэл, оюун санаа нь өвчилсөн хүмүүст туслах тун агуу эмнэлэг юм. Энэ нь дэлхий дээрх өвчин анагаадаг эмнэлэгтэй адилхан.[55]

А. Хүнд шүглэдэг хорон муу сүнс, буг чөтгөр гэж байдаг уу?

Б. Тийм ээ, тийм юм байдаг. Гэвч хорон муу сүнснүүдийн өчнөөн олон нь хүмүүсийн зүрх сэтгэлд байж байдаг. Бидэнд үзэн ядалт болон бусад уруу чиглэсэн гутрангүй болон дээрэнгүй санаа төрснөөр бид үл үзэгдэгч, тааламжгүй, цахилгаан гүйдлийг агаар амьсгал уруу цацаж байдаг. Тэр нь өтгөрсөөр, үзэн ядах сэтгэл ба тас харанхуй дарамтат хүч нэвчсэн энэ л орчны хажуугаар өнгөрч яваа эсвэл харьцаж байгаа хэн хүний хувьд бодохоос ч аймаар хүч болон хувирдаг. Тиймээс бид үргэлж сайн сайхныг

бодож, сайн үйл хийж, сайхан юм ярьж, Бурханыг бодож санаж, Бурхан шиг ярьж үйлдэж байвал сайн байдаг. Бурханыг таньж мэдвэл бүр ч сайн хэрэг. [46]

А. Буг чөтгөр нь хорон мууг илэрхийлдэг юм байж. Гэвч хорт муу амьтан, чөтгөр гэж үнэхээр энэ ертөнцөөр хэрэн хэсүүчилж байдаг юм уу, эсвэл энэ нь бидний дотор л байна уу?

Б. Дотоод ертөнц гэдэг бол бас гадаад ертөнц юм. Бид үүнийг үнэндээ ялган зааглаж чадахгүй. Бидний сэтгэлд байгаа бүхэн гадагшаа илэрч гардаг. Тиймээс адилхан өрөөнд байгаа хоёр хүн яг ижил орчин, эргэн тойрныхоо ижил уур амьсгалыг өөр өөрөөр хүлээж авдаг. Ойлгож байна уу? Нэг нь баяр баясгалантай байхад нөгөө нь үхтлээ гутарч байж болно. Тийм учраас хорон мууг бидний дотор эсвэл гадна талд байдаг гэж хэлэх аргагүй. Хаа хаана нь л байна, Бурхан бидний дотор ч, гадна ч хаа сайгүй байдагтай яг адилхан. Энэ нь бидний ойлголт, үзэл баримтлалаас хамаарна. Тэр Бурханыг ч, бугийг ч бий болгодог. Бид үзэл баримтлалаа өөрчлөх ёстой юм. Хэрэв бид бурханлаг маягаар сэтгэж, бурханлаг маягаар үйлдвэл Эзэн Бурхантай үргэлж хамт байна. Харин хорон муугаар сэтгэж үйлдэх юм бол бугтай үргэлж хамт байх болно. Буг чөтгөр гэдэг чинь хүний шинж төрхтэй хувь хүн биш. Энэ бол бидний сөрөг бодол, үйлдэл, үг хэлнээс төрж гарсан хүч. Тэр хаа сайгүй оршдог. Гэхдээ бид өөрсдийгөө Бурханы Оронд хандуулвал түүнийг заавал мэдэх шаардлагагүй. Хэрэв бид сэтгэл санаагаа Бурханы Орны долгионд тохируулвал тэнд л оршино. Хэрэв хорон муу орны долгионд тохируулвал харанхуйн хаанчлалд оршино. Энэ бүхэн бидний үзэл баримтлал, долгионоо олж барих чадвараас хамаарна. Тийм болохоор бясалгал хийж байхдаа бид Бурханы Орны долгионыг барих аргыг ашиглаж, ямагт Бурханы Оронд байдаг юм. Энэ нь янз янзын сувгийн долгионыг тохируулж барьдаг радиотай яг адилхан. [30]

## *Шалтгаан үр дагаварын хууль*

"Агуу их шашнууд цөм үйлийн үрийн хуулийн тухай сургадаг. Хэрэв тийм бишсэн бол, хэрэв бидний үйлдэл үр дагаваргүй байсансан бол тэд юунд сайхан сэтгэлтэй байхыг номлож, хүсч байх вэ? Тийм болохоор бүх том шашнууд дахин төрөл авах болон үйлийн үрийн хуулийн талаар сургажээ. Заримдаа үүнийг тов тодорхой тайлбарласан байдаг, хааяа санааг нь агуулсан байдаг. Манай хууль ёс гэдэг нийгмийн эмх журмыг хангахын тулд бүтээгдсэн байдаг бол ертөнцийн хамаг амьтны сайн сайхан, эмх цэгцийг хангах орчлонгийн түгээмэл хуулиуд гэж бас байдаг юм. Бид зөвхөн аль нэгэн улсад амьдардаг төдий бус, мөн дэлхий ертөнцийн иргэн, энд үндэстэн бүр нэг ордон мэт. Тиймээс ертөнцийн хуулийг бид мэддэг байх ёстой, хэрэв бид тэдгээрийг хүндэлж мөрдвөл оршихуйн доогуур түвшинг үзэж туулахаас хамгаалагдана." [18]

"Үйлийн үр гэдэг ойлголтын тухайд гэвэл, та бүхэн ертөнцийн үйлийн үр ба хүний үйлийн үр гэсэн хоёр төрлийн үйлийн үр байдгийг мэдвэл зохино. Хүн төрөлхтний хуулиудыг хүнд ойлгогдошгүй үл үзэгдэх хүч жолоодож байдаг. Үүнийг самгарьд хэлээр "Карма", өөрөөр хэлбэл Шалтгаан Үр Дагаврын хууль гэнэ. Библид үүнийг мөн *"Юу тарина, түүнийгээ л хурааж авна"* гэж дурдсан байдаг. [18]

Сайн ба муу үйлийн үр гэж байдаг, аль аль нь хүний дэлхийд татагдах сэтгэлийн хүлээсийг илэрхийлнэ. Авшиг хүртсэний дараа өмнөх амьдралын үйлийн үр арилж алга болдог, гэхдээ Багш одоогийн амьдралын үйлийн үрийг хөндөлгүй үлдээдэг юм. Эс тэгвэл та тэр дороо л ангижирчихна шүү дээ. Бид найз нөхдөдөө тусалж, дэлхий ертөнцөө адислахын тулд энд хэсэг хугацаагаар амьдрах ёстой юм. Ингэсний дараа бид Бурханы Оронд очиж болох бөгөөд хэрэв та өөрөө хүсвэл дуртай цагтаа эргээд ирж болно. Үйлийн үрийн хууль гэдэг бол нэн шударга, нэн хүчтэй үл үзэгдэх

хүч. Хийсэн үйлдсэн бүхэн маань бидэн дээр буцаж ирдэг. Шалтгаан үр дагаврын хууль гэдэг энэ юм.” [55]

“Биет (физик) ертөнцөд болж байгаа бүхнийг бичиж авах зориулалтай компьютер болох энэ бодол сэтгэл, ураг тархи байгаа учраас үйлийн үр оршиж байгаа юм. Үүнээс болоод л үйлийн үр гэж байдаг. Сайн муу алийг ч ялгалгүй эндээ бид бүртгэчихдэг. Бидний үйлийн үр гэж нэрлэдэг зүйл бол энэ. Үйлийн үр гэж юу юм бэ? Ердөө л олон олон төрөлдөө бидний туулсан сайн муу бүхэн, хариу үйлдэл, сурч мэдсэн туршлага маань юм. Бидэнд ухамсар гэх маягийн зүйл бий учраас бид сайн хүн байх ёстой гэдгээ мэддэг, гэвч заримдаа муу юм хийчихдэг. Муу үйл маань бөөн хог, ачаа шиг л биднийг дарчихдаг. Таталцлын хуулиас болоод тэр нь биднийг доош чангааж, уул өөд авирахад бэрхшээл учруулна. Энэ ертөнцийн ёс суртахууны сургаал номлол, янз бүрийн үндэстний өдий төдий зан заншил, дэг жаяг нь биднийг сайн муу, зөв буруугийн тухай үзэл баримтлалууд гэх зүйлстэй уяж хүлж орхидог. Иймээс бид энэ дэлхийн хүмүүстэй харилцахдаа сайн эсвэл муу, гэмгүй явдал эсвэл гэм бурууг үзэж мэдрэх нь тухайн үндэстний зан заншил, тухайн орны хууль ёсноос нь хамаарч байдаг. Ойлгож байна уу? Бид ингэвэл зөв, тэгвэл буруу, би муу хүн гэж бодох нь дадал болдог. Тэгээд тэр бүгд энэ тархинд бичигдэнэ дээ. Чухамхүү энэ л биднийг энэ биет ертөнц, эсхүл арай дээхнүүр ертөнцөд уяж чөдөрлөж, ахин дахин буцаж ирэхийг албадаж байдаг. Бид дээгүүр хөөрье гэсэн ч хангалттай хөнгөхөн, хангалттай чөлөөтэй биш байдаг. Энэ нь тэр бүх үзэл баримтлалууд, буруу ойлголтуудаас болж байгаа юм.” [42]

А. Багш та зураг төөрөг гэдэг зүйлийн талаар ярьсан. Зураг төөрөг гэдэг оюун санаанд илүү дөт боловч зарим нэг маань түүнийг заяа тавилан ч гэх. Харин чөлөөт сонголтыг яах вэ?

Б. Энэ бол биет төрөл авахаас өмнөх ба тийнхүү төрөх үеийн сонголт юм. Харин энэ насандаа буян хураагаагүй хүн үхсэнийхээ дараа сонголт хийх боломж байхгүй. Жишээлбэл, энэ ертөнцөд төрөхөөс өмнө бид тодорхой

хэв шинжтэй хувь хүн болох сонголт хийсэн байдаг ч, энд ирэхээрээ нийгмийн шахалт, нөхцөл байдалдаа тохируулан өөрчлөгддөг. Ингэж чөлөөт сонголтоо ч бас алддаг. Бид өөрсдийгөө эрх чөлөөтэй гэж боддог ч тийм биш. [58]

А. Тэгэхлээр жинхэнэ чөлөөт байдал, жинхэнэ сонголт бүр энд ирэхээс маань ч өмнө хийгддэг байх нь. Тэгээд Маягийн хөшиг халхлаад энэ гэрээгээ санадаггүй аж. Үүнийг гэрээ гэж нэрлэж болох уу?

Б. Тийм ээ, Бурхантай болоод өөрийнхөө ухамсартай хийсэн хэлцэл юм. [58]

А. Та үүний өмнө үйлийн үрийн тухай ярилаа. Хойд төрөлдөө хэн болохоо бид хянаж чадах уу, бид юу болохыг хэн нэгэн нь хэлж өгөх үү?

Б. Юу болохыг хэн ч бидэнд хэлж өгөхгүй. Яагаад гэвэл хойд төрөлдөө хэн болох нь бидний өөрсдийн үйлс, түүний үрээр тодорхойлогдоно. Хэрэв та нар хойд төрлөө хяналтанд авмаар байгаа бол зам мөрөө олж, агуу хүч чадлаа дахин олж авах билгүүн ухаантай байх ёстой. Гэтэл одоогоор та нар дэндүү сул дорой байна. [18]

А. Залбирал мөргөлөөр үйлийн үрээ багасгаж болох уу?

Б. Тийм, болно, гэхдээ үнэхээр чин сэтгэлээсээ залбирвал шүү дээ. Учир нь чин сэтгэлээсээ гүн гүнзгий залбирахад энэ нь нэг төрлийн бясалгал болдог. Энэ үед бид бясалгалын төлөв байдалд ордог учраас тэр залбирал нь бидний аврал буянт адислалын эх сурвалжинд хүрч, энэ нь нөлөө үзүүлж, ариусгадаг. Гэхдээ бид үнэхээр чин сэтгэлтэй байж, сэтгэлийнхээ гүнээс өршөөл гуйсан үед л нэмэртэй. [26]

А. Үйлийн үрээ хэд хэдэн төрлийн хооронд хуваарилж, аль нэг төрөлдөө багахан зовохоор зохицуулж болох уу?

Б. Хуваарилж болно. Гэхдээ та улам их зовох болно. Яагаад гэдгийг хэлье. Яагаад гэвэл төрөл авах бүрт бидэнд үйлийн

үр угаасаа байдаг, хэрэв та энэ амьдралынхаа үйлийн үрийг түүн дээр нэмэх юм бол улам л их зовох болно. Амьдрал болгонд чинь чамайг зовоох үйлийн үр хангалттай бий, гэтэл та дээрээс нь энэ амьдралынхаа үйлийн үрийг нэмчихвэл бүр их зовохоос бага зовохгүй гэж бодож байна. Та ойлгов уу? [26]

А. Эцгийн нүгэл хүүхдэд нь шилжих үү?

Б. Тодорхой хэмжээнд дагадаг. Үүнийг хамтын үйл үр гэдэг. Энэ нь гэр бүл дотор нь нүглийнх нь хариу ирж байгаа хэрэг. Үүнээс гадна хүн бүр өөр өөрийн муу үйлийн үр, сайн үйлийн үрийг цуглуулж тээж явдаг. Үйлийн үр гэдэг нь сайн муу үйлийн аль алиныг, зөвхөн мууг нь биш, сайн муу үйлийн аль алиных нь үр дүнг илэрхийлж байдаг. Гэвч олонхи хүн энэ үгийг сөрөг утгаар нь л хэрэглэдэг юм. [46]

А. Эрхэм Багш аа, сая сая хүний амь насыг хөнөөн, олон хүнийг зовоон тарчлаасан дайн дэгдээсэн Гитлер, Ленин, Хо Шин Мин зэрэг дарангуйлагчдыг бий болгосон зүйл нь үйлийн үрийн ямар хэлбэр гэдгийг тайлбарлаж өгнө үү?

Б. Энэ бол миний дээр өгүүлсэнчлэн хүн төрөлхтний хамтын үйлийн үр юм. Энэ нь хүмүүс, энэ ертөнц болоод өөр ертөнцийн бусад амьтдын хоорондын харилцааны дагавар бүтээгдэхүүн юм. Иймэрхүү дагавар бүтээгдэхүүн манай Дэлхийн агаар мандлыг хүрээлсэн нэн хүчтэй энерги болсон байна. Энэ нь хэт их нягтрахаараа, сая сая хүнийг хөнөөн дарангуйлагч гэх мэт үзэгдэхүйц бодит зүйл болон хувирах ёстой болдог.

Тийм учраас нэг талаар энэ хүмүүсийг буруутгах хэрэггүй. Бид өөрсдөө буруутай. Хэрвээ хүн болгон буянт амьдралаар амьдарч, сахил зааврыг баримталж, аллагын аливаа төрөл хэлбэр түүний дотор шууд бусаар амь хөнөөхөөс татгалзаж, мацаг хоол хэрэглэдэгсэн бол ертөнцөд ийм дарангуйлагчид хэзээ ч бий болохгүй байх байсан. Энэ бүх аймшигт гай зовлон нь бидэнд зөв зам мөрийг сануулахын тулд оногдсон бөгөөд хэрэв бид сэрж

сэхээрэхгүй бол бүх хүн төрөлхтнийг сэрэн сэртэл ийм зүйлс үргэлжилсээр, сануулсаар байх болно. [50]

А. Та үйлийн үрийн асуудлыг эргэн хөндөж, өмнөх үеийнхээ үйл үрийн өр төлөөснөөс хэрхэн ангижрах тухай, тэр нь гэгээрэлтэй ямар хамаатай тухай ярьж өгнө үү?

Б. Карма- үйлийн үр гэдэг бол орчлонгийн доогуур түвшний хэсгийн хууль болох *"Юу тарина, түүнийгээ л хурааж авна"* гэдэг хуулийг илэрхийлсэн самгарьд нэр томьёо юм. Багш авшиг хүртээх үедээ таныг дээш нь хол татна. Тиймээс доод давхрын үйлийн үр тань шатаагдаж, улмаар танд нөлөөлөхгүй. Тэрбээр Багшийн хүчээр хэдийн зөөлөрч сайжирсан энэ насны амьдралыг чинь үргэлжлүүлэх бага сага үйлийн үрийг л танд үлдээдэг. Авшиг хүртсэний дараа танд хуримтлагдсан үйлийн үр байхгүй болох учраас хэрэв та өөрөө л хүсэхгүй юм бол дахин төрөл авахын хэрэг үгүй болно. Хэрэв та дахин төрөл авъя гэвэл энэ нь маш амархан. Бид доошоо буухын тулд үйлийн үр үүсгэх юм уу, эсвэл олон амьтнаас үйлийн үр зээлдэж болно. Авшиг нь аливаа амьтны урьд төрлийн бүх үйлийн үрийг устгаж, ирээдүйд эргэж төрөх боломжгүй болгодог юм. [51]

## *Төрөл арилжихуй*

"Төрөл арилжих гэдэг нь эргэн эргэн ирэх орчил юм. Хэрэв та Бурханы оронд хүргэх гарц олоогүй бол эргэж ирэх хэрэгтэй болно. Энэ нь яг л хурдны зам шиг, та тэр замаас гарах гарцаа олохгүй бол түүнийг олохын тулд буцаад явах хэрэгтэй болно. Үүнийг төрөл арилжих гэдэг юм." [56]

"Төрөл арилжихуйн онолыг зааж сургах хэрэггүй, учир нь бидэнд төрөл авдаг оршнол байхгүй. Төрөл авдаг зүйл бол хураасан сайн муу мэдээлэлдээ хоргодон татагдах хандлага маань л байх. Тэгээд тэр хоргодох хандлага нь урьд төрөлдөө гүйцээж чадаагүй хүслийг маань биелүүлэхийн

тулд нэг хэрэгслийн дараа нөгөөхийг олж өгсөөр байдаг. Мэдлэгийн араас дагаж Билгүүн ухаан буюу Бурханлаг чанар маань бие хэмээх энэ сүмийг орхиод өөр сүмд шилжин очдог. Ингэх нь нэг сүмээс нөгөөд очихтой адил бөгөөд бид нөгөө л хүн хэвээрээ үлддэг. Үнэнийг хэлэхэд ертөнцөд оршин байдаг зүйл гэж нэгээхэн ч үгүй. Энергийн бөөгнөрөл болон хайрын орон зай л гэж байдаг, тэр нь заримдаа янз бүрийн хэсэгт хуваагддаг. Энэ нь чийдэн, дамжуулах утас, микрофон зэрэг өөр өөр хэлбэрт цахилгаан гүйдэл оршдогтой адил юм. Цахилгаан нь хайруул, хөргөгч гээд өөр өөр хэлбэртэй зүйл дотор оршивч гүйдэл нь яг л адилхан. [61]

А. Төрөл арилжихыг та юу гэж үздэг вэ?

Б. Төрөл арилжина гэж байдаггүй. Сүнс хэзээ ч төрөл арилждаггүй. Сэтгэлгээний зуршил, хүсэл шунал, сэтгэлийн хүлээс маань л төрөл арилждаг. Хэрэв бид сүнсээ таньж мэдэн, гэгээрч, бид болоод хамаг ертөнцийн хоорондын шүтэн барилдлагыг мэдэх юм бол хаана ч дахин төрөл авахгүй. Бид хэзээ ч төрөхгүй, хэзээ ч үхэхгүй. Гэхдээ энэ бүхэн цөм онолын яриа. Ердөө л гэгээрчих, тэгвэл та бүгдийг мэддэг болно.[47]

А. Хэрвээ хүмүүс дахин төрдөг юм бол яагаад ертөнцийн хүмүүс нэмэгдээд байна вэ?

Б. Яагаад гэвэл хүмүүс дахин дахин төрж байгаагаас. /Инээлдэв/ Учир нь хүмүүсийн олонх нь гэгээрэхгүй, чөлөөлөгдөхгүй байгаагаас болж дэлхийн хүн ам өсч байна. Мөн тамын амьтад энд хүн төрөл авахын тулд дээшээ мацаж байгаа учраас тэр. Мөн амьтны ертөнцөд амьтныхаа хувьд өр төлөөсөө гүйцээчихээд эргэж хүн болж байгаа амьтад байгаа учраас тэр. Бид үхэр, нугас, тахиа болон гахайн махыг хэдий чинээ их иднэ, ертөнц төдий чинээ дүүрэн хүнтэй болно. Үүнээс гадна хэдэн мянга юм уу зуун жилийн дараа хүн болж төрдөг сахиулсан тэнгэр, диваажингийн төрөлтнүүд байна. Ийм учраас хорвоо дэлхий үргэлж хэт их хүнтэй байгаа юм. [5]

А. Христийн шашны сүм хийд яагаад төрөл арилжих үзлийг хүлээн зөвшөөрдөггүй вэ?

Б. Учир нь тэд Библийг буруу ойлгодог, түүнчлэн Библи хэдэн зуу удаа хяналт засварт өртсөнөөс болж байгаа юм. Жишээ хэлье. Есүсээс *“Та өнгөрсөн үеийн тийм тийм гэгээн хутагтын хойд дүр мөн үү?”* гэж асуухад Есүс “Биш” гэж хэлээгүй. Мөн гэгээн Пол бас *“Би амьд байна, гэхдээ миний дотор би биш харин Христ амьдарч байгаа юм “* гэсэн байдаг. Ойлгов уу? Ингэхэд та нар дахин төрөхөд итгэдэггүй юм бол Христийг хоёр дахь удаагаа ирнэ гэж яагаад хүлээдэг юм бэ? /Инээлдэв/ Сүмийнхнээсээ асуу, тэгээд танд юу гэж хариулахыг нь үз. [10]

А. Дахин төрөл авах нь оюун санаа, сүнсний сонголт уу эсвэл биднийг эрхшээдэг Дээд Хүчний хяналтанд бидний сонголтгүйгээр болдог зүйл үү?

Б. Бидэнд сонголт бий, бас байхгүй. Ердийн хүмүүсийн хувьд сонголт байхгүй. Будда, гэгээнтнүүд, Христэд бол сонголт бий. Тэд эцэг эх, төрөх цаг хугацаа, газар орон болон ертөнцийг орхих өдөр цагаа ухамсартайгаар сонгодог. Тэд дэлхийд ирэхээсээ өмнө ухамсарлаж байдаг бөгөөд өөрсдийнхөө сонголтоор ирдэг юм. Тэд ертөнцийг аварч, найз нөхдөдөө, мөн тусламж гуйж тэдэнд залбирсан хүмүүст туслах гэж ирдэг юм. Бусад хүн бол өмнөх төрлүүдийнхээ туршид үйлдсэн зүйлээсээ болж дахин төрөл авахаас өөр аргагүй болдог. Бидний сэтгэлгээ болоод дадал зуршил энергит шилжин хэлбэржиж, тэр нь шаардлагатай бол биднийг аль нэг орчин нөхцөлд ямар нэг зүйл хийлгэх эсвэл устгуулахын тулд төрүүлдэг. Нэгэнт тодорхой хэлбэр олчихсон энэ энергийг саармагжуулах ёстой. [13]

А. Үйлийн үрийг нэг төрлөөс нөгөөд тээж явдаг зүйл нь сүнс үү?

Б. Сэтгэл, ой санамжийн хүч тээж явдаг. Үүнийг нэг утгаар энергийн хүч гэж хэлэхэд болно. Бид ямар нэгэн зүйлийг хийх үедээ энэ биеийн нүдэнд үл үзэгдэх энергийн хэлбэрийг бий болгодог. Энэ энерги нь хүний өөдлөх

доройтох гэх мэтчилэн энэ ертөнцөд сүнсний эдэлж өнгөрүүлэх амьдралын хэв маягийг үүсгэдэг. Урт удаан хугацаа өнгөрсний дараа сүнс өөрийгөө энэ хэв маягаас чөлөөтэй гэдгийг ухаарахын оронд өөрийгөө үүнтэй адилтгах болдог. [34]

А. Бид бол хөгжил хувьслын бүтээгдэхүүн. Тийм болохоор бүр доод түвшинд тухайлбал, адгуус амьтны түвшинд буцаж очих боломж бий гэдэгтэй санал нийлэхгүй байна. Энэ чинь хөгжил биш харин ухралт болно биз дээ?

Б. Тийм ээ, энэ бол хөгжил хувьсал, гэхдээ энэ нь хааяа түр хугацаагаар зогсоод дараа нь дахин дээш чиглэн үргэлжилдэг. Энэ нь цаг ямагт дээшээ явдаг хэдий ч бид заримдаа доошоо хальтирдаг. Уулын оргилд гарахыг хүсч байлаа ч хөл хальтирвал та бага зэрэг доош унах болно. Хэдий хүнд боловч уулын оройд гарах хэрэгтэй гэдгээ мэдэж байгаа болохоор өндийж босно. Хөгжил байнга явагдаж байгаа. Тийм учраас хүн өөрийгөө хүний бодгаль ёсоор биш адгуусны маягаар авч явах юм бол олигтой байгаагүйнхээ төлөө дараагийн төрөлдөө адгуус амьтан болж сургамж авах хэрэгтэй болно. Тэгэхээрээ тэр айж, залхаж гүйцээд “За больё, одоо боллоо. Би хүний амьдралд буцаж очъё, өөрийгөө хүний ёсоор авч явья. Дараагийн удаа яах ёстойгоо би мэдлээ” гэх болно. [20]

А. Шалтгаан, үр дагаврын хууль нь ертөнцийн хууль гэдгийг би мэднэ. Та ертөнцийн өөр бусад хуулиуд дээр тогтож, тодорхой ярьж өгч болох уу? Өөр хуулиуд байдаг уу?

Б. Тийм ээ, шалтгаан, үр дагаврын хуулиас илүү дээд хууль байдаг. Энэ бол Эзэн Бурханаас шууд ирдэг өршөөл хайрын хууль, энэрэл нигүүлслийн хууль. Үйлийн үрийн хуулийг ертөнцийг зохицуулах гэж Эзэн Бурхан бүтээсэн, гэвч үүнээс илүү дээд хууль, тухайлбал, хайр өршөөл, энэрэл нигүүлслийн хуулиуд байдаг юм. Үүнийг Есүс хүний биед төрөл авах үедээ бидэнд авчирч өгсөн юм. Үүнийг аврал одуулж, тусламж хайж ирсэн хэн болгонд

аливаа агуу их Багш нар авч ирдэг юм. Энэ бол хайр, нигүүлслийн хууль юм. [18]

## *Үхэл ба үхэхүй*

"Би өнөөдөр хамгийн аймшигтай боловч зайлшгүй зүйл болох үхлийн тухай ярья гэж бодож байна. Төрөх, өтлөх, өвдөх, үхэх эдгээрийн дотроос бидний хамгийн их айдаг нь сүүлчийнх нь, тэгээд ч үүнээс зугтаах арга байхгүй, тийм биз? Хүмүүсийн олонхи нь үхэх үедээ юу амсдагийг ярьж өгье.

Бидний бие цогцос нь төмөр, мод, ус, гал, шороо гэсэн таван махбод болон сүнснээс бүтсэн гэдгийг бид сонссон. Биднийг үхэхэд сүнс гарч одож таван махбодоос бүрдсэн бие цогцсоо орхидог гэж ярьдаг. Тэгснээр таван махбод бие биенээсээ салж, цаашид хамтдаа холбоотой байхаа больдог, учир нь сүнс байж байхдаа эрхийг хэлхэж холбодог утас мэт таван махбодыг бие биетэй нь холбох соронзон шиг үйлчилдэг. Хэрэв энэ утсыг тасалвал эрхи задарч газар унана. Үхэх үед яг ийм юм болдог. Гэхдээ бид эрхи биш, учир нь бидэнд мэдрэмж бий. Үхэл яагаад ийм шаналгаатай эмзэг явдал байдаг вэ? Юуны өмнө бид энэ ертөнц, эцэг эх, үр хүүхэд, эхнэр нөхөр, найз нөхөд, төрөл саднаа орхихыг хүсдэггүй учраас тэр. Хоёрт, энэ ертөнцийг орхисны дараа бид хаана очихоо мэддэггүй учраас айж эмээдэг. Гуравт, бид үхэлд бэлдээгүй байдаг учраас, үхэхээрээ яах ёстойгоо мэддэггүй. Түүнээс биш үхэл гэдэг нь айх юм юу ч үгүй, нэн жаргалтай агшин юм. [2]

Бидэнд өчнөөн хүн энэ ертөнцийн өдий төдий зүйлийг зааж сургадаг. Багш нар яаж уншиж бичих болон бусад олон зүйлийг заана. Эмч, эх баригчид ирээдүйн эхчүүдийг яаж төрөх болон төрөхдөө хүндрэлгүй, амар хөнгөн байхын тулд өөрийгөө болон хэвлий дэх үрдээ хэрхэн санаа тавихыг зааж сургадаг. Гэтэл үхэх үедээ яавал зохихыг хэн ч зааж өгдөггүй. Энэ талаар юуг ч үл дурдана. Бид яаж хүүхэд төрүүлэх,

хөгшрөхөөрөө даатгал, тэтгэврээр халамж хэрхэн хүртэхийг суралцаж болно. Эмч нар өвчин эмгэгийг маань анагааж, болзошгүй өвчнөөс хэрхэн сэргийлэх, өвдөх магадлалыг хэрхэн бууруулахыг заана. Гэтэл үхлийн тухай хэн ч ярьдаггүй, энэ сайнгүй хэрэг шүү. Тийм учраас би маргааш та нарт яаж "үхэх"-ийг (авшгаар дамжуулж) зааж өгье. [2]

"Сүнс энэ бие цогцсон машинаа орхих тэр үед бие махбодын бүх ажиллагаа зогсдог! Бид хамаг цагаа энэ биед анхаарал тавихад зарцуулаад харин мөнхийн нандин хайрт "Жинхэнэ Өөртөө" ер цаг гаргадаггүй буюу тун бага цаг гаргадгаа бодоод үз. Иймд бид жинхэнэ хүнийг түүний сүүдрээс ялгаж сурах ёстой." [57]

"Ертөнц мөнх бус. Бид хэчнээн их юм сурлаа ч, тэр нь нэг их тус болохгүй. Их эрдэмтдийн хувьд ч үхэл зайлшгүй. нэр цуутай суут хүмүүс ч энэ ертөнцийг орхих болдог. Ингэхдээ цөм гар хоосон явдаг. [2]

Тийм учраас шашин болгоны сургаалд бид энэ ертөнцөд сэтгэлээр хүлэгдэх ёсгүй гэдгийг онцлон дурддаг юм. Яагаад тэр билээ? Яагаад гэвэл бид энэ ертөнцийн тухай бодвол ийшээ эргэж ирэх болдог. Харин Эзэн Бурханы тухай бодвол Бурханы оронд очно. Шашин бүхэн бидэнд үүнийг сургадаг боловч Эзэн Бурханыг санаж бодох амаргүй байдаг. [2]

Хүүхдээ төрүүлэхэд бид сайтар бэлддэг ч хамгийн чухал зүйл болох үхэлдээ яагаад бэлдэж чаддаггүйг үүнээс харж байгаа биз дээ? Хүүхдээ төрүүлэх үед олон хүн ирж бидэнд хань болдог. Гэтэл үхэх үедээ бид нэн их ганцаардаж зовдог ч хэн ч бидэнтэй хамт байх боломжгүй байдаг. Бид үүнд бэлтгээгүй байдаг учраас үхэл бидэнд шаналал болдог юм. [2]

Бидний бие махбод нүд, чих, хамар гэх мэтчилэн есөн "хаалга"- тай. Бид бие махбодоосоо ангижрахдаа эдгээр хаалганы алийг нь ч ашиглаж болно, гэхдээ үхэнгүүтээ бид доогуур ертөнцдөө л байна. Байшингаар жишээлэн ярья. Хэрэв

та яарсандаа цонхоор харайж гарвал өчнөөн гэмтэж, битүү бэртэл авч мэднэ. Үүний оронд үүдээр гарах хэрэгтэй. Хэрэв үүд хаалттай байвал бид гарч чадахгүй. Бид дээд ертөнцөд нэвтрэн орж болох ганцхан л үүд байдаг. Тэр нь бидний бие махбодын нүдэнд харагдахгүй. Зөвхөн Их Багш л түүнийг нээж чадна. Бид түүнийгээ өөрсдөө нээж чадахгүй учраас, өөрийнхөө хаалгыг аль хэдийн нээчихсэн, яаж нээдгийг бидэнд үзүүлж чадах хэн нэг хүнээс гуйх хэрэгтэй. Тэгж байж бид үүдээ нээж хаах дасгалыг өдөр бүр хийх бөгөөд явах өдөр болоход гарч одоход түвэггүй байх болно. [2]

Сэтгэлийн авшиг хүртэх үед би та нарт хэрхэн үхэхийг зааж өгөмз, дараа нь та нар өдөр бүр бясалгах хэрэгтэй. Хэрэв ингэж бясалгахгүй бол мартчихна, яагаад гэвэл та нар энэ ертөнцөд дэндүү их уяа хүлээстэй, хэтэрхий дасчихсан байдаг. Хамаг л санаа бодол тань эхнэр, нөхөр, ажил, дарга руугаа чиглэсэн байдаг. Хэсэгхэн зуур дугхийгээд үз, тэд тэр дороо л яаж саад болж, санааг чинь зовоож байдгийг үзнэ. Тиймээс бид өдөр бүр хоёр цаг хагасыг “үхэх” дасгал хийхэд зориулах хэрэгтэй. [2]

Авшиг хүртэх үед Багш та нарыг агшин зуур дээд ертөнцөд хөтлөн аваачдаг бөгөөд танд ардаа юу үлдээсэн тухайгаа бодох ч сөгөө гарахгүй. Дээш өгсөх юу олж үзэх чинь “үхэх” зуураа таны хүрч чадсан тэр түвшингээс хамаарна. [2]

А. Багш аа, бид яагаад урьд төрлүүд болон үхлээ санадаггүй юм бэ?

Б. Яагаад гэвэл энэ нь бидний хувьд тэсвэрлэхэд дэндүү ахадсан, дэндүү хүнд ачаа. Бидний энэ насны амьдралд албан татвар, дайн дажин, үр хүүхэд, тулгамдсан асуудлууд, үйлийн үр хангалттай байна. Та өөрийгөө урьд төрөлдөө ийм тийм, их муу, их сайн, эсвэл их буянтай сайн хүн байснаа мэдлээ гэхэд та бүр будилж орхиод, энэ насандаа өмнөө байгаа зорилгоо гүйцээж чадахгүйд хүрэхсэн. Тийм учраас Эзэн Бурханы таалал, байгалийн хуулиар хөшиг татагдсан хэрэг. Харин үүнийг мэдэх зайлшгүй шаардлага гарвал та мэдэх л болно. Үүнийг та цаг тухайд нь мэдчихнэ.

Хэрэв энэ нь таны дэвшил хөгжилд зайлшгүй хэрэгтэй бол бясалгалаараа үүнийг заримдаа бас олж мэддэг. Харин зайлшгүй хэрэгтэй биш бол та мэдэхгүй өнгөрнө. Есүс ч мөн *"Маргаашийн тухайд битгий санаа зов. Бид өнөөдрийнхөө тухайд санаа тавьж байгаа маань хангалттай."* (Матвей, 6:33) гэсэн байдаг. Тэгэхээр, амьдралд чухал бөгөөд нөлөөтэй маргаашийнхаа тухай бид мэдэхийг хүсэхгүй юм бол, хэдийнээ улирч өнгөрсний тухайд мэдэх шаардлага бидэнд бүр хэчнээн бага байж таарах вэ! Ойлгож байна уу?[26]

А. Үхээд сэхсэн явдлуудыг та сургаал онолынхоо үүднээс юу гэж тайлбарладаг вэ?

Б. Үхээд сэхдэг тохиолдол бол үнэхээр үхэх үеийн мэдрэмж мөн л дөө. Гэхдээ ийм тохиолдолд бол сүнсийг маань бие махбод хэмээх хэрэгсэлтэй холбож байдаг мөнгөн утас гэгч зүйл хараахан тасарчихаагүй байдаг юм. Тиймээс тэр хүмүүс үхлийг үнэхээр биеэр амсдаг юм шүү. Буянтай, сайхан санаатай хүмүүс хурц тод гэрэл болон олон олон сайхан ертөнцийг олж үздэг, энэ бол үнэхээр тохиолддог зүйл. Бясалгал хийхэд мөн л тэгнэ; ганц ялгаа нь та энэ мэдрэмжээ уртасгах, эсвэл санасныхаа зоргоор дахин давтаж, улам илүү дээд ертөнц тийш тэлж байдагт оршино. Тийм болохоор бясалгал гэдэг бол мөн л үхлийг амсаж буй хэрэг юм. Тийм учраас Гэгээн Пол *"Би өдөр бүр үхдэг"* гэсэн. Урт биш хугацаанд хэсэг дадуулсны дараа та бие махбодоо орхиод дээд сайхан оронд очно, тэгээд өөрөө хүссэн үедээ буцаж ирж чадна. Зарим хүн ийм чадварыг авшиг хүртэх үедээ л шууд олж авдаг бөгөөд энэ нь цаашид байнга үргэлжилдэг. [58]

А. Үйлийн үр, үхэх төрөхийн хүрдний цаана юу байх вэ?

Б. Ойлгож мэдэхийн аргагүй хамгийн агуу билгүүн ухаан болон хамгийн дээд амгалан байдаг. Бидний жинхэнэ нутаг Хаант Улс энэ юм. Учир нь "тарьснаа хураах" хуулийг давбал Хайр Энэрлийн Хууль бий. Зөвхөн нигүүлсэл ба амгалан бий. Хэрвээ бид үйлийн үрийн хүрдийг эвдлэн

зайлж чадваас үхэх нь үгүй, төрөх нь үгүй, амьдрал үгүй, үйлийн үр үгүй, гагцхүү аз жаргал, амар амгалан байх оршихуйн тэр хэмжээст хүрнэ. Гэвч та нарт ингэж ярьснаараа түүнийг гутаан доройтуулчих шиг болох юм. Яагаад гэвэл хүний хэл гэдэг амархан төөрөлдүүлдэг, нэн хязгаарлагдмал зүйл билээ. Эрэгтэй эмэгтэй хүний хоорондох эгэл хайр сэтгэлийг гэхэд л үгээр илэрхийлэхэд ямар бэрх байдаг билээ? [58]

А. Амиа хорлосон хүнд юу тохиолддог вэ? Жам ёсоороо нөгчиж байгаа хүнтэй харьцуулахад ямар ялгаатай вэ?

Б. Ялгаа бий! Маш их ялгаатай. Амиа хорлосон ихэнх хүн ухамсрын нэн доод түвшинд, асар их гутрал хямралд байдаг. Тэдний хувьд ертөнцийн дарамт дэндүү их. Хэрэв хүн ухамсрын хувьд иймэрхүү байдалд үхэх юм бол тийм байдалдаа удаан хугацаанд үлдэнэ. Энэ нь бидний сүнсэнд сайнгүй. Ийм гутралын байдалд байгаа бол түүнээсээ салахыг хүснэ, гэвч өөрийгөө хөнөөсөн учраас гутралт байдалдаа удаан хугацаагаар үлддэг. [56]

А. Нөгчсөн бие цогцсыг яавал зохих вэ, чандарлах уу эсвэл оршуулах уу?

Б. Тухайн газар орныхоо байдлаас л болно. Нас нөхцөгсөд орших өөр газартай. Тиймээс цогцсыг чандарлаад үнсийг нь далай тэнгист цацах нь хамгийн сайн бөгөөд зохистой. [47]

А. Хүүхэд тийм цэвэр ариун атлаа яагаад нас бардаг вэ?

Б. Яагаад гэвэл түүнд цаашид амьдрах шаардлагагүй болсноос тэр. Тэр Бурханы Оронд ч очсон байж мэднэ. Тэнд бүр илүү цэвэр ариун. Заримдаа бидэнд ямар нэг ажил хийх хэрэг гардаг шүү дээ. Жишээлбэл, би энд гурав дөрвөн хоног л байх болно, учир нь ажлаа дуусгахад минь ийм л хугацаа хэрэгтэй юм. Тийм учраас би дөрөв хоногоор энд ирсэн. Хэрэв надад ирэх шаардлага гарвал би дахиад ирнэ. Зарим сүнснүүдийн хувьд энэ материаллаг ертөнцөд хамаарах юм бага байдаг учраас хэсэг хугацаагаар ирээд буцдаг. Зарим үед тэдэнд эцэг эхээсээ авах жаахан үйлийн үр байх бөгөөд дараа нь явах ёстой болдог. [56]

А. Хэрвээ амьдралын маань зорилго бид хэн юм бэ гэдгээ санахад оршдог юм бол үхлийн зорилго нь юунд оршдог вэ?

Б. Бие махбод гэдэг бол тодорхой хугацааны туршид л оршихоор заясан. Түүнийгээ элэгдэхээр бид суралцахад илүү тохиромжтой өөр бие цогцос ашиглах хэрэгтэй болдог.

А. Үхэл зөвхөн махбодод хамаарах уу эсхүл сүнсэнд бас хамаарах уу?

Б. Үгүй. Сүнс хэзээ ч үхдэггүй. Бид зөвхөн хувцсаа л сольдог. Хэрэв бид нэг хувцсаа хоёр өдөр өмсвөл бохир муухай болоод угааж цэвэрлэх хэрэг гарна. Хэтэрхий их элэгдэж муудчихсан бол түүнийгээ хаяад шинийг худалдаж авна. Ердөө л энэ. Бид зөвхөн хувцсаа л сольдог. [18]

А. Тэгэхээр үхэж байхдаа ч бид ухамсар, хянах чадвартайгаа байдаг байх нь ээ?

Б. Тийм. Гэхдээ бид гэгээрч, агуу их чадвараа эргүүлж олж аваагүй цагт хянах чадвартай байж чадахгүй.

А. Та үхэж үзсэн үү? Та үхлийн мэдрэмжийг санадаг уу?

Б. Тийм ээ, би өдөр бүр ингэж чадна! Би үхээд буцаж ирдэг.

А. Би ингэж чадах болов уу?

Б. Та чадна аа. Яаж тэгэхийг би танд зааж өгнө. *"Би өдөр бүр үхдэг"* гэж хэлсэн тэр хүн Гэгээн Пол байсан шиг санагдаж байна. Самади-д орохоороо та энэ ертөнцөөс хэдэн цагаар холбоогоо тасалж, тэгээд дараа нь дахин сэргээж чадна. Явах цаг тань болоогүй учраас та буцаад л ирнэ. Бид буцаж ирж ажлаа дуусгах ёстой.

А. Яагаад Та тийм олон удаа үхэхийг хүсдэг юм бэ?

Б. Би үхэхийг хүсдэггүй. Ердөө л амьдрахын тулд би үхэх ёстой юм. [18]

# Шашин сургахуунаас оюун санааны ухааралд хүрэхүй

Цаглашгүй Их Багш Чин Хайн тавьсан лекцээс

Би Буддын болон Католик шашны алинд ч харьяалагддаггүй. Би Үнэнд харьяалагдаж, Үнэнийг л номлодог. Та үүнийг Буддын шашин, Католик шашин, Бумбын шашин гэх юм уу аль хүссэнээрээ л нэрлэ. Би бүгдийг нь дуртайяа хүлээн авна. [11]

Бүхий л шашнуудын тухай хэдийнээ тогтсон үзэл баримтлалтай зөрчилдөх асуудал олон Багш нарт тулгардаг. Надад тийм юм байхгүй. Бүх шашин сайн гэж би хэлнэ. Бүхий

л шашны Багш нар бүгд сайн бөгөөд Үнэнийг ярьж, та бүхнийг Үнэн тийш хөтөлдөг. Өөрийнхөө шашныг туйлбартай шүтэж, өөрийнхөө шашны Багшид итгэ. Хэрэв одоогийн энэ цаг үедээ өөрийнхөө шашнаас Багшаа олж чадсан бол та азтай хүн юм. Хэрэв олоогүй бол өөр шашнаас амьд сэрүүн Багш бий эсэхийг эрэгтүн. Гэхдээ ингэхийн сацуу өөрийнхөө шашныг шүтсэн хэвээрээ л бай, тэр Багшийнхаа шашнаар солих хэрэггүй. Учир нь бүх шашин Эзэн Бурханаас гаралтай, мөн бүх шашны удирдагчид янз бүрийн цаг үед, янз бүрийн газар оронд сургаалаа хүргэхээр Эзэн Бурханаас л илгээгдсэн юм. [13]

Католик, Буддист, өөр аль ч шашны гэгээрсэн хүмүүс байсан ялгаагүй цөм нэгэн ижил зүйл, нэгэн ижил билгүүн ухаан, нэгэн ижил баяр бахдлыг нээн олсон байдаг. Би ч бас түүнтэй нэгэн адил ертөнцийг олсон бөгөөд уг чанартаа үүнийг сэтгэлийн төлөв байдал, ухамсрын төлөв байдал, оюун ухаан ба дээгүүр түвшний ухааралд хүрсэн байдал гэж хэлвэл илүү зохистой.” [64]

“Буддын шашин нь Католик шашинтай адил. Сургаал номлол нь өөр гэж би боддоггүй. Хэрэв Христийн шашны арван ариун хуулийг Буддын шашны сахилуудтай харьцулаад үзвэл нэг л адил: амь бүү хөнөө, хулгай бүү хий, худал бүү хэл, согтууруулах ундаа бүү уу, мансууруулах бодис бүү хэрэглэ, бусдын эхнэр, нөхрийг бүү булаа гэдэг. Харин сургаал номлолын доторх бусад зүйлс нь нарийн тодорхой юмс, тайлбар, эсвэл Багшийгаа амьд байх үед шавь нарынх нь бичиж авсан түүхэн үйл явдлыг л өгүүлсэн байдаг. Жишээлбэл, Библид дайн тулаан, талцан байлдаж байсан овог аймгуудын тухай олон үүх түүх байдаг. Эдгээр нь сургаал номлолд хамаарахгүй боловч тухайн Багшийг амьд байхад энэ үйл явдлууд болсон болохоор шавь нар нь түүнийг бичиж тэмдэглэжээ.” [35]

"Есүс гэдэг бол хүн байсан, харин Христ гэдэг бол хүч юм. Энэ хүч нь аль ч газар орон, аль ч цаг үед түүнийг дамжуулах чадвартай хэнээр ч дамжиж болдог. Цахилгаан гүйдэл шиг л дамжуулагч утас нь гэмтэлгүй, мөн залгуур байгаа юм бол ямар ч дамжуулагч утсаар дамжиж чадна. [26]

Есүс Христ бол Будда, Будда гэдэг нь Христтэй ижил утгатай. Ойлгож байна уу? Буддаг еврей хэлээр Христ гэнэ, харин Христийг самгарьд хэлээр Будда гэнэ. Ингэж хэлбэл та бүхэн юу гэх вэ? Хүмүүс эдгээр нэр томъёог хэзээ ч өөр өөрийн хэлэнд орчуулж байсангүй. Тэд зөвхөн анх тухайн нэрийг өгсөн хэлээр нь хэрэглэж, түүнийгээ баримтлахын төлөө тэмцэж иржээ. Хүний хэлний боломж дутуу дулимаг байдгаас болж бэрхшээл хүндрэл байнга л гардаг." [13]

"Судар бичиг бүрт анхнаасаа л хүмүүсийг ариун шударгаар амьдрахыг уриалан дуудаж "Бүү амь хөнөө. Ойр дотныхноо болон өстөн дайснаа ч хайрлаж, хулгай хийхгүй байх ёстой." (Матвей19:18) гэх мэтчилэнгээр сургажээ. Христийн шашны болон лал, сикх, хинду, буддын шашны гэрээс цөм нэг адил юм. Бид бие биенээ хайрлаж, сайн хүн болж, дотооддоо ариусах ёстой. Тэгвэл, бид цөм гадаад талын буянт явдыг мэддэг, мөн олонхи маань ариун бичээс дэх гэрээсийг сахиж чадна, гэвч дээр дурдсан дотоод ухаарал ба дотоод ариуслыг яах билээ? Бид Эзэн Бурханыг бусдаар дамжсан түүх болгон сонсох биш, харин яаж өөрийн оршихуйгаар олж сонсох вэ? Эдгээр нь бидний зүгээр л ёс суртахуунтай амьдрахаас илүү нэн чухал асуултууд юм. Гэхдээ мэдээж хэрэг, ёс суртахуунлаг амьдрал нь Эзэн Бурхантай нэг болох, Дао оршихуйд эргэж очих, Бурханы хутгийг олох эрмэлзэлтэй хүнд зайлшгүй хэрэгтэй мөн асар их тус нэмэртэй. Энэ бүхэн нь хамаг бүхний агуу их эх сурвалжтай нэгдэн нийлэх гэсэн нэг л утга санааг илтгэдэг. [5]

"Шашин нь Үнэн гэж юу болохыг зөвхөн зааж өгдөг, харин бид эдүгээ амьд буй Багшийн тусламжтайгаар Үнэнийг эрж олох ёстой. Жинхэнэ Багшгүй бол бид шашныг ч ухаарч ойлгож чадахгүй." [32]

## *Шашин суртахуунаас хальж гарахуй*

Буддын шашинд Бурханыг шүтэж, хөшөө барималд нь мөргөж, арц хүж уугиулж, цэцэг жимсээр өргөл тахил өргөж байвал л санаа зоволтгүй Бурханы авралд багтлаа гэж итгэдэг. Би үүнийг ихээхэн алдаатай үзэл баримтлал гэж боддог, яагаад гэвэл хөшөө баримал зэрэг нь эдүгээ үеийн биш, харин өнгөрсөн цагийн Бурханыг төлөөлдөг нь эргэлзээгүй. Өнгөрсөн үеийн Бурхан бидэнд дагаж мөрдөж, шалгаж үзэг гэж зарим нэг номлол сургаал үлдээснээс өөрөөр яаж ч туслахын аргагүй. Зарим хүн сүмд очиж усан баталгаа, бялуу мэтхэнийг хүртчихээд өөрсдийгөө тамын галаас найдвартай хамгаалагдлаа гэж боддог! Гэхдээ хүмүүсийн ингэж байгаад би баярладаг л даа. Учир нь ядахдаа үнэний бэлгэдэл нь ч гэсэн уламжлал болж үлджээ. Яагаад би баярладаг вэ гэхээр, энэ нь хүмүүс хэчнээн гэмгүй, хэчнээн амархан итгэж сүсэглэдэг, хэчнээн гэнэн цайлганыг харуулж байгаа юм. Бид ийм л гэнэн, цайлган зүрх сэтгэлтэй.

Тийм болохоор буддистууд буддын сүмд очин модон бурхдад жимсээр тахил өргөдөгт би баярладаг, католик шашинтнууд сүмд очиж эртний зан үйлийг давтан, аюулгүй боллоо гэж боддогт нь би баярладаг. Үүгээрээ тэд ядаж л гэнэн цайлган сэтгэлтэйгээ харуулж байна. Энэ амьдралдаа бид Бурханыг олж  үзэх юм уу эсвэл өөрсдөө Эзэн Бурханыг мэдэрч чадахгүй л бол гэнэн ариун байх нь бидэнд нэг их тус болж чадахгүй. Энэ нь хэн нэг хүн гэрт чинь шугам таталгүйгээр утас суурилуулж өгчихөөд "Танай утас энэ байна, хэний ч утастай адилхан харагдаж байгаа биз дээ, ингээд боллоо" гэж хэлэхтэй адил юм. Гэтэл  юу болох вэ? Та ердөө л өөрөө өөртэйгээ ярина. Шугам байхгүй юм чинь нөгөө

үзүүрт юу ч хүлээж авч чадахгүй. Хэрвээ нөгөө талаасаа хариу сонсохгүйгээр, нэг талаасаа л яриад, бүх юм болж байна гэж итгэж байвал гэнэн хэрэг, Эзэн Бурханаас хариу авахгүй байж болоод байна гэж итгэж байвал түүнээс ч гэнэн явдал болно.

Урьд би хэчнээн гэнэн байсан гэж санана. Өдөр бүр сүм хийдэд очдог, тэгээд хийх ёстой бүх зүйл маань ердөө л тэр гэдэгт итгэдэг байсан билээ. Гэвч хэсэг хугацаа өнгөрсний дараа би өсч хөгжин, сэтгэл нэг л хоосон оргихыг мэдэрч, Эзэн Бурхан юунд ч хариу өгөхгүй байна, би хэчнээн сэтгэл зүрхээ уудлавч Түүнд огтхон ч хамаагүй ажээ гэж бодох боллоо. Бурхан нулимсыг минь эгшээсэнгүй, хамгийн чин сэтгэлийн залбирал, асуултад минь ч хариулсангүй. Тэр ердөө л өдөр бүр нэгэн адил суусан яг тэр чигтээ инээмсэглэсээр л. Би уйлан хайлж, хөлд нь сөгдөн унаж, залбирч мөргөлөө, гэвч тэр ямхын төдий ч хөдөлсөнгүй! Тэгээд би урам хугарч, дараа нь уур хүрэв. (Инээлдэв) Би: “Та ийм эелдэг бус байж яаж чадаж байна!” гэж бодлоо. Гэтэл хэргийн учир Бурхан эелдэг бус байсанд биш, харин миний тун гэнэн бодолд байсан билээ.

Хэсэг хугацааны дараа би нөгчсөн Бурхан надад төдий л их тус болж чадахгүй байж магад, тэгэхлээр амьд байгаа, дотоодынхоо амьд Бурханыг эрж олох хэрэгтэй юм гэдгийг ойлголоо. Тиймээс ердөө л амьгүй барималд мөргөж байхын оронд, гэгээрлийг олохын тулд Багш хийгээд арга барил, жинхэнэ зам мөрийг хайж эхэлсэн юм. Тэгээд ихээхэн зүтгэл тэмцэл, хатуужил сахилга, хүч чармайлт гаргасны үр дүнд нэг л өдөр түүнийг олсон билээ. Бурханы эрж олсон тэр зүйлийг би оллоо. Би Есүс эрж олсон, Лууз, Күнз, Платон, Сократын эрж олсон тэр зүйлийг оллоо. Тэгээд би үүнийгээ та бүхэнд ямарваа нэг нөхцөл, болзол, уяа хүлээсгүйгээр өгөхөд бэлэн байна. Энэ бүхэн ямар ч үнэ төлбөргүй бөгөөд учир нь миний олсон тэр зүйл та нарт аль хэдийн байгаа юм. Энэ бол таных болохоос минийх биш. Би танд ямар нэг юм өгч байгаа ч юм биш. Би зөвхөн үүнийг нээхэд тань тусалж, хаана байгааг нь харуулна. Тэгэнгүүт та аз жаргалыг олж, хамаг гуниг зовлон тань алга болно. Библид хэлсэнтэй л яг ижил:

*Эхлээд Бурханы орныг эрж ол, тэгвэл бусад бүх зүйл танд аяндаа ирнэ.” (Матвей 6:33) гэжээ.*

Ном судар болгонд бид өөрсдөө гэгээрлийг олвол хамаг нүгэл хилэнц маань угаагдаж ариусна гэж цохон тэмдэглэдэг. Энэ нь нар мандангуутаа л хамаг харанхуйг хөөдөг шиг амархан.

Эс бөгөөс бид Библид өвөг дээдсийн “нүгэл хилэнц” гэдэг, Буддын шашинд урьд төрлүүдийн эцэс төгсгөлгүй үйлийн үр гэж нэрлэдэг тэр зүйлийг санааны зоргоор угаан ариусгаж хэзээ ч дийлэхгүй. Бид зөвхөн буян юм уу сайн үйл хийснээр, эсвэл Будда болон Есүсийн хөшөөнд мөргөж залбирсны ачаар үүнд хүрч чадахгүй юм. Бид тамын харанхуйг хөөхийн тулд Эзэн Бурханы гэрэл, угаас заяагдсан дотоодынхоо бурханлаг оршихуйг ашиглаж, үүнийг зүй ёсоор нь хийх ёстой. Есүс мөн: “Өнөөдөр миний хийж байгаа бүхнийг ирээдүйд та нар бүр ч илүү хийж чадна.” гэжээ. Энэ бол Есүс болон бид адил тэнцүү гэсэн үг. Тэр: “Ганцхан би л энэ бүх ид шидийг бүтээж чадна. Та нар үүнийг хэзээ ч хийж чадахгүй! “ гэж хэлээгүй билээ. Үгүй шүү. Тэр харин: “Миний хийж байгаа бүхнийг та нар бас хийж чадна.“ гэсэн. Энэ бол ихээхэн чөлөөт байр суурь бөгөөд Будда ч бас: “Би Бурханы хутагт хүрсэн, та нар ч Бурханы хутагт хүрч чадна.” гэж хэлжээ. Бид шинжлэх ухааны аргад ханддаг шигээ, энэ зөв аргыг дагаж, бүгд яг тэдний адилаар хийх юм бол ийм адил үр дүнд хүрч чадна.” [5]

## *Христийн мартагдсан илгээлт*

“Хүмүүсийн ихэнх нь өөрсдийгөө хэтэрхий мунхаг, хэтэрхий тэнэг, ямар ч найдлагагүй, юу ч биш улс гэж хэлүүлсний улмаас болоод л ердөө өөрсдөө Христийн жишээг дагаж чадахгүй гэж боддог. Тархи толгойг нь ингэж үеэс үед угааж мунхруулсаар тэд үүнд итгэчихсэн байна.[4]

*"Надад итгэдэг хүн, Миний хийж байгааг бас хийж чадна." (Жон 14:12)*

Есүс, өөрийгөө энэ бүх ид шидийг үйлдэж хүмүүст номлож, тэднийг гэтэлгэх цорын ганц хүн байсан гэж хэлээгүй. Тэрээр бид ч бас нэгэн адил хийж чадна гээд:

*"...үүнээс ч илүү ихийг тэр бүтээж чадна."*
*(Жон 14:12 ) гэж нэмж хэлсэн билээ.* [4]

Гэтэл хэрэв Есүс: "Өнөөдөр Миний хийж байгаа бүхнийг та нар ч хийж чадна." гэж хэлсэн байтал бид яагаад хийж эхэлж болохгүй гэж? Бид цөм л маш агуу их болохыг хүсдэг ч чадахгүй байна. Яагаад тэр вэ? Яагаад гэвэл бидэнд хүч чадал, эрдэм мэдлэг, билгүүн ухаан хүрэлцэхгүй байна. Энэ нь хүний дотоод эрхтний системд нарийн хагалгаа хийж сурсан мэс засалч гэж байдагтай адил юм. Хэрэв бид мэс засалчаас хэсэг хугацаагаар суралцвал түүн шиг нарийн мэргэшсэн хүн болно. Хэрэв бид Христийн сурсан тэр зүйлд суралцах юм бол түүнтэй адил агуу их болж чадна. Энэ бол зүй ёсны бөгөөд шинжлэх ухаанд нийцэх зүйл. Будда юм уу Христ шиг болоход ямар ч нууц далдын зүйл байхгүй. Хималайн уул өөд явах, үсээ хусуулах юм уу өөр хувцас өмсөх шаардлага байхгүй. Та жийнстэй байсан ч гэгээрч болно! Энэ бол амьдралын өөр хэв маягийг дагах тухай л асуудал юм. [5]

Гэвч бид энэ тухай бүр мартчихжээ. Биднийг нүгэлтэй улс, Есүс үгүй бол бид тамд унана гэж сүм хийдээс болон номлогчдын хэлдэгт бүр итгэчихсэн байна! Хэрвээ Есүс эргэж ирдэгсэн бол, Өөрийнх нь сургаал ийм хүчирхийлэл, гуйвуулгад өртсөнийг үзээд Сүнсээ зайлтал уйлахсан биз. Тэр уйлдаг юм. Уйлсаар л байгаа. [4]

Библид биднийг Эзэн Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн, Түүний үр хүүхэд, Түүний өв залгамжлагчид нь гэж өгүүлснийг бид мартчихжээ. Энэ нь бид бол Эцэгтэйгээ

адилхан бөгөөд Түүний хүч чадал бидэнд ч бас байгаа гэсэн үг. Хэрэв бидний эцэг хаан юм бол бид ханхөвүүд гүнж нар байж таарна, хоосонгүй байгаа биз дээ? Тэгэхлээр бид яагаад үнэ цэнэдээ итгэхгүй, өв хөрөнгө, төрөхөөс заяагдсан эрхээсээ юунд татгалзах ёстой юм бэ? Бид цаг үргэлж: "Бид бол Эзэн Бурханы үр хүүхэд, Түүний дүр төрхөөр бүтээгдсэн" гэж давтацгаах атлаа хэдхэн зоос олохын төлөө өдөр бүр зовж зүдэрч, хэзээ ч хариу авалгүйгээр мөргөж залбирч байдаг. Энэ нь бид зөв эх сурвалжиндаа залбирахгүй, буруу хаалга тогшиж байгаагаас болдог." [27]

"Бурханы Оронд хүрэх зам мөр хэцүү байдгийн учир гэвэл:

*"Амьдрал руу хөтлөх зам нарийн, сүйрэл үрүү хөтлөх зам өргөн, тиймээс түүгээр олон хүн явдаг."(Матвей 7:13)*

Энэ замаар явахад нэн бэрх байдаг тул зарим хүн түүнийг сахлын хутганы ир мэт гэжээ. Энэ зам яагаад ийм нарийхан байдаг вэ? Яагаад гэвэл энэ зам нь бидний сэтгэлгээний хэв маяг, хүсэл сонирхол, дур шохоорхлын эсрэг байдаг. Бид орших амьдрахын их далайд хувцсаа норголгүйгээр шумбах ёстой болдог юм. Тиймээс л энэ тийм хэцүү бэрх байгаа хэрэг. Бид энэ ертөнцийн шунал хүсэл, зөрчил тэмцэл тэр бүхний дунд амьдрахдаа лаг шавраас ургадаг ч цэвэр тансаг, сэвгүй ариун, анхилам байдаг бадамлянхуа шиг л сахил санваар, ариун ёсоо хадгалсаар үлдэх ёстой болдог юм. Бид энэ бадамлянхуа лугаа адил, тамын оронд ч гэгээнтэн болох ёстой." [4]

Есүс амьд ахуйдаа:

*"Би энэ дэлхий дээр байгаа цагтаа Би гэгээрлийн Зам Мөр, ертөнцийн Гэрэл Гэгээ мөн" (Жон, 9:5) гэжээ.*

Тэрбээр нэгэнт явсны дараа биеэрээ энэ дэлхийн гэрэл гэгээ байхаа больжээ. Гэхдээ бид өдөр бүрийн амьдралдаа дагаж мөрдөх сургаал номлолыг Тэр үлдээсэн байна. Энэ үнэхээр сайн хэрэг. Гэвч чимээгүй мөн чанартай нэгэн зүйлийг бид өвлөж авсангүй. Энэ бол зөвхөн чимээгүйгээр дамждаг чимээгүй номлол юм. Энэ бол чухамдаа бидэнд Эзэн Бурханыг харуулдаг, биднийг Эзэн Бурханд ойртуулдаг хамгийн чухал зүйл. Тийм учраас үүнд маань тусалж чадах хэн нэгэн байвал та бүхэн Түүнд хандахдаа эмээж гэмших ёсгүй." [61]

## *Есүс ба бясалгал*

"Есүсийн амьдралыг аваад үз. Есүс сүмд хэзээ ч залбирах гэж орж байсангүй, зөвхөн номоо айлдах, наймаачдыг хөөх, номлогч нарыг зэмлэх гэж л ордог байж. Түүнийг сүмд мөргөл хийж байсан гэж би ганц ч удаа уншаагүй, тэгэхлээр Тэр юу хийдэг байсан болж таарах вэ? Машноттой судалгааны мэдээллээс үзвэл Есүс олон орноор, тэр дундаа Энэтхэг болон Төвдөөр явж, өөр өөр шашин сургуулийн гэгээрсэн Багш нараас суралцаж байжээ. Хүн үнэнээсээ Багшийг хайж Энэтхэг явбал бясалгаж амьдардаг хүмүүстэй таарах бөгөөд тэд танд бясалгал зааж өгнө. Миний мэдэх Багш нар цөмөөрөө бясалгал хийдэг, түүнчлэн Төвдийн хамгийн алдартай лам нарын олонхи нь мөн л янз бүрийн бясалгал хийдэг.

Тийм болохоор Есүс Энэтхэгт наанадаж л арван хоёр жил байсан юм бол тэнд эдгээр бясалгалын Багш нарын заримтай уулзаж учирсан байх магадлалтай гэж бид хэлж чадна. Эхэндээ зарим нэг тарни, ёогийн дасгал, ид шид жишээлбэл, усыг хэрхэн дарс болгон хувиргах гэх мэтийг заадаг, хүч чадлаар багахан шиг Багш нартай учирсан байх. Есүс тэнд байх эхэн үедээ, Хималай уулын бясалгагч Багштай танилцахаасаа өмнө, энэ бүхнийг сурсан байж мэднэ. Эдгээр арга чаргыг сурахад түр зуур ч гэсэн бясалгалын тодорхой арга барилд суралцах хэрэгтэй болдог.

Есүс энэ хүмүүстэй уулзаад бясалгал сурсан байж таарна. Тийм биш бол Тэрээр дөч хоног элсэн цөлд завсарлагагүй сууж яаж чадах билээ? Та гэнэтхэн дөч хоногоор цөл үрүү ганцаараа явж чадах уу? Өмнө нь дасгал, бэлтгэл хийж байгаагүй л бол ингэх боломжгүй. Жишээ нь, “Аръяабалын бясалгалын арга“ буюу Библид бол Бурханы дуу хоолой болох “Үг” гэж дурдсан дотоодын аялгууг ажих бясалгалын аргаар хичээллэдэг бид долоо хоног юм уу сарын дияаныг тогтмол хийдэг юм. Бидний хувьд энэ нь тун жирийн явдал, харин манай энэ аргаар хичээллэдэггүй жирийн хүн бол таван өдөр битгий хэл таван минут ч сууж чаддаггүй. Хэрэв та таван минутын туршид хөдлөх ч үгүй, бодох ч үгүй сууж чадах юм бол та өөрөө Багш гэсэн үг. Тэгэхээр Есүс бясалгал хийх гэж л цөл үрүү дөч хоногоор явсан болох нь ойлгомжтой. Үүнээс Түүнийг бясалгалын аргаар хичээллэж байсан, бясалгал хийсээр байсан байна гэж дүгнэж болно. Тэгэхлээр Эзэн Бурханы илгээлтийг заан хүргэхээр хүмүүст хандахынхаа өмнө Түүний хийсэн сүүлчийн дияан нь энэ байжээ.

Ихэнх Багш эгэл ертөнц үрүү гарч очихоосоо өмнө буюу энэ үүргийг өөртөө хүлээж авах эсэхээ шийдэхээс өмнө ингэдэг юм. Энэ бол өглөөгүүр сэрүүлгийн хонхны дууг сонсох сүүлчийн агшин, халуун орон дотроо жаргаж хэвтэх сүүлчийн агшинтай адил юм. Үүнтэй адилаар ихэнх Багш гэгээрэлд хүрч, эрин цагийнхаа Бурханы Элч, эсвэл Аврагч нь байх үүрэг тавилангаа ойлгож мэдсэнийхээ хойно, хүлээж буй хүнд үүрэг зорилттойгоо тулж, Бурханаас оноосон урт холын замд гарахын тулд бие, сэтгэл, оюунаа бэлтгэхээр хэсэг хугацаанд дияан хийдэг юм.” [30]

## *Эзэн Бурханаас тусгаарлагдахуй*

Бид дэндүү зав чөлөөгүй байдгаасаа болоод Эзэн Бурханаас тусгаарлагджээ. Та хэн нэгэнтэй юм яриад, утас чинь дуугарч байхад хоолоо хийгээд юм уу эсвэл өөр хүмүүстэй

яриад завгүй байвал хэн ч тантай холбогдож чадахгүй. Эзэн Бурхан тантай холбогдох гэхээр яг л ийм юм болдог. Тэр бидэн үрүү өдөр бүр залгаж, харин бидэнд Түүнд зориулах цаг зав байдаггүй, Түүнд хариу өгөлгүй утсаа тасалж хаясаар байдаг билээ. Ийнхүү тусгаарлагддаг байна. Хэрэв та Эзэн Бурхантай дахин холбогдохыг хүсвэл цаг гаргах хэрэгтэй. Эзэн Бурхантай харилцахын тулд өдрийнхөө арваны нэгийг Түүнд зориулагтун, тэгэх юм бол та ийм тусгаарлалтыг дахин мэдрэхээ болих нь дамжиггүй. Гэхдээ бид хэзээ ч Бурханаас тусгаарлагдаагүй юм шүү дээ. Бид бүгд дотооддоо Бурханыг агуулж байдаг. Гагцхүү бид дэндүү зав зайгүй, ертөнцийн үүрэг хариуцлагаар өөрсдийгөө сохор балай болгочихдог учраас Бурхан хаана оршиж буйг мэддэггүй. Нүдний шилээ зүүчихээд түүнийгээ хаа сайгүй эрж хайгаад байгаа мэт. Бид дэндүү чөлөө завгүй үедээ олон зүйлийг ор тас мартчихдаг. Би та бүхнийг Бурхан чанартай тань дахин нэгтгэж чадна; тиймээс яах гэж хэмээн бүү асуу, харин яаж гэж л асуу.” [4]

“Мэдлэг дадлын их хуримтлал болох “Би”-тэйгээ зууралдаж, жинхэнэ зүйлийг олж харахаа мартдаг хандлага маань биднийг уяа хүлээстэй, “эрх чөлөөгүй” санагдуулж байгаа юм.”

Бид өөрсдийгөө материаллаг мэдлэг, эд хөрөнгөтэй хэдий чинээ их адилтгана, өөрсдийн ямар агуу их гэдгээ төдий чинээ бага мэднэ. Оюуны мэдлэг ихтэй зарим хүн бясалгал хийхэд тун бэрх, боловсрол багатай хүнтэй харьцуулбал дээд билиг ухаанд хүрэхэд амаргүй байдаг. Энэ нь тэд угааж арилгах, ялгаж салгах юм ихтэй байдгаас болдог юм. Гэрт чинь дэндүү их юм байх юм бол шинэ тавилга оруулж тавихын тулд цэвэрлэгээ хийхэд илүү их цаг шаардагдана. Харин танайд тоотойхон хэдэн хогшил байвал гэр орноо хурдан цэвэрлэчихнэ шүү дээ.” [61]

“Хэрвээ бид Бурханы Орноос ирсэн юм бол ингэж их зовох гэж тэндээс явсан хэрэг үү? гэж та бүхэн асууж болох юм. Бид хамгийг бүтээгч ертөнцөөс ирсэн нь үнэн

болович ирснийхээ дараа энэ тухайгаа мартчихжээ. Яагаад гэвэл бид өөр хувцастай байсан бөгөөд доошлох тусам хувцас маань нягтраад эргэн тойрноо бид харж чадахаа больчихдог. Жишээлбэл, хэрэв та далайн гүнд шумбая гэвэл усны хувцас, баг, хүчилтөрөгчийн сав, хөлийн сэлүүр гэх мэт юм танд хэрэгтэй болно. Тэгээд та харахад яг л мэлхий шиг болж, өөрийгөө танихгүй. Бид доогуур түвшин лүү буухын хэрээр хувцас маань хүндэрсээр, нэгэн цагт баясан мэдэрч байсан хөнгөн чанараа бүр мартана. Хэдий чинээ доошилно, хувцас төдий чинээ нягтарч, юмсыг өөр нүдээр харахад төчнөөн хэцүү болдог.

Үүнтэй адилаар доош буух үед биднийг дээд ертөнцөд байхад огт хэрэггүй байсан нүд, чих, ам, бие цогцос зэрэг янз бүрийн зүйлийг "өмсөх" шаардлага гардаг. Ингээд жаран жилийн туршид өдөр болгон өмсөж зүүж яваа үүндээ дасчихаад өөрийгөө энэхүү гадна талын хувцас хунартай адилтган үздэг болно. Гүнзгийрэх тусам улам олон багаж хэрэгсэл шаардлагатай болж хүрээлэх орчныг харахад төдий бэрх хэцүү болно. Нарны гэрэл үгүй, ердөө л хав харанхуй болж, зохиомол гэрэл хэрэгтэй болно. Үүнтэй нэгэн адилаар бид ахуйн далайд шумбан ормогц Бурханы гэрлийг олж харж чадахаа больдог юм." [17]

## *Гэртээ харихуй*

Бид хэзээ ч Оройн Дээд Бурханаас салангид байгаагүй, бид цаг үргэлж Төгс Дээд байсаар ирсэн. Гэвч хүлээн авч буй мэдээлэлтэйгээ өөрийгөө адилтгах хандлага, орчин тойрон болон нөхцөл байдлаас олж авдаг дадал зуршлынхаа улмаас бид цогц бүхлээс өөрийгөө тусгаар гэж боддог хувь хүн, хэн нэгэн этгээд болдог. Гэхдээ өөрийн хүч чармайлт юм уу, оюун санааны анд нөхрийнхөө ачаар гэгээрснийхээ дараа бид юмсыг өөрөөр хардаг болно. Тэгмэгц бид хэдийгээр хувь хүний бүрхүүлтэй хэвээрээ ч бид бол энэ биш гэдгээ мэддэг болно."[61]

“Тэгэхээр бид энэ гэрлийг дахин олж үзэхийг хүсч байгаа бол өөрсдөө дээш гарах ёстой, эсвэл бид ямар нэг хад чулуунд тээглэж гацах юм уу хүчилтөрөгчийн нөөц дууссан тохиолдолд хэн нэгэн хүн биднийг дээш татах хэрэгтэй болно. Тиймээс бид бүхий л саад тотгорыг давах ёстой. Доош буух үедээ туулсан бүхнээ одоо дээш гарахдаа туулан гарах хэрэгтэй. Тэгж байж бид өмсгөл тоногоо тайлан хаяж, төрөлх гоо үзэсгэлэндээ эргэж орно. Ийнхүү бид элдвийг нээн шинжилж, зугаалж цэнгэх гэж дээд ертөнцөөс бууж ирэн, ахуй амьдралын далайд шумбасан юм. Шинэ ертөнц биднийг догдлуулан татаж, бид цаг өнгөрч, амь нас маань аюулд учирч буйг мартчихжээ. Яагаад гэвэл томилолт дуусахаар бид эрэг үрүү буцаж гарах ёстой байсан. Гэтэл биднийг гарч ирэхгүй болохоор найз маань доош шумбаж биднийг авчрах ёстой болно. Үүнтэй адилаар бид хэтэрхий удаан энэ өмсгөлтэй байснаас өөрсдийгөө биет хэлбэртэйгээ адилтган үзэх болсон хэрэг. Тэгэхээр бид  Бурханы Орон луу гэртээ харихын тулд хэчнээн хүнд бэрх байлаа ч оршихуйн далайн ухамсрын бүх түвшинг нэвтрэн гарах ёстой.

Ямар ч адал явдалтай учрахад бэлэн хүч чадлаар дүүрэн байсан учраас доош буухад харьцангүй хөнгөн байсан. Бүх зүйл шинэ сэргэг, бид ч ядрахыг мэдэлгүй маш хурдан доошилсон. Харин дээшээ гарна гэдэг өөр хэрэг! Бид эцэж ядарч, хүчилтөрөгч маань дуусахаа шахан, адал явдалд арай хэтэрхий дурласнаас буцах замаа мартчихжээ. Гэвч аз болоход Бүтээгч маань биднийг холбох шугамаар хангаж өгчээ. Та бүхэн мөнгөн утасны тухай ер нь сонсож байсан уу? Энэ бол биднийг аврах шугам бөгөөд тэр утсыг татвaас биднийг гэрийн зүг замчлах аялгуу дуугардаг.

Бидний эрхэм анд нөхөр Есүс, Будда хоёр оршихуйн далайн ёроолд дэндүү удсан юм уу төөрч будилсан хүмүүсийг эрж олох гэж бууж ирсэн билээ. Хэрэв бид ганцаараа буцаж чадвал маш сайн хэрэг, харин тэгж чадахааргүй бол ийм хүмүүс зайлшгүй хэрэгтэй. Тэд бол бидний аюулгүй байдлыг харгалзагч малчид юм. Бид дээшээ гарахдаа усны олон үе

давхаргыг нэвтрэн өнгөрөх хэрэгтэй болдог. Газрын татах хүч ба усны даралтаас болоод дээшээ хөвж гарах илүү хэцүү байдаг. Бид бас эцэж ядарсан байгаа, иймд дээш гарахад доош буухаас хэцүү. Тиймээс хэн нэг нь дэргэд ирж, замыг маань гэрэлтүүлж, хүчилтөрөгчийн нөөц шинээр авчирч өгвөл бид айх аюулгүй бөгөөд өөртөө ч итгэлтэй байх болно. Бид бол энэ оршихуйн ертөнцийн харьяат биш, энэ нь бидний хэсэг зуур үзэж сонирхож, тоглох газар юм, ойлгож байна уу? Яагаад гэвэл Бурханы Оронд хэтэрхий удахаараа, жаргал цэнгэл маань дэндүү их, жаахан уйтгартай санагдаж ч мэднэ!” [17]

“Бид угаасаа Эзэн Бурхантай хамт байгаа юм. Гагцхүү үүнийгээ мэддэггүй учраас хагацлын бэрхийг амсаж, энэ ертөнцийн хамаг л дарамт шахалтан дор орь ганцаар байх шиг санагддаг. Би та бүхнийг Эзэн Бурхан оршиж байдаг тухайд ойлголт төсөөлөлтэй болоосой гэж хүсч байна. Тэгэх юм бол та нар өөрсдөө Түүний өмөг түшиг, хайр энэрэл, заавар зөвлөгөөнд итгэх болно.” [7]

А. Сүм, хийд болгонд уншлага, залбирал байнга үйлдэж харагддаг. Эдгээр нь гэгээрэлд хүрэх зам мөр болж чадах уу?

Б. Чадахгүй. Энэ бол зөвхөн гэгээрлийн нэгээхэн хэсэг. Уншлага залбирал нь бидний үнэн сүсгийг бататгаж, чин сэтгэлийн ариун уур амьсгал бий болгоход хэрэгтэй. Харин өөрийн анир чимээгүй Бурханлаг мөн чанартайгаа холбогдъё гэвэл бид чимээгүй байх ёстой. Тэр маань дуу шуугиангүй байдаг. Бид өдөржингөө юм ярьж, бодсоор зав чөлөөгүй, тэгсэн атлаа сүмд очихоороо юм ярьцгаан, уншлага үйлдэж, юу хийх ёстойг нь Эзэн Бурханд зааж хэлсээр бас л завгүй. Ийм байхад таны бодлоор Бурханаас бидэнд зориулах эсхүл биднээс Бурханд зориулах цаг хэзээ гарах болж байна? Бид уншлага үйлдэж, залбирахын сацуу нам сууж, нам зогсож, нам хэвтэж яаж ч юм, Бурханыг хаанаас эрж олохоо мэдэх хэрэгтэй. [6]

А. Хуучин Гэрээ болон Жүүд шашны талаар та юу гэж боддог вэ?

Б. Сайн л зүйл. Гэхдээ Аврагчийг хүлээх хэрэггүй, учир нь Тэр цаг ямагт оршиж байдаг. Өөрийгөө орчин цагийн Аврагчийг таньж олоосой гэж залбирч бай. Та одоогийнхоо байдлаар Түүнийг хүлээх юм бол хүлээж байгаа тэр хүн чинь хэзээ ч ирэхгүй. Есүсийг ирэхэд хүмүүс бас л Аврагчийг хүлээж байсан мөртлөө дэргэд нь байсан түүнийгээ алчихсантай адил!

Бид үргэлж л нэг ижил тэнэг явдлаа давтан хийгээд байдаг. Хэргийн учир нь Жүүд шашны муу биш, бидний мунхагт байгаа юм. Есүс ч хүртэл бидэнд тайтгаруулагч илгээнэ гэж өөрөө амласан, өөртэй нь эн чацуу хэн нэгэн гэсэн үг, тийм биз? Гэтэл хоёр мянган жилийн хойно бид хүлээсээр л байна, харин өчнөөн олон элч дэлхий дээр ирээд буцсан байдаг. Есүс дахин ирнэ гэж бид сонссон, тийм үү? Таныхаар бол бидэнд танигдахын тулд Тэр ямар харагдах ёстой вэ: далавчтай, сахалтай эсхүл загалмайд цовдлоотой байх уу? Хэрэв Тэр ирдэг юм гэхэд бид Түүнийг яаж таних вэ? Бид тэр байтугай Есүс ямархуу дүр төрхтэй байсныг ч мэдэхгүй шүү дээ! Бид тэр үед байгаагүй, байсан байлаа ч гэсэн хоёр мянган жилийг нэвт шувт санаж чадах тийм агуу ой дуртгал хэнд байх юм бэ!

Есүс дүрээрээ бус, харин сүнсээрээ ирнэ. Есүс юм ойлгож мэдэрдэг, Түүнийг оруулах зөв хаалгаа нээсэн хэнд ч Тэр ирнэ. Тэгвэл бид Есүстэй адил болно, ингэмэгц Тэр дахин ирнэ. Бид хэзээ бэлэн байна тэр цагт л Тэр ирнэ. Түүний бүхнийг чадагч хүчийг нь агуулах чадвартай ямар ч Багшаар дамжин ирж болно. Тэр хүн мөн л Есүс, өөр үс, зүстэй байж болох ч, Есүс л юм. [30]

А. Бидний Бурхан чанар хийгээд долоон хүрд хоорондоо ямар холбоо хамааралтай байдаг вэ?

Б. Хэрвээ та энэ хүртэлх (Багш билгийн нүдээ заав) бие махбодын хүрдийг ярьж байгаа бол ямар ч холбоо хамаарал байхгүй. Би эдгээр хүрднээс дээгүүр зүйлийн тухай ярьж

байна. Хүрдэн дээр бясалгадаг егүзэрүүдийн ихэнх нь зөвхөн халуун дулааны хөдөлгөөнийг л өдөөдөг юм. Бидний биед хоёр урсгал байдаг: нэг нь аялгууны урсгал, нөгөө нь дулааны урсгал. Сүүлчийнх нь биеийн хөдөлгөөн, хоол боловсруулах, хөлс ялгарах, цусны эргэлтийг харгалздаг. Нөгөөх урсгал нь биднийг Бурханы Оронд буцаан аваачдаг. Тиймээс егүзэрүүд доод хүрднүүд дээр (бэлгийн хүрд, ахар сүүл, наран сүлжээ, хоолойн хүрд гэх мэт) бясалгах нь хамаарал үгүй; би энэ бүгдээс дээш оршдог хүрднүүдийн тухай л ярьдаг. [6]

А. Эзэн Бурхан яагаад Есүсийг тийм маягаар нас нөгчиг гэж хүссэн юм бэ?

Б. Тэгэхээс өөрөөр Түүний шавь нар нь нүгэл хилэнцээсээ цэвэршин ариусах аргагүй байжээ. Багшийн бие цогцос хоёр шалтгааны тулд байдаг. Нэгдүгээрт, биет ертөнц дэх шавь нартаа харагдахын тулд. Тэд Багшийнхаа астрал биеийг харж чадахгүй шүү дээ. Хоёрдугаарт, Багшийн бие цогцос золиос болж байдаг. Шавиас салж арилах ёстой бүхнийг авах, шавь нарын нүглийг цуглуулан цэвэрлэж ариусгахын тулд Багшийн бие оршдог. [32]

А. Өнөөгийн Христийн шашны сургаал номлолтой харьцуулан Христийн өөрийнх нь жинхэнэ сургаалын тухай ахиухан ярьж өгнө үү?

Б. Христийн сургаал болон орчин үеийн Христийн шашны сургаал хоёр аль аль нь сайн. Христийн шашны өнөөгийн сургаал ном хяналт засварт өртөж хасагдсан, зарим нэг хэсэг нь үгүй байж мэднэ, надад түвэг удаж мэдэх тул би энэ тухай ярьж зүрхлэхгүй байна. Христийг амьд байх үеийн Түүний сургаал номлолын ихэнхийг бичиж тэмдэглэжээ. Энэ нь миний уншсан Сөнөмөл Тэнгисийн Хуйлааст бичгийн жишээнээс илт байдаг. Эдгээр нь маш эрт цагийн, бүр Есүсийг амьд байх үеийнх гэж тооцогддог. Библид эдгээр зарим зүйлс байхгүй ч ер нь бол Христийн шашны сургаал давгүй. Цорын ганц дутагдаж буй зүйл

нь Есүс юм. Энэ бол дутаж буй хамгийн агуу зүйл нь. Тиймээс бид одоо, Есүстэй шууд тогтоосон холбоогоор энэ хэсгийг орлуулъя. Хэрвээ та Түүнтэй уулзахыг хүсч байвал Түүнийг харж болно, Түүнтэй ярьж болно, Түүнээс биечлэн сурч болно, учир нь Тэр үхэшгүй мөнх юм. Хэрэв Сүм эсвэл Христийн шашны аль нэг байгууллага таныг Есүстэй шууд холбогдоход тань тусалж, Эзэн Бурханы утасны дугаартай шууд холбож чадах юм бол илүү зөв, илүү бүрэн төгс, илүү их сэтгэл ханамж өгнө. Тэгж чадахгүй бол, бид танд энэ дутуу хэсгийг нөхөж өгч чадна. Ердөө л энэ. О.К ?” [46]

А. Есүс Сөнөмөл Тэнгисийн эрэг орчмын Ариун Бүлэглэл болох Эссенесд байсныг Та мэдэх үү?

Б. Тийм ээ. Тэр мянга мянган жилийн туршид мацаг хоолтон байсан Эссенес бүлгээс гарч ирсэн бөгөөд тэд тэр үед ч авшиг хүртээдэг уламжлалтай байсан. Тэд бол гэрэл, аялгууг дамжуулдаг ”Цагаан ахан дүүс“ гэгдэгсэд байсан, тэр үед энэ бүлэгт элсэнэ гэдэг тун хэцүү хэрэг байжээ. Гэрлэхгүй байх сахил, сургаал номлолыг гадагш ил тод заахгүй гэсэн амлалт авах хэрэгтэй байсан ажээ. Бүлэгт элсэж буй хүн болгон ахмад гишүүний батлан даалттай байх, бас цагаан жанч өмсөхөөсөө өмнө олон жилийн сорилт шалгалтыг давж гарах ёстой байв. Тэд бол ”хайр энэрлийн биелэл” байсан, гэтэл сургаал номыг нууцлах амлалтыг зөрчсөн хүн нь Есүс байжээ. Гэхдээ энэ бол мэдээжээр Оройн Дээрхийн зарлигаар болсон хэрэг. Есүс дотооддоо илгээлт хүлээж авсан; үүнээс өмнө энэ Бүлэгт хэн ч Түүн шиг ил тод номлол тавьж байгаагүй. Энэ нь нэгдүгээрт, андгай өргөсөн учраас, хоёрдугаарт, аюултай байсан учраас тэр. Тийм ч учраас Есүс цовдлуулсан билээ. Тэр ил тод ном тавьж, бүх Цагаан ах дүүс Түүнийг нарийн харж хандаж, янз бүрийн аргаар хамгаалах гэж хичээж байжээ. Гэвч тэд яаж ч чадаагүй билээ.” [32]



Их Багш тайзан дээр Түүний загварыг өмсөгчдийн хамт үзэгчдэд хүндэтгэл үзүүлэн ёслохоор гарч ирээд байгаа нь.
1995 онд Нью Йорк, Лондон, Парис, Милан хотуудад S.M.Тэнгэрийн хувцас загварын шоу асар амжилттай болж өнгөрсөн юм. Энэхүү шоуны орлогыг Ижил Хүйстэн Эрчүүдийн Эрүүл Мэндийн төлөө Байгууллага, Орон Гэргүйчүүдийн Холбоо, ДОХ-ын эсрэг Дизайнеруудын Холбоо зэрэг байгууллагуудад хандив болгон өргөжээ.



Итали


Шотланд



Чех улс



Испани


Норвеги


Финлянд


Португал


Их Британи




Польш

1999 онд Европт хийсэн айлчлалын үеэр Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай 18 орны нийслэлд ном тавьжээ. "Бурхантай шууд холбогдох нь энх тайванд хүрэх арга зам мөн" хэмээх номонд эдгээр лекцүүд тус бүрээс эмхтгэн оруулсан байна.



Швед



Армени



Грек



Орос



Ирланд



Болгар



Словени



Нидерланд



Унгар






Чин Хай Багш 1993 онд, Өмнөд Калифорний түймрийн үеэр Лагуна элсэн эрэг дээр болсон бүх шашны хамтын залбирлын үеэр.
Залбирах ёслолын дараа Америкийн уугуул Индиан иргэдийн ахлагч Багшид хүн төрөлхтний төлөө тавьж буй анхаарал халамж, дэлхийн энх тайвныг бэхжүүлэхийн төлөө оруулж буй их хувь нэмэрт нь талархал илэрхийлж бүргэдийн өд дурсгал болгов.



Их Багш 1999 оны 12 сард Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улсын Кейп Таунд болсон Дэлхийн шашнуудын чуулга уулзалт дээр.

# Гэрлийг олохуй

Цаглашгүй Их Багш Чин Хайн тавьсан лекцээс

## *Дотоодын Бурханы орон*

Бидний дотоодод илүү сайхан амьдрал, илүүтэй төгс төгөлдөр амьдрал оршдог. Бид дотооддоо төгс төгөлдөр болмогц гадна талын амьдрал маань ч бас төгс төгөлдөр болдог. Ажил төрлөө илүү үр бүтээлтэй, илүү хурдан шалмаг, дэлхий ертөнцөд илүү ач тустай болгохын тулд бид билиг ухаан, дотоодынхоо хүч чадлыг ашиглаж чадах болно. Тиймээс ч хэрвээ бид нийгэмд чухал байр суурь эзлэх буюу аль нэг салбарт амжилт олъё гэж хүсвэл бодол сэтгэлээ бус харин зөв зүйтэй хүчнээ ашиглах ёстой юм. Хүч чадлын хоёр түвшин байдаг; нэгдэх нь хүчний түвшин, тэр нь бодол сэтгэл юм. Нөгөөх илүү өндөр дээд түвшин нь аврал, хайр ба гайхамшгийн түвшин. Гайхамшиг гэж би цаг агаар өөрчлөх чадварыг хэлж байгаа биш, гэхдээ бид тэгж ч бас чадна!” [27]

"Хүн уураг тархиныхаа таван хувийг л ашигладгийг эрдэмтэд баталчихсан. Бид зуун хувь бүгдийг нь ашиглаж чаддаг бол гээд төсөөлөөд үз дээ. Уураг тархиа зуун хувь ашиглаж чаддаг хүн бол Христ, Будда, Лууз өөр та хэнийг ертөнцийн агуу их ухаантан гэж үздэг вэ, тэр хүмүүс. Тэд бол бидний Бурханы Орон гэж нэрлэдэг оюун ухааны бүхэл бүтэн хаант улсад хүрч очих нууцыг мэддэг хүмүүс. Бүх юм дотоодод маань байж байдаг. Далайгаас давалгаа үүсдгийн адилаар энэ Бурханы Орноос уг сурвалжгүй хүн гэж нэгээхэн ч үгүй. Тэгвэл оюун ухааныхаа зуун хувь хяналтыг олж авах арга зам бий юу? Бий, олон зам мөр бий, зарим нь бусдыгаа бодохноо их цаг шаарддаг, зарим нь бусдаасаа илүү хүнд хэцүү байдаг. Зарим хүн мөргөж залбирч, мацаг барьж, хатамжил эдлэн суудаг. Эзэн Бурханыг эрж олохын тулд хүмүүс хэрхэн хамаг байдгаа золиосолж байсан энэ тухайд бид эртний билгүүн сургаал ном судраас уншдаг. Гэтэл хэрэв бид өнөөдөр энэ хатуу ширүүн зам мөрийг дагах юм бол энэ нь дэндүү хүнд бэрх, хэтэрхий их цаг шаардах болно. Бид тэгж нийгмээсээ тасраад шууд ширэнгэ ой руу явчихна гэж үгүй. Эрт цагт хүмүүсийн амьдрал нь хүсэл шунал, ая тухаар бага байсан. Өнөө үед ая тухтай байдлаас болоод дур сэтгэл татах зүйл асар их болжээ. Тэдний хувьд бол дур хүслийг нь татах зүйл бага, бясалгал дасгал хийж, Эзэн Бурханыг эрж олох чөлөө цаг их байжээ." [18]

"Эзэн Бурханыг яаж олох вэ? Тун энэрэнгүй, өршөөнгүй, нигүүлсэнгүй, билиг ухаант тэр зарчмуудыг эргэн баримталж, мунхгийн уршгаар үйлдсэн өнгөрсөн үеийн буруу үйлдэлдээ гэмшиж, түүнийгээ дахин давтахгүй гэж шийдсэнээр олж чадна. Ийм чин сэтгэлийн гэмшил наминчлалын ачаар Эзэн Бурханы гэрэл дахин цацарч, өнгөрсөн хамаг нүгэл хилэнц маань өршөөгдөнө. Энэ бол усаар бус, харин Ариун Сүнс, билиг ухаан учир зүйн гэрлээр адислах жинхэнэ баталгаа. Тийм ч учраас бид өнөө үед усан баталгаа хүртэхдээ Эзэн Бурханы гэрлийг олж үздэггүй, нүгэл хилэнцээсээ чөлөөлөгдсөн санагддаггүй, билиг ухаан маань

ч нээгддэггүй, гүн гүнзгий наманчлах сэтгэл сүнсэнд маань сэрдэггүй юм.” [21]

“Эзэн Бурханыг эрж олох нь мөнгө олох шиг тийм хэцүү биш гэж би боддог! Би мөнгө олох гэж наймаас арван цаг ажилладаг байхад их хэцүү байсан, тэглээ ч гэсэн энэ мөнгөө бид маш хурдан үрэн таран хийдэг. Гэхдээ бид ариг гамтай байвал, дөнгөж данган аргацаасаар, өтөл насанд хэрэглэх бага сага юм хурааж болох л доо. Харин хэрэв бид Бурханы Орныг олчих юм бол энэ нь үүрд мөнх байх болно. Бид оюун сэхээрэл, билгүүн ухаан, аз жаргал, баяр цэнгэл юу л олдогсон, хэзээд биднийх байж, түүнийг үрэн таран хийх арга байхгүй, мөн хэн ч түүнийг маань биднээс хулгайлж чадахгүй.” [18]

“Хүн бүр төрөлхийн Бурхантай, яагаад гэвэл Бурханы орон бидний дотор байдаг. Хүн бүрт байдаг болохоор түүнийгээ эрж олж чадна. Та ч мөн түүнийгээ олж чадна тэгэхдээ агшин зуурын дотор шүү гэдгийг би танд нотолж болох юм. Та үүнийг хүссэн даруйдаа л тэр дороо олоод авчихна, ийм хурдан. Гэхдээ ургуулах гэж тарьсан үрээ услах хэрэгтэйн адилаар дотоодын энэ мөн чанараа өдөр бүр тэжээн тэтгэх хэрэгтэй. Та өөрийн Бурхан чанараа өнөөдөр ч таньж мэдэж болно, гэхдээ нэлээдгүй бясалгасныхаа дараа Бурханы хутгийг олно. Учир нь бид харанхуй мунхаг байдалд их удсан тул дадал зуршил, өөртөө үл итгэх зангаасаа ангижран салахад урт хугацаа шаарддаг. Хүмүүсээр юу хийх ёстойгоо заалгаж, нүгэл хилэнцтэйгээ дуудуулсаар бид дасчихсан байдаг. Гэгээрсний дараа бидний тархи толгой саруулхан болж, хэчнээн агуу их гэдгээ мэдэрч, өөртөө илүү их итгэлтэй болно. Аръяабалын аргаар бясалгах тусам бид бол үнэндээ Христ юм, Христ шиг юм эсвэл Эзэн Бурхан хүнийг Өөрийнхөө дүр төрхөөр бүтээсэн тул Бурхан шиг юм гэдгээ өдрөөс өдөрт таньж мэдэх болно. Эзэн Бурхан хүнийг боол болог гэж бүтээгээгүй. Бид болон Эзэн Бурхантай нэг ижил мөн чанараас бүтсэн, цорын ганц ялгаа нь бид үүнийгээ олсон уу, үгүй юу гэдэгт л байгаа юм. Эзэн Бурхан бүгдийг ижил тэгш бүтээсэн, зарим хүн

үүнийгээ нээж, Христ шиг, Будда шиг агуу их болсон байтал, бусад нь үүнийгээ ололгүй, төрөл төрлийн туршид мунхгийн харанхуйд бүдчиж мөлхөж яваа ажээ.” [5]

## *Эзэн Бурханыг ухаарахуй*

“Эзэн Бурхан оршдог гэдэгт би та бүхнийг итгүүлэх гээгүй байна. Би та нарыг Эзэн Бурхантай холбож өгөхийн тулд л та бүхний дунд байгаа юм, ингэвэл та нар надад итгэж чадах юм. Би шашингүй үзэлтнүүдийг буруутгахгүй, учир нь тэд дотооддоо буй Бурханыг олж харахгүй байгаа юм шүү дээ. Нотолгоо байхгүй бол хүн бүр үүнд итгэх аргагүй. Өөрсдийн уг чанар, Бурханлаг мөн чанараа нээхийн тулд агшин зуурын гэгээрлийн замаар Эзэн Бурханыг олж үзэх боломжийг би Бурханд итгэдэггүй хүмүүст санал болгож байна.” [18]

“Харна гэдэг чинь итгэнэ гэсэн үг, ойлгож байна уу? Эзэн Бурханыг бидний ойлголтонд жаахан ойртуулж өгөхгүй юм бол Тэр хэтэрхий хийсвэр, хэт барьцгүй. Биднийг Түүнд яаж итгэнэ гэж Тэр бодоо вэ? Энэ бол мухар сүсэг. Чухам ийм учраас би гэгээрлийг эрж олохоор явсан билээ, яагаад гэвэл би зүгээр л Библи, бичиг судрыг уншчихаад өөрийгөө би Буддад итгэдэг, би Эзэн Бурханд итгэдэг, ингээд боллоо гэж хэлж чадахгүй байв. Тийм ээ, надад нотолгоо хэрэгтэй байлаа. Би өдөр болгон Эзэн Бурханд “Хэрвээ Та оршдог бол Таныг эрж олох, яаж ийгээд Тантай холбогдох арга замыг зааж өгөөч. Нүдийг минь, сонорыг минь нээж, ядахдаа Таны хайр энэрлийг харж мэдрэх боломж олгооч. Биднийг ямарваа нэг байдлаар харж хандаж байдгаа надад мэдрүүлж хайрла, мэдүүлж хайрла” гэж залбирч мөргөдөг байв. Тэгвэл гэгээрснийхээ дараа буюу авшиг хүртсэнийхээ дараа та Эзэн Бурхан таны талаар санаа тавьж халамжилж байдгийг өдөр болгон мэдрэх болно. Аль ч тал дээр, ямар ч нөхцөлд, өчүүхэн жижиг зүйл болон үлэмжийн том зүйл дээр ч үнэхээр ийм

байдаг. Эзэн Бурхан үнэхээр бидэнд санаа тавьж, хайрлан энэрч, зам мөрийг маань тэгшлэн засч байдаг. Тэр бидэнд осол аюул, өвчин зовлонгийн үед ч тусалдаг. Бидэнд хүнд үе тохиолдох болгонд Эзэн Бурхан тусалдаг юм, Тэр бүхий л арга замаар тусалдаг. Тэр үед та Эзэн Бурхан үнэхээр оршиж байдгийг мэднэ. Таныг хайрлаж, хамгаалж байгаа гайхалтай хайр энэрлийн хүчийг та мэдэрнэ. Энэ бол Эзэн Бурхан. Тийм учраас хүмүүс Эзэн Бурхан бол хайр гэж ярьдаг юм." [17]

Бид Бүхнийг чадагч Эзэн Бурханыхаа дэргэд байхын тулд зөвхөн өөдөө, тэрхүү дээдийн тансаг сайхан ертөнц тийш явах хэрэгтэй. Аврал, нигүүлслийн далай -энэ бол бидний Эзэн Бурхан гэж нэрлэдэг тэр зүйл. Түүнтэй ойр дотно гэдгээ мэдрэг гэж, Түүнд хүрч, Түүнтэй харилцаг гэж Тэр заримдаа биелж болох хэдий ч Тэр бол биет оршнол биш. Түүнээс биш Тэр бол ердөө л хайр, өршөөл, адислал, нигүүлслийн далай юм. Сайн сайхан, баяр жаргалтай бүхэн бол Эзэн Бурхан. Өөрсдөө одоогоор авшиг хүртээгүй байлаа ч, төрөлх билиг ухаан, угаас заяасан бурханлаг хүчээ мэдэхгүй байлаа ч ялгаагүй бид Эзэн Бурхан мөн билээ.

Хөршүүд, үр хүүхэд, найз нөхөд, садан төрөлдөө эсвэл ядарч зүдэрсэн хэнд ч хайр энэрлээ зориулах болгондоо та Бурханыг төлөөлж байдаг юм. Ойлгож байна уу? Тийм учраас ийм энэрэл, нигүүлсэл, өршөөл билиг ухаанаа бид хэдий чинээ их илтгэн гаргана, бид Эзэн Бурханд төдий чинээ ойрхон байдаг. Гэхдээ ийм утгаар Эзэн Бурханыг ойлгох нь дэндүү хязгаарлагдмал хэрэг. Бид удаа бүрт цөөхөн хэдхэн хүнд л тусалж чадна. Төгс утгаараа бол Эзэн Бурхан бүх ертөнцөд тусалж чаддаг юм. Тэгэхээр бидний хүрэхээр тэмүүлж байгаа зорилго энэ юм. Энэ бол Будда, Есүс нарын хүрч чадсан тэр зүйл." [3]

"Будда амьд ахуй үедээ дөрвөн сохор хүн зааныг тэмтэрч үзээд сэтгэгдлээ хэлсэн тухай түүхийг ярьжээ. Чихийг нь тэмтэрсэн хүн: "Өө, заан дэвүүр шиг, томоо дэвүүр шиг юм байна" гэж, хөлийг нь барьсан өөр нэг нь "заан байшингийн

баганатай адил юм" гэж, хамрыг нь тэмтэрсэн нь "заан усны хоолойтой адилхан байна" гэж, сүүлийг нь барьсан нь: "заан шүүр шиг юм" гэжээ. /Инээлдэв./ Бид Эзэн Бурханыг ингэж л хардаг юм. Эгэл хүмүүс Эзэн Бурханыг ингэж л хардаг, янз бүрийн дэстэй бясалгагчид Эзэн Бурханыг ингэж л хардаг. Тийм учраас Эзэн Бурхан бидний дотор, Будда бидний сэтгэл санаанд байдаг гэж хэлсэн хэрэг. Үүний утга нь ийм юм." [36]

"Орчлон ертөнцийн бүх зүйл энергиэс бүтсэн бөгөөд түүнийг бид туурвигч /бүтээгч/ хүч гэдэг, эсвэл Бүтээгч ч гэж нэрлэдэг, яагаад гэвэл энэхүү энерги бүх орчлонд, зүг бүрт тархан цацарч, янз янзын ертөнц, төрөлтөн болж хувирдаг. Тэгээд энэ төрөлтнүүд өөр өөрийн сэтгэлгээ буюу ухамсрын түвшинтэй болж, бие биетэйгээ хэрхэн харилцан шүтэлцэж байгаагаас хамааран өөр маягийн энергийг үүсгэнэ. Бид түүнийг хоёр төрөлд хуваадаг. Эхнийхийг нь эерэг энерги буюу Эзэн Бурханлаг чанар, оюун санааны хүч, Бурхан чанар гэдэг. Хоёр дахь төрлийг нь, сөрөг хүч, сайн сайхантай эсрэгцдэг хорт муугийн буюу харанхуйн хүч гэдэг.

Иймд сайн сайхан эерэг энерги нь сөрөг энергитэй зэрэгцэн оршиж байдаг. Хэрэв сахиулсан тэнгэр, дэлхийн хүмүүс зэрэг аливаа төрөлтөн сайн сайхан, эвлэрэл зохицол, хайр, нигүүлслийг төрүүлж, хамтран зүтгэж байвал энэ энерги нь сайн буюу Эзэн Бурханы хүч, эерэг хүчний төрөлд багтана. Хэдий чинээ олон төрөлтөн ийм сайн сайхныг үүсгэнэ, манай дэлхийн төлөв байдал төдий чинээ эерэг хүчтэй байх болно. Хэрэв бид, болоод өөр ямарваа нэг амьтан үзэн ядалт, муу санаа, бусад ямар ч хамаагүй сөрөг хандлага, үг хэл, үйл хөдлөл гаргавал дэлхийн төлөв байдалд хуримтлагдсан сөрөг нөөцөнд нэмэр болно. Үүнийг бид хорт муу зүйл гэдэг. Дэлхий дээр ч тэр, өөр бусад хүмүүсийн амьдардаг аль ч ертөнц дээр ийм хүч нь илүү их үзэн ядалт, дайн байлдаан болон үл зохицлыг авчирдаг." [40]

"Энэ нь цахилгаан гүйдэлтэй ижил, нэг нь сөрөг, нөгөө нь эерэг, тэгээд нэмэх хасах нь бие биетэйгээ холбогдмогц

эрчим хүч гаргана. Гэхдээ цахилгаан гүйдэл өөрөө эерэг ч бус, сөрөг ч бус, гэвч эерэг, сөрөггүйгээр цахилгаан гаргаж чадахгүй. Бүх юм яг үүн шиг байдаг. Эзэн Бурхан сайн ч биш, муу ч биш. Тэр зөвхөн үл ялгаварлахуй болоод хайр энэрлийн далай юм. Эзэн Бурхан үзэн ядахуй, бохир бузар, муу муухай, нүгэл хилэнцийн алиныг нь ч мэдэхгүй; Тэр сайн ба муу, сайхан ба муухайг хооронд нь ялгадаггүй. Тийм учраас бид Түүнийг Хайр, Өршөөлийн далай гэдэг юм. [4]

А. Та Эзэн Бурханы тухай ярихдаа "Тэр" гэж эр хүйс хэрэглэх юм. Бурхан эр үү, эм үү, үгүй бол хоёр хүйстэй юу, эсвэл аль нь ч биш үү?

Б. Микеланжелогийн Эзэн Бурхан шиг үү? Үгүй, энэ бол түүний Эзэн Бурхан, Микеланжелогийн л Бурхан. Та Эзэн Бурхан ямар харагддагийг үзэхийг хүсч байна уу? Энэ асуултыг хэн тавьсан бэ? Гараа өргөнө үү. Би танд яг одоо харуулаад өгье. Та юу? Ардаа байгааг хар, таны өмнө, баруун, зүүн талд байгаа хүмүүсийг хар, Эзэн Бурхан иймл харагддаг юм. Таны сэтгэл ханав уу? Эзэн Бурхан хэлэхдээ: *"Эзэн Бурхан хүнийг Өөрийнхөө дүр төрхөөр бүтээсэн"* гэсэн болохоор та Эзэн Бурханыг харахыг хүсч байвал хажуу дахь хүнээ хар. Хүн болгон дотооддоо Эзэн Бурханыг агуулж байдаг. Тийм учраас бие махбодон ханыг нэвт хар, тэгвэл та өөрийн болон бусад хүний дотоодод байгаа Эзэн Бурханыг олж харна. Бие биедээ Эзэн Бурханд хандаж буй мэт ханд, тэгвэл амьдрал өдрөөс өдөрт хэчнээн их өөрчлөгдөхийг үзнэ. [47]

А. Би өөрийн Бурханлаг гэрлээ хэрхэн илэрхийлэх вэ?

Б. Бурханы гэрэл танд байсан цагт л та түүнийгээ илэрхийлж чадна. Тийм учраас эхлээд Бурханы гэрэлтэй бол. Авшиг хүртсэний дараа та түүнийг илэрхийлж чадна. Бид мөнгөө хаана байгааг мэдэхгүй бол түүнийгээ харуулж чадахгүй, тийм үү? Бидэнд мөнгө байлаа ч, түүнийгээ хүмүүст үзүүлье гэвэл хаана байгааг нь мэдэх ёстой. Тиймээс таны дотоодод Бурханы гэрэл байлаа ч эхлээд түүнийгээ таньж

мэдэж, түүнтэй холбогдох ёстой, тэгсэн хойноо л түүнийгээ хүмүүст үзүүлж чадах юм. Надад гэрэл байгаа болохоор би танд үзүүлж чадна. Би гэрэлтэй. Надад гэрэл байдгийг би мэднэ.Танд ч бас байгаа, гэхдээ та мэдэхгүй. Үүнд л бидний хоорондын ялгаа байгаа юм." [46]

## *Гэгээрэл буюу агуу их сэхээрэл*

"Гэгээрэл гэдэг бол амьдралаас ч агуу, нүдээрээ харж бие эрхтнээрээ хүртэн мэдэрч чадах зүйлсээс ч агуу зүйлийг танин мэдэх үйл явц юм. Энэ бол эдгээрээс илүү ямар нэгэн агуу их зүйлийг таньж эхлэх, чухамдаа өөрсдийн маань дотоодод ч бас орших бүх орчлон ертөнцийг жинхэнэ эзэгнэгчийг таньж мэдэж эхлэх агшин юм.

Гэгээрэл нь дотоод сэхээрэлтийг илэрхийлдэг. Таны өдөр тутам ашигладаг хүчийг бодвол хавьгүй илүү агуу хүч чадал танд байна гэдгийг та ухаарч эхэлнэ. Ер нь бол бид биеэ тоосон аминч үзлийнхээ зааврыг дагаж явдаг, харин гэгээрснийхээ дараа Эзэн Бурханы зориг хүслийг дагадаг болно. Бид Түүнтэй холбогдмогцоо өөрсдийн жинхэнэ үнэ цэнийг ухаарч мэднэ. Гэхдээ бас даруу болно. Өөрсдийнхөө тухай хэдий чинээ их мэдэх тусмаа бид төдий чинээ даруу төлөв болдог. Орчлонд хүмүүн бидний ухаарал ойлголтоор шүүж, захирах аргагүй агуу их хүч байдгийг бид мэднэ. Ийнхүү бид даруу төлөв болохын зэрэгцээ асар хүчирхэг болно, учир нь бид дотооддоо агуу их хүч чадал агуулж, түүнийгээ өдөр бүр бусдын сайн сайхны төлөө зориулахад хэрэглэдэг. Христийн шашны томъёоллоор "дотоодод тань оршдог сүнс" буюу Бүхнийг Чадагч Эзэн Бурхан гэж нэрлэдэг тэрхүү эерэг энергийн жинхэнэ эх сурвалжтай дотооддоо холбогдонгуутаа бид урьд өмнө нь хаалттай байсан энэхүү эх булгаа нээдэг. Энэ эх булаг нээгдсэний дараа бид Христ шиг, Будда шиг хүчирхэг болж хувирна. Бид угаас заяасан энэ Бурханлаг хүчээрээ үй олон хүнд тусалж чадна, тэгээд улам даруу төлөв болно, яагаад

гэвэл хүн болгонд үүнтэй адил хүч чадал байдгийг бид харах учраас хэнийг ч амьд Бурхан гэж хүндлэх болно.” [58]

“Гэгээрэл бол Эзэн Бурханы бэлэг болохоос өглөг буян үйлдсэний үр дүн биш. Бид бүгдээрээ гэгээрэх буюу гэтэлж чадна. Тиймгүй бол, бид тийм найдваргүй байсан бол, хэрвээ зөвхөн буянтай хүмүүс л ингэж чадах байсан юм бол, Эзэн Бурхан яах гэж Есүс юм уу, Будда эсвэл Мухамедийг илгээсэн юм бэ? Тэгээд ч би хэн нь үнэхээр буянтан гэдгийг мэдэхгүй, учир нь “Гэгээнтэн бүрт өнгөрсөн үе бий, нүгэлтэн бүрт ирээдүй бий.” Бид тийм нүгэл хилэнцтэй улс биш. Энэ бол хуурмаг үзэгдэл, та нар үүнийг ойлгосны дараа буян нүгэл гэж огт үгүйг мэдэх болно. Үүнийг ойлгохын тулд харин бид их хөдөлмөрлөх ёстой. Аръяабалын бясалгал нь та бүхэнд өөрийнхөө төрөлх ариун чанар, эрхэм гарал үүслээ дахин нээх аргыг үнэ төлбөргүйгээр санал болгож байна” [26]

“Агуу их сэхээрэлтийг мэдрэнгүүтээ л би өөрөө бүтээгдсэн бүхэнд оршиж: эрвээхэй, шувуу, сахиулсан тэнгэр, чулуу эсвэл мод юу ч байсан тэдгээрээс баяр баяслыг мэдрэн, юм бүхэн байгаагаараа төгс төгөлдөр гэдгийг олж харсан билээ. Үүнийг үгээр тайлбарлахад хэцүү, гэхдээ хэрэв бид үүн лүү зорин тэмүүлвэл ухаарлын энэ түвшинд эцэстээ бүгд хүрч чадна, тэр цагт үүнийг өөрсдөө мэдчихнэ. Бидний хувьд хуурмаг үзэгдэл болон мөнх бус ахуйн талаар итгэл ойлголтыг маань төгсгөл болгох цорын ганц зам энэ мөн. Хүний ухаарал ойлголтоор юмсыг харахад бүгд өөр харагддаг ч, хэрэв бид нэн өндөр ухамсрын түвшинд орших юм бол бүх зүйл баяр баясгалантай, санаа зовох юмгүй, эерэг сайхан байдаг.” [14]

“Жинхэнээр гэгээрсэн цагтаа л бид юунд ч баясан цэнгэж чадна. Юу ч тохиолдлоо гэсэн бид жаргалтай байж чадна. Хэрвээ сайн юм тохиолдвол бид түүнийг Эзэн Бурханы бэлэг гэж сэтгэл зүрх, санаа бодолдоо ямарваа гэмшил, эргэлзэл, ямар ч хаалт саадгүйгээр хамаг сэтгэлийнхээ угаас хүлээж авна. Яагаад гэвэл гэгээрсэн хүн яг л хүүхэд шиг, маш

чөлөөтэй, огт санаа зовох юмгүй, огт ярвиггүй зантай байдаг. Хэрэв та түүнд ямар нэг сайхан юм өгвөл тэр үүнийг авчихна, та түүнийг хуурч мэхлэх гэж байна уу, тэр өөрөө ийм гавьяатай юу, үгүй юу гэж бодох ч үгүй, ердөө л авчихна. Бас тав тухтай, баян тансаг амьдрах боломжгүй нөхцөл байдалд бид адилхан л байгаадаа сэтгэл хангалуун амьдарсаар байна, асар их эд баялгийг хүсээд байх юмгүй. Гэхдээ энэ нь бид нийгмийнхээ төлөө ажиллахыг эрмэлздэггүй, дэлхийн иргэний хувьд үүрэг хариуцлагаа биелүүлэхийн тулд чадах бүхнээ хийдэггүй гэсэн үг биш. Бид ялгаа байхгүй хийдэг, дэлхий дахиныг тохинуулахад хувь нэмрээ оруулах ажлыг дуртайяа бүр ч илүү үр дүнтэй хийж байдаг. Ялгаа нь бид үүнийг хийхдээ гавьяа шагнал юм уу, сайшаал магтаал хүсэлгүйгээр хийдэг юм. Бид осолдож буруутлаа гэхэд, эсвэл хүмүүс сайн санааг маань ойлгохгүй байлаа гэхэд бид үүнийг тэсээд л гарна, зүрх сэтгэлээ ердөө шаналгахгүй .[51]

## *Туулан гэтэлгэх гурван зам мөр*

“Бидэнд туулан гэтлэх гурван зам мөр байдаг. Хамгийн хялбар нь болох итгэн дагах зам мөрийн тухай би ярьсан. Та ердөө л гэгээнтнүүдийн аль нэгэнд итгэн сүсэглэж, Түүнд мөргөн залбирч, таныг энэ хорвоог орхих үед адислаж, гэтэлгэж өгөхийг гуйгтун, тэгээд л та чөлөөлөгдөнө. Хоёр дахь зам нь Багшаас авшиг хүртэж, өөрөө Багш болох зам мөр. Энэ нь зөвхөн өөрийгөө төдийгүй хамаг амьтад хийгээд гэр бүлийнхнээ аварч чадах учраас хамгийн эрхэм зам юм. Ингэх нь илүү эрхэм буянтай хэрэг бөгөөд тэгээд ч энэ бол Эзэн Бурхан болоод Багшийн биднээс хүсч байдаг тэр зүйл мөн. Хэрвээ хүн Багш болчихвол Бурханы орноос тамын орон хүртэлх тэр үй олон амьтныг аварч чадна. Багш хүн аль ч түвшинд хүрч, ямар ч амьтныг аварна. Өөрийгөө гэтэлгэх гурав дахь зам нь авшиг хүртсэн хүний садан юм уу найз байх явдал бөгөөд та нэгэнт нас нөгчсөн байсан ч хамаагүй. Та нас

нөгчөөд хэдийнээ тамд уначихсан байлаа гэж бодоход таны ач охин агуу их Багшаас авшиг хүртэх юм бол та нэн даруй чөлөөлөгдөж тэнгэрийн оронд очих болно. Бас хэрвээ бид авшиг хүртсэн хүний найз нөхөр нь байвал мөн л Багшийн тусламжийг хүртэнэ.

Гэтлэн чөлөөлөгдөх ийм гурван зам байна. Мэдээж хэрэг, хүн өөрийгөө сахилгажуулах замыг би илүүд үздэг, учир нь тийн авшиг авч, өөрийгөө танин ухаарахуйд хөтлөх дэг журмыг мөрдөж эхэлснээр бидний өнгөрсөн, одоо, ирээдүй үеийн садан төрлүүд бас гэтэлдэг. Учир нь эдгээр үе үеийн хамаатан садан маань бидэнтэй олон олон төрөл, үе удмыг дамжин үргэлжилдэг авлага өглөг, шалтгаан үр дагаварыг томьёологч “Үйлийн Үрийн Хуулиар” холбогдсон байдаг.” [10]

А. Хэрвээ сүнс нэгэнт сэрж сэргэсэн бол тийнхүү идэвхтэйгээр сэргэсэн хэвээр үлддэг үү?

Б. Тийм ээ, үргэлж тийм. Бие махбод унтаж болно, бодол сэтгэл элдэв асуудалд орооцолдож магад, харин сүнс хэзээ ч дахиж ингэхгүй. Нэгэнт сэрсэн сүнс хэзээд сэрсэн чигтээ л байдаг. Гэхдээ дээд зэргээр хөдөлмөрлөж, ертөнцийн тусыг илүүтэй бүтээхийн тулд ухаан санаа, бие махбод болон сэтгэл хөдлөлөө бид сүнсний удирдах хүчин доор нэгтгэн ажиллуулах ёстой. Тийм учраас авшиг хүртсэний дараа бид гэгээрлийн амтыг мэдэрч, өөрийгөө таньж мэдсэн ч гэлээ, сүнснийхээ гэгээрсэн байдалд сэтгэл бодлоо дасгахын тулд, биет ертөнцийн түвшин, хоцрогдсон үзэл баримтлал ба юмыг хийдэг зуршмал арга барилдаа буцаад живчихгүйн тулд бясалгал дадлаа үргэлжлүүлсээр байдаг.” [28]

## *Агшин зуурын гэгээрэл*

Агшин зуурын гэгээрэл гэдэг нь тэр дорхноо гэгээрэх гэсэн утгатай. Энэ агшинд өөрийнхөө дотоодын Төгс Дээд Багшаа харахын тулд хүн сууж эхэлнэ. Дотоодын Багш бол

жинхэнэ мөн чанар тань юм. Энэ мөн чанар нь үнэхээр таных бөгөөд төрөхөөс тань өмнө, таныг шунал, тачаал, үзэн ядахуйд автахаас өмнө танд угаасаа байсан юм. Энэ мөн чанар бол үнэхээр таны Төгс Дээд Багш юм. Та энд ирэхдээ сэтгэлээ нээж, Түүний юу зааж сургахыг сонсох ёстой, тэгвээс та агшин зуурын гэгээрлийг олж авна. Тийм учраас үүнийг бичих тэмдэглэх, сургаж зааварлах шаардлага байхгүй." [62]

"Эгэл жирийн үг хэлээр энэ бүх хийсвэр үзэл санааг та нарт хүргэх амаргүй, гэхдээ энэ нь бидний гүн дотор агуулагдаж байдаг өөрсдийн маань нэгээхэн хэсэг гэдгийг нэгэнт ойлгохоор бидэнд амархан, асар аз жаргалтай санагддаг. Гэхдээ энэ нь оюун санааны гэгээрлийн нэг л хэлбэр юм. Зэн Буддизмын бясалгалд үүнийг заримдаа Гэнэтийн буюу Агшин Зуурын Гэгээрэл гэдэг юм. Учир нь багшийн нэг л үг биднийг зарим талаар эсвэл бүр нэлээн ихээр, эсвэл бүрэн төгс чөлөөлдөг.

Гэхдээ бид гэгээрснийхээ дараа буюу, Багшийнхаа хэлэх гэсэн зүйлийг хэдийнээ ойлгосны дараа яагаад бясалгалаа байнга хийж байх хэрэгтэй байдаг вэ? гэдгийг дахин тодруулъя. Яагаад гэвэл бид хэтэрхий их дадал зуршил, хэтэрхий их мэдлэгтэй байна, иймд гэгээрсэн гэдэгт маань итгүүлэхэд ганц удаагийн бясалгал хангалтгүй. Бид дараа өдөр нь л энэ тухай мартаж орхино. Тийм учраас сэтгэл маань үүнийг бүрэн хүлээн авах хүртэл бид гэгээрлийн энэ ахуй ойлголтыг давтаж байх ёстой. Жинхэнэ Мөн Чанар өөрийгөө таньж мэдэх нь хангалттай биш, учир нь жинхэнэ Мөн Чанар өөрийгөө яагаад ч хэзээд мэдэж байдаг. Харин гэтэл бид энэ ертөнцөд байгаа болохоор бүх зүйлийг нөгөө оюун ухаан гэдэг компьютер, багажаараа хийх хэрэгтэй болдог. Энэ багаж бол ирээдүйд ирэх үр хүүхдийнхээ төлөө энэ гаригаа илүү сайхан болгохын тулд дэлхий дээр ажиллахдаа, эмх цэгцгүй орчинд хайрын хүч хийгээд адислалыг түгээхдээ ашиглах хэрэгтэй болдог багаж хэрэгсэл юм." [61]

А. Эртний Египтэд жишээлбэл, авшиг хүртэхэд наад зах нь долоон жил болдог байж. Ихэнхдээ авшиг гэдгийг ер нь урт удаан хугацааны үйл явц, хэн давж туулсан нь гэгээрэх хувьтай гэж үздэг. "Та яг одоо гэгээрч болно" гэх нь орчин үеийн амьдралтай маань зохицож байгаа ч юм шиг. Яаж ийм юм байж болдог юм бол?

Б. Эрт цагт аливаа нэг Багшийг олоход тийм ч амар хялбар байгаагүй. Хэрэв Багшийгаа олбол Багш нь шавиа, тухайлбал, Төвдийн Мялрайваг сорьсон шиг олон жил сорьж шалгадаг байсан. Түүнийг дөрвөн жилийн турш маш их загнаж, зарим үед зодон байж шалгажээ. Харин өнөө үед Багш ингэх юм бол шоронд сууна биз дээ! (Инээлдэв.) Ингэхийг зөвшөөрөхөө больсон, түүнээс гадна манай дэлхий энэ өндөр хурдацтай, хөгжингүй амьдралын улмаас шавь нараа шалгах иймэрхүү аргатай зууралдаж болохгүй болжээ. Өнөөдөр бид орчин үеийн нийгмийн хурдацтай хөл нийлүүлж явах ёстой. Шавиа засч тэгшлэн, түүгээр асар үнэ цэнэтэй тэр зүйлийнх нь төлөө зүтгүүлэх цаг хангалтгүй болохоор Багшид илүү их яршиг түвэгтэй байх нь мэдээж юм. Хэрвээ Багш ингэвэл юу болно гэж та бүхэн бодож байна? Гэгээрэлд хүрэх шавийн зам хэчнээн илүү уртсах вэ? Урт хугацаа шаардана. Гэгээрэх бол маш хурдан зүйл шүү дээ, харин долоон жилийн үйл явц нь шавийг сорьж, ёс суртахууны сахилга батад сургахад зориулагддаг юм. Энэ бас тун сайн хэрэг л дээ, гэхдээ үүнээс болоод эрт цагт тийм ч олон хүн гэгээрсэнгүй. Хүмүүс мунхаг байсан учраас л Христыг загалмайд цовдолсон, гэгээрэл гэж юу юм, бясалгал гэж юу юм гэдгийг цөөхөн хүн мэддэг байж; энэ нь цоо шинэ, маш сонин зүйл байсан хэрэг. Тиймээс шавь нараа гэгээрлийн нэн өндөр дэс, чанд ёс суртахууны түвшинд хүргэх гэж өнөөдөр олон Багш хүч чадал, хөрөнгө мөнгө, цаг заваа золиослон бясалгалын эрдмийг өргөн олон түмэнд нээж байна. Цаг өөр болсон, түүнээс гадна гэгээрэл гэдэг нь бүрэн төгс гэгээрчихсэнийг илтгэж байгаа биш. Гэгээрлийн амтыг мэдэрсэн хүн цаашид үүнийгээ гүнзгийрүүлэн үргэлжлүүлэх урам зоригтой болдог.

Эрт цагт Багш нар ингэдэггүй байсан. Хүнийг эхлээд гэгээрлийн төлөө зүтгүүлж үнэхээр зовооно, тэгэхээр үнэ цэнийг нь илүү мэдэрдэг байсан юм."[54]

А. Гэгээрсэн хүн юу ч боддоггүй, юу ч хийдэггүй, тэр ердөө л ажиглагч бөгөөд шийдвэр гаргадаггүй гэж ярьдаг. Энэ ертөнцөд юу ч сонгохгүй, юу ч хийхгүйгээр яаж амьдрах вэ? Үүнээс гадна хүний үйлдэл нь байгалийн эмх журмыг алдагдуулдаг, иймд энэ тэнцвэргүй байдлыг нөхөх гэж /хариуд нь/ байгаль өөрөө эсрэг зүйлийг бүтээдэг гэдэг. Та үүнтэй санал нийлэх үү?

Б. Та эхлээд гэгээрэлд хүрэх хэрэгтэй, тэгвэл та юу болж байдгийг мэдчихнэ! Хийхгүйгээр хийнэ гэдэг бол та амьдралгүй, сэтгэхгүй, сэтгэлгүй байх гэсэн үг бус харин ердөө л аливааг аяндаа хийнэ гэсэн үг. Үүнээс хойш та шийдвэр гаргах хэрэггүй болно гэдэг нь үнэн. Та гагцхүү Эзэн Бурханы хүсэл зоригт зохицуулан хийж, яах ёстойгоо яг таг мэднэ. Хөндлөнгөөс харахад та бусадтай адилхан хийж байх шиг боловч энэ нь тийм биш, учир нь таны үйлдэл бүрийг Эзэн Бурхан хэлж өгөх болно. Цаашид танд хариуцлага гэж байхгүй болж, та хэзээд хамаг чадлынхаа хэрээр л хийдэг болно. Гэхдээ энэ нь аливааг бодож сэтгэхгүй хийж байгаа хэн ч байсан хамаагүй Эзэн Бурханы хүсэл зоригийг биелүүлж байна гэсэн үг биш, яагаад гэвэл тийм хүн Эзэн Бурханы хүсэл зоригийг мэдэхгүй. Гэгээрсний дараа л бид Эзэн Бурханы уг Төлөвлөгөөг мэдэх болж түүнд зохицуулан хийнэ. Гэгээрэхээс өмнө бол бид Бурханы төлөвлөгөөнд өөрийнхөө хүсэл зоригийг тулгах гэж оролдоод үүнийг гагцхүү эмх цэгцгүй байдалд оруулж байдаг. [26]

А. Ухамсрын хэчнээн түвшин байдаг, аль түвшинд нь байгаагаа яаж мэдэх вэ?

Б. Үнэн Мөрийн хамгийн дээд түвшинд хүрэхээс өмнө бид ухамсрын таван түвшинг туулах ёстой. Дотооддоо харж байгаа гэрлийн эрчим, гэрлийн хэмжээ, түүнчлэн дотооддоо харж байгаа байгаль, бурхны орны дүр зургаар түвшинг тодорхойлж болно. Өөр нэг арга зам нь дуу

аялгуугаар тодорхойлох. Ухамсрын түвшин бүр өөрөөр хэлбэлзэж байдаг, ямар дуу нь ямар түвшинтэй тохирч байдгийг мэдсэнээр бид юунд хүрээд байгаагаа их бага ямар нэг байдлаар тодорхойлж чадна. Хэсэг хугацааны дараа та туршлага хуримтлуулж, хэн аль түвшинд байгааг тэр дор нь мэдэх болно. Дотоодын дэвшлээ бид гадна талын үйлдлээрээ, жишээлбэл, илүү энэрэнгүй, илүү эвлэрэнгүй, хүн төрөлхтний тусыг илүү их бүтээдэг болсон зэргээрээ тодорхойлж болно.”[46]

## *Энэ ертөнцийн чанадад*

Манай ертөнцийн чанадад өөр олон ертөнц бий. Түвшин бүр нь дангаараа нэгэн ертөнц бөгөөд бидний ойлголтын түвшинг илэрхийлдэг. Энэ нь сурах явцад дамжин өнгөрдөг анги бүр нь бидний үзэж буй зүйлээ ойлгож ухаарсан хэр хэмжээ, дээшлэн ахиж байгааг илтгэн харуулдаг их сургуулийг санагдуулах ба бид ийнхүү аажим ахисаар сургуулиа төгсдөгтэй адил юм. Асурийн ертөнцөд бид ид шид гэж нэрлэдэг олон гайхалтай зүйлийг үзнэ. Бид өвчтэй хүнийг эмчилж, бусад хүний нүдэнд харагдахгүй зүйлийг олж үзэж чадна. Наад зах нь зургаан төрлийн ид шидийн хүчтэй болж, ердийн зүйлээс цааш далдыг харж, орон зайн хязгаараас цаадхийг сонсож чадна. Бидний хувьд орон зай хамааралгүй болох бөгөөд үүнийг тэнгэрлэг үзэхүй, тэнгэрлэг сонсохуй гэж ярьдаг юм. Тэр цагт бид хүний бодож буй зүйлийг нэвт харж, тэр байтугай заримдаа хүний ой дурсамжид юу байгааг үзэж чадна. Бурханы орны нэгдүгээр түвшинд хүрэхэд энэ бүх боломж чадвар нээгддэг.

Хэрвээ бид жаахан дээшилж хоёрдугаар түвшинд очвол, ойлгоход амрыг бодож «хоёрдугаар ертөнц» гэе, хоёрдугаар ертөнцөд биднийг нэн их авьяас чадвар түүний дотор нэгдүгээр ертөнцөд байдаггүй ид шидийн чадвар хүлээж

байдаг. Гэхдээ хоёрдугаар ертөнцөд хүрээд олж авдаг авьяас чадваруудын дотроос хамгийн гайхамшигтай нь – уран илтгэх чадвар болон маргах урлаг юм. Хоёрдугаар ертөнцөд хүрсэн хүний оюун ухааны хүч чадал оргилдоо хүрч, гайхалтай уран илтгэх чадалтай болсон байдаг тул хэн ч түүнийг давж дийлэхийн аргагүй.

Дунд зэргийн оюуны чадвартай юмуу I.Q (Ай-Кью: оюун ухааны итгэлцүүр. орч.) нь өндөр биш хүмүүс I.Q нь ер бусын өндөр ийм хүнтэй өрсөлдөж чадахгүй. Гэхдээ энэ нь уураг тархины физик чадварын хөгжил төдий зүйл биш, бидний дотоодод угаас байдаг төрөлхийн билгүүн ухаан, нууцгай тэнгэрлэг хүч чадал болно. Тэр нь л нээгдсэн хэрэг. Энэтхэгт энэ түвшинг “Буддхи” гэж нэрлэх бөгөөд энэ нь “оюун ухааны түвшин”-г илтгэдэг. “Буддхи”-д хүрвэл та Будда болно. “Будда” гэдэг үг нь эндээс гаралтай юм. Тэгэхээр Будда гэдэг нь чухамдаа үүнийг илэрхийлдэг байх нь. Гэхдээ энэ бол эцэс төгсгөл нь биш ээ. Үүнээс цааш нэн өндөр ертөнц бий. Гэгээрсэн хүнийг хүмүүс Будда гэдэг. Хэрвээ тэр хүн хоёрдугаараас дээш орших ертөнцийг мэддэггүй бол үүгээрээ сэтгэл нь бахархана. Өөрийгөө үнэнээсээ амьд Будда гэж бодохын зэрэгцээ шавь нар нь ч түүнийг Бурхан хэмээн өргөмжилж бахархана. Үнэн хэрэгтээ хоёрдугаар ертөнцөд нэгэнт хүрч аль дуртай хүнийхээ өнгөрсөн, одоо, ирээдүйг нэвт үзэж, дээд зэргийн уран илтгэх чадвартай болсон нь Бурхны Оронд хүрэх зам мөрийн эцэс биш.

Бидний хүссэн ч, эс хүссэн ч ид шидийн гэгддэг өдий төдий зүйл тохиолддог, учир нь оюун ухаан маань нээгдэж, амьдралаа амар амгалан, илүү сайн сайхан болгохын тулд эмчлэн анагаах, эвсэн зохицохуйн дээд эх сурвалжтай яаж холбогдохоо бид мэдчихсэн байдаг.

Гуравдугаар ертөнц гэдэг бол илүү дээд шат мөн. Гуравдугаар ертөнцөд хүрье гэсэн хүн наад зах нь энэ ертөнцийнхөө өр төлөөсийг бүгдийг нь төлж, бүрэн ариусах ёстой болдог. Хэрэв бид энэхүү материаллаг ертөнцийн эзэнд ямар нэг өр төлөөстэй бол дээш дэвшихийн аргагүй. Хэрэв

та аль нэг улсын хууль ёсыг зөрчсөн гэмт хэрэгтэн бол хил давж өөр улсад орж чадахгүйтэй адилхан. Энэ ертөнцийн өр төлөөст урьд ба энэ төрөлдөө бидний хийсэн үйл, мөн энэ биед оршихдоо ирээдүйд бидний хийх үйл зэрэг олон зүйл хамаарна. Тэгэхээр үйлийн үр гэж нэрлэгддэг энэ бүх зүйлийг төлж барагдуулсан байх хэрэгтэй.

Одоо та бүхэн гуравдугаар ертөнцийг туулчихлаа гэж бодьё, дараагийнх нь юу вэ? Мэдээж та нар дараагийн бүр өндөр дээд дөрөвдүгээр ертөнц үрүү явна биз. Дөрөвдүгээр ертөнцөд гайхаж сонирхмоор зүйл юу ч байхгүй. Энэ ертөнцийн тухай хүмүүст эгэл жирийн үг хэлээр өгүүлж Эзнийг нь гомдоох вий. Учир нь энэ ертөнц өгүүлшгүй гоё сайхан юм. Гэхдээ зарим газар нь гэрэл тасарсан Нью-Йоркийн шөнөөс илүүтэй харанхуй байдаг. Гэрэл гэгээнд хүрэхээс өмнө бол бүүр ч их харанхуй байдаг. Ямар нэг хориотой хот мэт. Эзэн Бурханыг таньж мэдэхээсээ өмнө бид тэнд зогсох хэрэгтэй болно. Гэвч Багштай, туршлагатай Багшийнхаа хамт бол та нэвтрэн гарч чадна. Үгүй бол бид энэ ертөнцөд замаа олж чадахгүй.

Оршихуйн янз бүрийн давхарга буюу түвшинд хүрэх үедээ бид зөвхөн оюун санааны хувьд өөрчлөгддөг төдийгүй амьдралын бусад бүх тал дээр бие махбод, оюун ухааны хувьд өөрчлөгддөг юм. Бид амьдралыг өөрөөр харж, өөрөөр хөдөлж, өөрөөр ажилладаг. Тэр байтугай өдөр тутмын маань ажил төрөл шинэ утга учиртай болж, бид яагаад ингэж ажилладаг, яагаад энэ ажлыг хийх ёстой юм, эсвэл яагаад энэ ажлаа өөрчлөх ёстой юм гэдгээ ойлгож мэднэ. Амьдралынхаа учир зорилгыг ойлгож мэдээд цаашдаа хий дэмий бухимдаж шаналахаа больж, харин ч газар дэлхий дээр ирсэн томилолтоо дуусахыг тэвчээртэй, дуулгавартай хүлээх болно. Яагаад гэвэл үүний дараа бид хаана очихоо мэддэг болно. Амьд байхдаа л бид үүнийг мэдчихнэ.

Ингээд, үүний дараа та илүү дээд түвшинд хүрнэ. Дөрөвдүгээр Ертөнцийн дараа та дараагийн өндөр дээд түвшинд очно. Энэ бол Тавдугаар Ертөнц болох гэгээрсэн Багшийн гэр юм. Гэгээрсэн Багш бүхэн тэндээс ирдэг. Тэдний

зэрэг дэс нь Тавдугаар Ертөнцөөс өндөрт байсан ч тэд тэнд л суудаг. Энэ нь гэгээрсэн Багш нарын гэр юм. Энэ түвшнээс цаашилбал Эзэн Бурханы өөр олон илрэл байх бөгөөд тэр болгоныг ойлгож ухаарахад амаргүй. Тав дахь түвшинд хүрсний дараа та хүссэн тийшээгээ явж болно.

Тав дахиас дээш олон түвшин бий, гэхдээ тав дахь түвшинд байх нь илүү тухтай, илүү тохиромжтой байдаг юм. Дээшээ бол хэт их хүчтэй байдаг. Та түр хугацаагаар очиж болох ч тэнд үлдэхийг хүсэхгүй байх.

Эзэн Бурханд бидний төсөөлж ч чадахааргүй олон тал бий. Бид хэдийчинээ дээш гарна, төдийчинээ их хайр энэрэл олно гэж дандаа боддог. Гэвч хайр олон янз байдаг. Догшин хайр, хүчтэй хайр, зөөлөн хайр, зүгээр л нэг хайр гэж байдаг. Бидний хүлээж авах савны хэмжээнээс хамаарч, Эзэн Бурхан бидэнд янз бүрийн түвшний Хайр өгдөг. Гэхдээ заримдаа тэр нь дэндүү хүчтэй, биднийг цуулан тасчиж байх шиг санагддаг.

42

# Багш нар гэж хэн бэ?

Цаглашгүй Их Багш Чин Хайн тавьсан лекцээс

Багш гэдэг бол хаанаас ирснээ мэддэг, үүнийг эрж хайж байгаа хүмүүстэй энэрэнгүй сэтгэлээр мэдлэгээ дуртайяа хуваалцаж, энэ ажлынхаа төлөө төлбөр төлөөс авдаггүй хүмүүс. Тэд хамаг цаг хугацаа, хөрөнгө мөнгө, хүч энергиэ энэ дэлхийн төлөө зориулдаг юм. Эрдэм чадварын энэ түвшинд хүрмэгцээ бид уг гарлаа мэдээд зогсохгүй бас өөрсдийн жинхэнэ үнэ цэнээ таньж мэдэхэд нь бусдад тусалж чаддаг. Багшийн заасан замыг дагаж байгаа хүмүүс жинхэнэ сайн сайхан, жинхэнэ гоо үзэсгэлэн, жинхэнэ мэдлэгээр бялхсан цоо шинэ ертөнцөд үтэр түргэн хүрнэ. Гадна ертөнцийн бүхий л гоо сайхан, эрдэм ухаан хийгээд буянт үйлс нь жинхэнэ дотоод ертөнцийн маань тухай сануулахын тулд л байдаг юм. Сүүдэр хэчнээн сайхан байлаа ч жинхэнэ зүйл шигээ тийм сайхан байж хэзээ ч чадахгүй. Гагцхүү жинхэнэ юм л гэрийн эзэн Эзэн болох сүнсийг маань амарлиулж чадна.”[57]

“Багш гэдэг бол хэдийнээ Өөрийн Мөн Чанарыг таньсан, өөрийгөө ухаарч мэдсэн хүн юм. Тийм учраас Багш хүн агуу их ухаан болох Эзэн Бурхантай харилцаж чаддаг, учир нь энэ нь бидний дотоодод оршиж байдаг юм. Чухам тийм учраас Тэрбээр энэ баяр баясгаланг хуваалцахыг хүсч буй хэн бүхэнд тэрхүү мэдлэг, тэрхүү сэхээрүүлэгч хүч чадлыг дамжуулж чадна.

Нэг талаар бидэнд Багш гэж үнэндээ байдаггүй юм. Гагцхүү шавь нар нь өөрсдийгөө эзэн, багш гэдгээ таньж мэдэх чадвартай болтол тэднийг удирдан чиглүүлэхийн тулд л Багш хэмээгсэд хэрэгтэй байдаг. Гэхдээ бид гэрээ хэлцэл буюу тиймэрхүү зүйл байгуулдаггүй. Мэдээж хэрэг, та эцсийг нь хүртэл явна гэж өөрөө өөртэйгээ гэрээ хийнэ, энэ нь өөрийн тань тусын тулд юм. Авшиг хүртэнэ гэдэг бол агуу их сүнсээ анх удаа танин ухаарах агшныг л илэрхийлж байгаа юм, ердөө л энэ.” [58]

“Багш газар дэлхийд амьдарч байх цагтаа хүмүүсийн үйлийн үр, ялангуяа Багшид итгэдэг хүмүүс түүний дотор шавь нарынхаа үйлийн үрийг бүр ч илүү ихээр өөртөө авдаг. Энэ үйлийн үрийг арилгаж үгүй хийх ёстой. Тийм учраас Багш амьдрах хугацаандаа шавь нарынхаа төлөө болон нийт хүн төрөлхтний төлөө зовж зүдэрч байдаг. Энэ нь түүний бие махбод дээр илэрдэг. Тийм учраас бие нь өвдөж мэднэ, түүнийг эрүүдэн тамлаж, загалмайд цовдлон хадаж, гүжирдэн гүтгэж мэднэ. Ямар ч Багш иймэрхүү зүйлийг туулах ёстой болдог. Будда, Мухамед, Христ болон Дорно, Өрнийн өөр олон Багшийн амьдралын жишээнээс та бүхэн үүнийг мэднэ. Тэдний хэн нь ч мөрдлөг хавчлагагүй, амар тайван амьдарч байгаагүй. Хүн төрөлхтний төлөө Багш өөрийгөө золиослох гэж үүнийг хэлдэг юм. Гэхдээ үйлийн үрийг үүрч зовохын тулд Багш бие махбодтой байх учиртай, учир нь энэ дэлхий дээрх үйлийн үр нь биет бодит шинжтэй. Хэрвээ та хүмүүсийг биет үйлийн үрээс нь аврахыг хүсвэл танд физик бие махбод хэрэгтэй болдог. Тийм учраас хамаг зовлон бэрхшээлийг

өөртөө үүрэхийн тулд Багш бие махбодтой байх ёстой.“ [26]

“Тусламж дэмжлэг хэрэгтэй байгаа хүмүүст туслах гэж Багш дэлхий дээр байдаг. Гэхдээ Тэр энэ дэлхий дээр байдаг ч юм биш, энэ дэлхийд татагддаг ч юм биш, Тэр энэ дэлхий болоод энэ дэлхий дээрх өөрийн амжилт, алдааны алинд ч хүлэгддэггүй. Есүс алдар хүндийнхээ оргил үед яасныг та бүхэн мэднэ. Үхэх ёстой л бол үхэхэд бэлэн байсан. Есүс Өөрийнхөө үхлээр бүхнийг огоорох гэж юу болохыг хүн зонд үзүүлсэн. Алдар нэр, амь настайгаа зууралдаагүйгээрээ тэр Эзэн Бурханы хүсэл зоригт захирагдахыг сургасан. Тэрбээр Эзэн Бурханы хүсэл зоригийг үргэлж дагаж байхыг бидэнд ийнхүү сургасан билээ.” [28]

## *Жинхэнэ Багшийг хэрхэн таних вэ?*

“Энэ маш амархан! Юуны өмнө, жинхэнэ Багш өөрийнхөө ашиг тусын төлөө ямар ч өргөл барьц авдаггүй, яагаад гэвэл Эзэн Бурхан зөвхөн өгдөг болохоос хэзээ ч авдаггүй юм. Хоёрдугаарт, Багш танд гэгээрлийн ямар нэг нотолгоо өгөх ёстой. Жишээлбэл, хэн нэгэн Багш өөртөө гэрэл бий гэж баталж байгаа бол Тэр танд ямар нэг гэрэл өгөх юм уу Эзэн Бурханы Дуу хоолойг сонсох нотолгоо өгөх ёстой. Танд гэрэл ба Эзэн Бурханы Үгээр нотолгоо өгч чадаж байвал та тэр хүнд итгэж болох юм. Гүрү /Багш/ гэдэг нь “гэрэл өгөгч”, “харанхуйг үлдэн хөөгч” гэсэн утгатай. Тиймгүй бол Тэр танд үнэхээр ямар нэг зүйл өгч чадах эсэхийг та хэрхэн мэдэхсэн билээ." [3]

“Хуурамч Багш өөрийн бага сага ид шидээ үргэлж зарлан гайхуулдаг бол жинхэнэ Багш хэзээ ч ингэдэггүй. Хэрвээ Түүнд шидийг бүтээх хэрэг гарвал үүнийг нууцхан хийдэг. Энэ тухайд зөвхөн шавь нь л, тэгэхдээ өөрийг нь аюултай байдлаас аврах, өвчин эмгэгийг нь анагаах, сэтгэл

санааны хувьд нь туслах юм уу, оюун санааны дэвшлийг нь түргэтгэхэд зайлшгүй хэрэгтэй болох тийм тохиолдолд л мэддэг. Тэр үед шавь нь Багшийнхаа үнэ цэнийг ухаарч мэднэ. Жинхэнэ Багш зөвхөн өгч л чаддаг, хэзээ ч авдаггүй юм. Шавь нар нь сэтгэл хангалуун амьдарч байхад харин Багш нь зовж зүдрэхээс өөр аргагүй болдог. Тийм учраас Есүс хүн төрөлхтнийг дээшлүүлэх ёстой байсан, загалмайд цовдлуулахаас өөр аргагүй болсон гэцгээдэг. Тэр ямар ч онцгой эрх дарх эдлэх аргагүй байж. Тийм учраас хүмүүс Түүнийг загнаж зүхэж, цовдлон хаджээ. Яадаг байлаа ч гэсэн та нар энэ бясалгалын аргыг сурвал Эзэн Бурханы хүч чадлаар зуун хувь хамгаалуулна. Хүн бүхэн цэнгэл жаргалтай байхын төлөөнөө Багш хүн л ганцаараа элдэв бүх зовлон зүдгүүрийг үүрдэг. Гэхдээ эцэг эх байхын баяр жаргал үүнд л байдаг! Үр хүүхдүүд нь бүх талаар тав тухтай амьдарч харин эцэг эх нь тэднийг хэрэгтэй бүхнээр хангахын тулд ажиллахаас өөр аргагүй бөгөөд мөн хамаг хариуцлагыг үүрч байдаг билээ.” [4]

“Жинхэнэ Багш юмыг хэзээ ч хувиа хичээсэн сэдлээр хийдэггүй. Түүний ухаан санаа, сэтгэл зүрх нь бусдын сайн сайханд бүрэн зориулагддаг. Газар дэлхийд оршин байх цагтаа Багш Өөрт нь итгэдэг хүмүүс, ялангуяа шавь нарынхаа зарим үйлийн үрийг өөртөө авдаг. Тэдний үйлийн үр арилж үгүй болох ёстой байдаг бөгөөд Багш шавь нарынхаа төлөө, нийт хүн төрөлхтний төлөө зовж зүдрэх болдог юм. Тэр амьдарч байхдаа зовж зүдэрнэ, тэгээд энэ нь бие махбодод нь илрэн гардаг. Тийм учраас Тэр өвчин эмгэг тусч мэднэ, Түүнийг мөрдөж мөшгин, загалмайд цовдолж, гүжирдэн гүтгэж, эрүү шүүлт тулгаж магад. Багш болгон үүнийг туулан гарах ёстой болдог.” [3]

А. Өөрийнхөө Багшийг хэрхэн таних вэ? Хүнд амьд сэрүүн буй Багш нэгээс олон байж болох уу?

Б. Нэг л хангалттай гэж би бодож байна. Нэг Багшаас сурахад л хэдийнээ маш их юм сурах хэрэгтэй болдог, та яаж хоёр гурван Багшаас сурч амжих юм бэ? Хоёр Багшаас сурах

нь байтугай та дагаж ч амжихгүй! Янз бүрийн түвшний Багш байдаг, та үүнийг мэдэх хэрэгтэй. Энэ насандаа чөлөөлөгдөхийн тулд хамгийн дээд, хамгийн сайн Багшийг таньж олохын тулд залбирч мөргөх хэрэгтэй. Эс бөгөөс гэгээрэхэд маш их цаг шаардагддаг юм шүү дээ. Та хоёр, гурван төрөл авч байж эсвэл хоёр, гурван мянган жилийн дараа ч гэтэлж мэднэ. Тийм учраас хамгийн сайн сайхны төлөө залбир, зөвхөн хамгийн шилдэг Багшийг ол, тэгвэл хамгийн сайн! Хэрэв та чин сэтгэлээсээ мөргөж залбирвал Эзэн Бурхан танд хамгийн сайныг нь илгээнэ. Хамгийн сайн сайхны төлөө л залбир, тэр нь юу вэ гэвэл, энэ насандаа зөвхөн Эзэн Бурханыг л таньж мэдье, Эзэн Бурханыг таньж мэдэхэд минь туслах хэн нэгнийг илгээгээч гэж хүсч гуй. Тэгэхгүй бол Бурхан таныг аль нэг түвшний диваажинд хүргэх, эсвэл ямар нэг ид шидийн хүч мэт үл ялих чамин зүйл өгөх хүн илгээчихэж мэднэ! Гэхдээ хэрэв та энэ насандаа Эзэн Бурханыг, зөвхөн Эзэн Бурханыг л таньж мэдэхийн төлөө залбирч мөргөвөл Тэрбээр танд хамгийн шилдэг, хамгийн хурдан, хамгийн хүчирхэгийг нь илгээнэ.” [30]

А. Багш аа, Хермес, Зороастра, Эссей болон Гностикууд гэгээрсэн Багш байсан уу? Хамгийн анхны Багш нар хэн байсан бэ? Агуу Их Цагаан Ах Дүүс гэж юу вэ?

Б. Жинхэнэ Багш бүхэн нэг юм. Тэд бүгдээрээ нэг л эх сурвалжаас ирсэн бөгөөд хамгийн дээд Багш бол та бүхний бүгдийн тань дотор оршин байгаа Хамгийг Чадагч, Төгс Дээд Багш юм. Бид анх энд ирэхдээ Багш байсан бөгөөд бид ертөнцийг адисласан. Харин гадна талын юмс үзэгдэлд анхаарлаа хандуулсны улмаас хамаг сүр жавхлан, эрх мэдлээ мартаж, хүч чадлаа баржээ. Тэгэхээр энд заларсан Багш нар бол бүгд үүнийг ухаарч, ухамсар нь сэргэсэн хүмүүс юм. Тэд жинхэнэ сүр жавхлангаа мэднэ, гэртээ харих замаар хэдэнтээ ч аялж чадна, мөн биднийг гэрт маань хүргэж өгч чадна. Тийм учраас Багш нарын хооронд зааг ялгаа гаргахын хэрэггүй. Бүх шашнууд Багшаасаа хойш

үүссэн. Тийм учраас Христээс хойш Христос шашинтнууд, Буддагаас хойш Бурханы шашинтнууд гэх мэтчилэнгээр бий болсон билээ." [50]

## *Гурван янзын багш*

"Хэрэв бид янз янзын Багш байдгийг мөн бидэнд аль нь хамгаас илүү таарч тохирохыг мэдэж байвал Багшийг эрж олоход амархан. Миний бодлоор Багш нар гурван янз байдаг. Эхнийх нь мэдлэг ухаантай, эрдэмтэд. Тэд бичиг судрыг маш сайн мэддэг, гүн ухааны хүрээнд нэр томьёог сайтар эзэмшсэн байдаг. Тэд тухайн судрыг хэн, хэзээ бичсэн болон нэр томьёоллынх нь утга учрыг тайлбарлаж өгч чадна. Ийм Багш нар бидний хүндэтгэлийг бүрэн хүлээнэ. Нэр томьёог нь мэдэхгүй юм уу, сурч судлах цаг завгүйн улмаас бидний ойлгож чадаагүй байж болох эртний сургаал номлолыг тэд бидэнд дамжуулж чадна. Энэ бол нэг янзын Багш. Бид тэднээс янз бүрийн шашин, сургаалын тухай сурвал бидний мэдлэг нэмэгдэнэ.

Хоёрдахь янзын багш бол цаг үргэлж, асар сэтгэл хангалуун жаргал буюу Самадид байдаг. Тэд Эзэн Бурхан, Түүний Таалал төлөвлөгөөнд өөрийгөө бүрэн зориулсан байдаг юм. Тэд Бурхантай шууд холбоотой бөгөөд эрдэм ухааныг шууд Эзэн Бурханаас хүлээн авдаг. Тэд Эзэн Бурхантай нүүр тулан уулзаж чадна. Хэрэв бид ийм Багш нартай санаандгүй юм уу, эсвэл хүсч зориод холбогдвол ач тусыг нь хүртэнэ. Эгэл ухаан санаа маань ертөнцийн амьдралын дарамтанд өртөх нь багасч, бид урам орж, баяр баясгаланг мэдрэн, Эзэн Бурханыг танин мэдэх эрмэлзлээ эргэн олж авна. Бидэнд ертөнцийг огоорох хүслэн төрж буйг мэдэрнэ. Энэ нь үсээ хусуулж, ой ширэнгэд амьдрах тухай бус, харин ертөнцийн олз ашиг болон биеийн таашаал мэдрэмж хүсэхээ багасгах тухай хэлж байгаа юм. Ийм Багш нар ер нь ном тавьдаггүй, ердөө л дотоод зохирол, аз жаргалдаа умбаж, асар сэтгэл хангалуун сууж байдаг тул

тэднийг олоход тун хэцүү.

Гуравдахь янзын Багш бол мөн л Эзэн Бурханы хайранд автсан байдаг ч мунхагт нэрвэгдсэн зовлонт хүмүүсийг нигүүлсэж хайрлах сэтгэл тэдэнд бас байдаг. Тийм учраас тэд хэрэгцээтэй газар болгонд явж байдаг. Тэр байтугай, чин үнэн сэтгэлийн угаас Эзэн Бурхантай эргэн нэгдэхийг эрмэлзэгч ганц, хоёрхон хүн байхад ч тэд ирж, Бурханы Орны тухай нууц, бидний дотоодод байдаг Дао, Үнэн Мөр, Бодит байдлыг олох аргыг хуваалцдаг. Мөн амьдралын зовлон зүдгүүрийн эрчийг бууруулахын тулд хүмүүс өөрсдөдөө итгэж, уг гарал буюу бүхнийг чадагч эх булагтайгаа нэгдэн нийлэхийн тулд дотоод дахь авралын хүч чадал, эрдэм ухааны агуу эх булгаа хэрхэн нээж олохыг хэлж өгдөг.

Гурван янзын Багшийг ерөнхийд нь тодорхойлоход ийм байна. Тиймээс бидний хүсэл, хэрэгцээ, мөрөөдлийг биелүүлж чадах Багшийг л бид хайх ёстой. Багштай учирвал, бидний хүсч буй тэр Багш мөн үү, бидний итгэл, хүндэтгэлийг хүлээж чадах уу гэдгийг тодорхойлох хэрэгтэй болно.

Эхний маягийн Багшийг их эрдэм мэдлэгээр нь таньж болно. Тэрээр ярьж чаддаг, хамаг судар бичгийг мэддэг болохоор бид энэ хүн бол эрдэм ухааны хүн гэж шууд хэлж чадна. Ертөнцийн эрдэм ухааныг ойлгож, шалгахад амар тул үүнийг тодорхойлох нь хялбар. Хоёр дахь янзын Багшийг гадаад төрхөөр нь, асар их аз жаргалд автсан бишрэмээр байдлаар нь танихад мөн л амархан. Гурав дахь янзын Багшийг танихад амаргүй, яагаад гэвэл хүн Самадид байгаа биш бол Түүнийг тийм байдалд ер байсан эсэхийг мэдэхэд хэцүү; учир нь ийм Багш хоногийн хорин дөрвөн цагийн туршид үл үзэгдэх “Самади”, туйлын их аз жаргалд байдаг. Самади гэдэг нь туйлын их аз жаргал, асар их баяр цэнгэл, амар амарлингуй болон гэрэл гэгээг илэрхийлдэг.

Та энэ дэлхий дээр амьдарч байхдаа ч туйлын их аз жаргалтай байж болно. Хоёр төрлийн Самади байдаг. Нэг нь, та энэ ертөнцөөс ангижирмагц Бурханы Оронд, мөнхийн агуу их аз жаргал, баяр цэнгэлд умбана. Та Эзэн Бурхан -

Энэрэл Нигүүлслийн Далайд нийлнэ. Хоёр дахь нь, Самадид хүрэхийн тулд бясалгалаар, сүсэг бишрэлээр эсвэл аливаа зан үйлийн тусламжтайгаар асар их аз жаргалыг өдөр бүр багахан мэдрэхийг хэлнэ. Самадид орсон үедээ та бүх ертөнцийг мартана. Зарим үед та орчныхоо хүмүүсийг сонсож болох боловч дэлхийд нэг л хамааралгүй санагддаг. Та гүн гүнзгий Самадид орвол бүх ертөнц алга болоод, зөвхөн гэрэл болон Эзэн Бурханыг л ажиж, амар амгалан, асар их цэнгэл, туйлын аз жаргалыг мэдэрнэ.

Гурав дахь маягийн Багш нар Есүс болон Будда шиг нэгэн зэрэг Самадид ба Самадид биш оршдог болохоор тэднийг танихад амаргүй. Тэд жирийн хүн шиг л харагддаг. Гурав дахь маягийн Багш байхын аюул үүнд оршдог. Эхний янзын Багшийг бүх хүн таньж, хүндэлдэг, мянга мянган хүн түүнийг шүтдэг. Хоёр дахь янзын Багшийг мөн л бүх хүн мэдэж, хөлд нь сөгдөн мөргөдөг. Тэр байнга Самадид байдаг учраас ингэж байгааг нь мэдэж ч байж болох, үгүй ч байж болох бөгөөд хүмүүс үүнийг нь харж байдаг. Гэтэл Есүс, Будда нарын адил гурав дахь янзын Багшид юу тохиолддог вэ гэвэл, хүн биетэй, хамгийн энгэл хүмүүс шиг аяглах Тэднийг ертөнцийн Аврал, Гэрэл, Мөр, Бурханы хүүхдүүд гэдэгт олон хүн итгэж чаддаггүй учраас тэдэн лүү чулуу шидэж, тэднийг хараан зүхэж, алж хөнөөж, загалмайлан цовдолж мэднэ.

Тэгэхээр Есүс, Будда нарын нэгэн адил явж, Бурханы орны нууцаас хуваалцаж байдаг тийм хүмүүс бол нэг зэрэг Самадид байж ч чадна, байхгүй байж ч чадна. Яагаад гэвэл сургаал номоо дэлгэрүүлэх цаг үедээ Түүний жинхэнэ мөн чанар нь Самадид оршдог, харин бие нь, гуниг шаналлыг амсаж, зовж зүдэрсэн хэвээрээ байдаг. Хоёр дахь маягийн Багшийн бие зовохгүй, сандарч шаналах юмгүй зөвхөн асар их аз жаргалд умбаж, зовлон гуниг нь тэр чигтээ арилах бөгөөд үүнийг хүний хэлээр илэрхийлэхийн аргагүй. Хэрэв Багш нэг болон хоёр дахь маягт хамаарах бол хүмүүс Түүнийг хүлээн зөвшөөрч, шүтэн биширнэ. Гуравдахь маягийн Багш байхын аюул нь тэд энгэл жирийн хүн шиг харагддаг. Хүмүүс тэднийг

авралын зам мөр гэдэгт итгэдэггүй учир чулуугаар шидэж, тэр ч байтугай амь насыг нь хөнөөж ч мэднэ.” [16]

## *Бидэнд яагаад амьд сэрүүн багш хэрэгтэй вэ?*

“Бид аливаа агуу хүн, агуу сүнс, Есүс, Будда нар шиг аль ч агуу их бясалгагч, хүн төрөлхтний төлөө асар ихийг золиосолж, төгс төгөлдөр Билгүүн ухааныг олсон ямар ч агуу их хүмүүсийг бүгдийг хүндэтгэж, хайрлах ёстой. Тэр хүн нэгэнт нас нөгчсөн байлаа ч бид үргэлж хүндлэн хайрлаж байх ёстой. Гэхдээ зөвхөн тэднийг магтах, шүтэх, тэднээс тус дэм гуйх гэж хамаг цагаа гарздахын хэрэггүй. Учир нь өнгөрсөн үеийн Багш нар өнгөрсөн үеийн шавь нартаа дамжуулан өгсөн тэр эрдмийг бидэнд нээх амьд сэрүүн Багш хэрэгтэй, бид бол амьд хүмүүс гэдгийг хэн бүхэн мэдэж байгаа. Тиймээс бид амьд буй Багшийг эрж олох ёстой юм.

Өнгөрсөн үеийн Багшийг бид хайрлаж шүтлээ ч гэсэн нэгэнтээ бидний соронзон оронгоос гараад явчихсан болохоор бидэнд тодорхой нэг хэмжээнд хүртэл л тусалж чадна. Тэд өөр ертөнц, өөр хэмжээст газар ажлаа хийхээр явчихсан, тэндээ завгүй байна. Тэгэхээр, одоо амьд буй Багш гэдэг бол тэдний хийж байсныг өнөө цагт үргэлжлүүлэх үүрэг хүлээсэн нэгэн мөн. Энэ нь ноён Картер хэдэн жилийн өмнө ерөнхийлөгч байсан, харин одоо бол ноён Буш ерөнхийлөгч болсонтой л адилхан. Тиймээс ноён Картер энэ албан тушаалыг хашихаа больчихсон байтал үндэстнийхээ асуудлыг шийдүүлэх гэж түүнийг бишрэн дагаж, урьж дуудах нь сайнгүй хэрэг. Бид түүнд дургүйдээ ч биш, хийсэн ажлыг нь үнэлэхгүй, хүндлэхгүй байгаа хэрэг биш, гэхдээ тэр нэгэнт ажлаа өгчихсөн байна. Бид түүнд одоогийн ажлаа хийх боломж олгож, харин түүний байрыг эзлэн яг одоо бидний төлөө ажиллаж байгаа хүнээс гуйх ёстой. Ердөө л энэ.” [33]

"Хамгийн дээд Багш ч байсан, энэ биет ертөнцийг орхихоороо бие махбодтой хүн амьтанд туслах аргагүй болдог. Гэхдээ ихэнх хүний хувьд хүрч мэдрэхэд нэн бэрх дотоод нэвтрэлцлийн замаар зөвхөн төрөлхийн далд ойлголцол телепаттай, эсвэл урьд төрөлдөө бясалгал хийснээс ямар нэг далдыг мэдрэх хүч чадал юм уу дотоод нэвтрэлцлийн чадварыг авч үлдсэн онцгой зарим нэг хүмүүсийг аварч чадна. Үүнийг зургаа юм уу долоо дахь мэдрэмж, ухамсрын хамгийн дээд хэмжээс гэж нэрлэж болно. Ийм хүн оюунлагийг үйлдэлгүйгээр, бясалгал дадалгүйгээр ч Есүсийг харж чадах боломж байж магад. Ийм явдал гарч байсан, гэхдээ тийм элбэг тохиолддоггүй." [4]

"Хэрэв бясалгал хийж байх үед тань бэрхшээл тохиолдох юм уу ямар нэг асуулт гарвал Эзэн Бурханд залбирч, бодол сэтгэлээ тайвшруулахыг хичээх хэрэгтэй, тэгвэл хариу эсвэл тусламж ирнэ. Эс бөгөөс Есүс, Будда, аль эсвэл өөрийн итгэдэг хэн нэг гэгээнтэнд залбирч мөргө. Манай номын цогцос бол түгээмэл чанартай, бид шүтлэг бишрэлийн аль ч тогтолцоог ялгаварлан гадуурхдаггүй. Гэхдээ, нэг зүйл нэмж хэлэхэд хэрэв та хамаг л гэгээрсэн төрөлтнүүд болоод Эзэн Бурханд мөргөж залбираад энэ нь нэмэр болохгүй бол намайг дуудаж тусламж эрж болно. Энэ нь би өөрөө өөрийгөө ихэд алдаршуулан магтаж байгаа мэт санагдаж байж болно. Гэвч би та нарт бүхнийг хэлж өгөх ёстой учраас би үүнийг хэлж байна, яагаад ийм байдгийг би бас тайлбарлах ёстой. Яагаад гэвэл би илүү ойрхон байгаа учраас тэр. Хол байгаа төрөл саднаас ойрхон байгаа хөрш дээр. Энэ бол маш энгийн бөгөөд учир зүйтэй хэрэг. Та бид аль аль нь дэлхийн соронзон оронд оршиж байгаа учраас би та нарт ойрхон байгаа юм. Бидний энерги сүлжилдсэн байдаг ба бид бие биедээ ойрхон, нэг ижил давтамж дээр хэлбэлзэж байдаг болохоор энергийн харилцан үйлчлэл амархан явагдана." [61]

Амьд сэрүүн Багштай хүнд хэрвээ бясалгал хийх үед саад бэрхшээл гарвал түүндээ чимээгүйхэн мөргөж залбирч, зөвлөгөө хүсч болно. Харин Эзэн Бурхан танд хол санагдаж байгаа бол танд зууч хэрэгтэй. Хөлд ороход нь эцэг эхийн тусламж шаардлагатай байгаа хүүхэд шиг та одоохондоо сул дорой байна. Гэвч та хожим өөрөө алхаж, таны зорилго бол өөрөө бие дааж алхаж явах гэдгийг ухаарч мэдээд эцэг эхээсээ хамаарахаа болино. Аръяабалын Бясалгалын Аргын тусламжтайгаар та өнгөрсөн үеийн Их Багш нараас шууд сурч болно. Бид сургаал номлол сонсож бус, харин ингэж Үнэнд суралцдаг юм. Үнэн Ёс нь бидний өмнө зөн билгээр маань дамжин нээгддэг. Дээд хэмжээст очвоос бид зөвхөн дотооддоо анхаарлаа төвлөрүүлж байж, гүн бясалгалын түвшинд хүрсэн үед л ойлгогдох боломжтой өөр бусад төрөлтнүүд болон илүү "соёл иргэншилт" ертөнцийг нээдэг. Аръяабалын Бясалгалын Арга бол ийм төлөвт хүрэх зам мөн." [24]

"Өнгөрсөн үеийн Багш танд зааж сургаж чадахгүй. Таны асуултанд хариу өгч, эргэлзэж тээнэгэлзэхэд тань тусалж, гараас тань хөтлөн Бурханы Оронд хүргэж чадах одоо цагийн Багшийг л та эрж олох хэрэгтэй. Бидэнд өнгөрсөн үеийн хэн нэгэн бус, харин хүн хүнтэйгээ холбогдох харилцаа хэрэгтэй. Өнгөрсөн үеийн эмэгтэй хэчнээн гоо үзэсгэлэнтэй байсан байлаа ч та түүнтэй гэрлэж чадахгүй биз дээ! Тэр эмэгтэй танд хүүхэд төрүүлж өгч чадахгүй, амьд сэрүүн эхнэртэйгээ байдаг шиг хайрын мэдрэмжийг танд өгч чадахгүй." [60]

Амьд буй Багшийн ашиг тус их. Надад цахилгаан эрчим хүч бий. Тасархай дамжуулагч утас ажиллахгүй, гагцхүү амьд дамжуулагч л танд цахилгааныг дамжуулж авчирч чадна. Дамжуулах утас хэчнээн хүчин чадал сайтай байсан ч нэгэнт тасархай бол цахилгаан дамжуулж чадахгүй. Чийдэн хэчнээн сайхан байлаа ч эвдэрхий бол гэрэлтүүлж чадахгүй. Гэтэл гадаад үзэмжээрээ муухай ч гэсэн бүрэн бүтэн чийдэн л бол гэрэл өгч чадна. Чухам ийм учраас л нөгчсөн Бурханд мөргөж

залбирвал хүмүүс хариу хүлээж авах нь ховор байдаг юм." [22]

"Багшийн тухай бодлоороо та Багштай нэг болно, Багш гэдэг бол та өөрөө юм. Багш гэдэг бол таны өөрийн жинхэнэ "Мөн Чанар", гэвч үүнийг та ойлгохгүй болохоороо Багшийн тухай бодохоос өөр аргагүй байдгийн учир нь та өөрөө Багш юм. Энэ бодлоор дамжин Багшийн хамаг цог чанар танд аажим аажим, алхам алхамаар шилжинэ, тэгээд та Багшаар дамжин өөрийн Мөн Чанараа олно. Тэгээд хожим нь та "Өө, Багш гэдэг чинь би юм байна. Багш гэдэг чинь үргэлж би өөрөө байсан юм байна" гэдгээ ухаарч ойлгоно. Тийм учраас эрт цагаас хүмүүс билиг ухаантан хийгээд гэгээрсэн Багшийг тэдний тусын тулд биш харин өөрсдийнхөө төлөө л шүтэн биширч иржээ." [43]

А. Хэрвээ би зөв ойлгосон бол бидний дотоодынхоо Багшийг эрж олтол хэсэг зуур гадна талын Багш хэрэгтэй байх нь ээ?

Б. Гэхдээ Багш гэдэг бол зөвхөн биет түвшний төдийгүй мөн дотоодын замч юм. Эс бөгөөс Багш ертөнцөд хаа сайгүй, мянган бээрийн хол байгаа шавьдаа тусалж чадахгүй байхсан. Өдөр шөнө ялгаагүй аль ч үед, хаана ч хамаагүй орших хүн бүхэнд туслахын тулд Багш асар өндөр түвшинд байх ёстой.

А. Өрнө дахинд оюун санааны эрэлчид Багшийн хөлд сөгдөж, хэт шүтэх аюул их байдаг. Та үүнийг асуудал бэрхшээл гэж үздэг үү?

Б. Хэрэв багш нь жинхэнэ Багш бол тэгж үзэхгүй. Учир нь энэ тохиолдолд та өөрийгөө л шүтэж, Багштай нэгдмэл агуу их оюун санааг л биширч хүндэтгэж байгаа хэрэг.

А. Тэгэхээр багш нь жинхэнэ Багш мөн бол, хүмүүсийн өмнө толь барьж өгч, өөрсдийн мөн чанараа гүн гүнзгий олж харахад нь тусалдаг гэж хэлж байна уу?

Б. Тийм ээ, яг тийм юм. [58]

А. Урьд үеийн Багш нарт шавилагсдын тухайд яах вэ? Амьд сэрүүн жинхэнэ Багш энэ ертөнцийг орхиж одвол Түүний шавь нар өөр Багш хайж олох ёстой юу, эсвэл ингэхийн хэрэггүй юу?

Б. Ингэх хэрэг байхгүй. Гэхдээ хэрэв тэд амьдралын талаар юм уу материаллаг зүйлсийн талаар ямар нэг юм тодруулахыг хүсвэл амьд байгаа өөр Багш эсвэл Багшийнхаа залгамжлагч дээр очиж болно. Түүнээс биш өнгөрсөн Багшийн оюун санааны жолоодлого дотоодод тань байсаар байдаг. Тэр шавь нараа хариуцсан хэвээр, үүнийгээ үргэлжлүүлэх хүчтэй хэвээрээ байдаг, учир нь холбоо барилдлага хэдийн тогтоочихсон болохоор тэр. Ойлгож байна уу? Өнгөрсөн Багштай холбоо барилдлага гэдэг зүйл байхгүй тохиолдолд л бидэнд шинэ Багш хэрэгтэй. Бид олон зууны өмнө амьдарч байсан урьд үеийн Багш дээр яагаад очсонгүй вэ гэхээр бид Түүнийг амьд байх үед нь холбоо тогтоогоогүй учраас тэр, тиймээс бид Түүнтэй барилдлага үүсгээгүй байх нь. Хэрвээ та мянган жилийн өмнө Багштай барилдлага тогтоосон бол хэчнээн цаг хугацаа өнгөрсөн ч хамаагүй Тэр танд санаа тавьсаар байх болно. Гэтэл Түүнийг нас нөгчихөөс өмнө та Түүнтэй холбоо тогтоогоогүй бол Тэр яаж танд санаа тавьж чадах юм бэ? Ойлгож байна уу?

А. Хүмүүст та өөрөө юу өгч чадах вэ гэдэг тал дээр юу хэлмээр байна?

Б. Эзэн Бурхан Түүний ойр дэргэд нь байх дуртай хүүхдүүд нь болох хүмүүст үйлчлүүлэхээр миний бие, хэл, сэтгэлийг ашиглахыг хүсэх юм бол түүнийгээ өгөхөөс өөр илүү их юм санал болгож чадахгүй. Би ашиглуулахад л бэлэн байхаас өөр юмгүй. /Инээлдэв/. Би чинь тантай л адилхан шүү дээ. Бие цогцос юу өгч чадах юм бэ? [24]

А. Хүмүүсийг таны номлол сургаалд улам их итгүүлэхийн тулд та ид шид үзүүлж чадах уу?

Б. Ид шид гэнэ ээ, та юу хүсч байна? Танд мөнгө өгөх үү, тийм үү? Тэгээд та түүгээр юу хийх вэ? Энэ нь танд ямар сайн зүйлийг мөнхөд өгч чадах вэ? Би таныг миний ид шидэнд найдаж, зөвхөн ид шидийн хүчний төлөө над уруу ирэхийн оронд эрх мэдэл, Эзэн Бурханы Вант Улс, өөрийн Билгүүн ухаан, төрөлхөөс заясан эрх, өөрийнхөө Бурханы орон,

өөрийнхөө Хаант Улсаа олж авахын тулд хүч чадлаа нээ гэж зөвлөе. Ид шидэд бус харин үүнд л хүний амьдралын хамгийн эрхэм дээд хүслэн оршино. Ид шид бол зуурдын юм шүү дээ.

Шаардлага гарвал би та нарт ид шидийн гайхамшгийг үзүүлнэ. Гэхдээ алга ташуулах гэж тоглолт хийхгүй. Бясалгал хийх үед тань шаардлага гарвал үзүүлнэ, бясалгах үедээ та муу нөлөөлөл, саад тотгортой учирч магадгүй юм. Тэр цагт та намайг ид шид бүтээж чаддагийг мэднэ. Би чадна, гэхдээ зүгээр л өөрийгөө хэчнээн агуу болохыг та бүхэнд ойлгуулах гэж үүнийг хамаагүй хийхгүй. Надад ийм юм хэрэггүй. Би та бүхнийг иймэрхүү балчир хүүхдийн наадам, хуванцар тоглоомтой зууралдалгүй, харин өөрийнхөө хамгийн агуу билиг ухааныг эргүүлэн олж, төгс дээд оршихуйд буцахын тулд маш зөв үзэл хандлага, зөв бодол, бясалгалын зөв ойлголттой байгаасай гэж хүсч байна. Бүх юм та нарынх болно. *"Эхлээд Бурханы Орныг эрж ол, тэгвэл бусад бүх юм та нарынх болно." /Матвей, 6:33/* Өчүүхэн юм битгий гуй, агуу их юмыг л гуйж хүс. Бидэнд энэ нь илүү зохистой, учир нь орчлон ертөнцийн хамгийн агуу нь хүн төрөлхтөн юм. Тийм учраас хамгийн агуу ихийг л хүс, энэ нь таны байр сууръ, намба хүнд, төрөлхөөс заясан эрхэнд илүү тохирно. [13]

А. Багш аа, та даян дэлхийгээр аялж явдаг болохоор хүн бүхнийг зааж сургах гэж энд үлдэж болохгүй, тэгэхээр таныг үгүйд бид хэнийг дагах юм бэ?

Б. Ийм юм л даа. Бид Багшийг бус, харин сургаал номлолыг л дагадаг. Тийм ч учраас Багш буруудлаа гэхэд бид хэзээ ч буруудна гэж байдаггүй. Ном зүй ёсоороо байхад бид номоо л дагадаг. Бид сургаал ном зөв байна уу, үгүй юу гэдгийг харах ёстой. Та бүхэн намайг зөв ёс суртахуунтай байна уу, та нарт зааж сургаж байгаагаа би өөрөө дагаж мөрдөж байна уу гэдгийг хар. Тухайлбал, би та нарыг мах битгий ид гэж сургадаг, тэгээд би өөрөө ч мацаг хоол иддэг. Би та нарыг бүү хулгай хий гэж сургадаг, тэгээд би ч бас хулгай

хийдэггүй. Би та нарыг буян хий гэж сургадаг, би өөрөө ч өглөг буян хийдэг. Би та нарт хүмүүсийг хайрла гэж сургадаг, би ч гэсэн хүмүүсийг хайрлаж, хүмүүст тусалдаг. Би хүнд ном заасныхаа төлөө мөнгө зоос авдаггүй, би өөрөө мөнгөө олдог, тийм болохоор та нарт алдах юм байхгүй. Та нар зөвхөн хожих л болно.

Цаашилбал, би та нарт Христийн Библи болон Буддын ном судартт тэмдэглэсэн ёс суртахууны тэр хэм хэмжээг л зааж сургадаг. Тийм болохоор би та нарт ямар ч шинэ юм, зан суртахуунгүй ямар ч зүйл, ёс зүйгүй ямар ч юм номлоогүй. Ойлгож байна уу? Тийм учраас та бүхэн Багш тань ном судрын хүрээнээс хальсан ямар ч юм, ямар ч зүй бус юм уу, ёс суртахуунгүй зүйл сургадаггүй гэдэгт итгэж болно. Миний та нарт зааж сургаж байгаа бүхэн цөм судар номд бичээтэй байдаг. Эрт цагаас аваад ёс суртахуунт байдал өөрчлөгдөөгүй, Эзэн Бурханы хийгээд Буддын сахил гэрээслэл өөрчлөгдөөгүй байгаа. Би та нарт үүнтэй нэгэн адил зүйлийг л сургадаг, өөрөө ч үүнийг баримталдаг, тийм болохоор та нар наад зах нь намайг муу хүмүүсийн нэг биш гэдгийг мэднэ! Ийм маягаар, сургаал номлол зөв зүйтэй байна гэж хэлж болно, тийм биз?

Харин бясалгал та бүхэнд билгүүн ухаан болон сэтгэлийн амгаланг авчирна. Ямар ч арга техник байсан та бүхэнд ямар нэг хэмжээгээр тус болно. Манай арга ч мөн адилхан. Гэхдээ харин энэ бол хамгийн түргэн арга гэдгийг л зөвхөн хэлэх байна, ердөө л энэ. Та нар надад итгэх албагүй. Би зөвхөн та нарт мэдээллийг л өглөө, харин өөрсдөө сонголтоо хийцгээнэ биз. Би зөвхөн үнэнийг л хэлнэ. Түргэн аргыг би энэ их түргэн арга л гэж хэлнэ. Тэгээд ч би хувраг хүн, худал ярих нь хориотой. Жирийн хүмүүс ч худал хэлдэггүй байтал хувраг хүн яах гэж худлаа ярих юм бэ? Тэгээд ч та бүхний мөнгө зоос надад хэрэггүй учраас худал ярих шалтгаан байхгүй. Надад юу ч хэрэггүй, наад зах нь би ямар энд амьдардаг хүн ч биш. Надад та нараас олох ашиг үгүй. Би маргааш гэхэд л явчихаж мэднэ,

тэгээд бид дахиад хэзээ ч уулзахгүй байж мэднэ. Баяртай! Тийм болохоор би ямар ч ашиг завшаан олохгүй юм. Ингэж авч үзэх юм бол та бүхэнд санаа зовох зүйл алга, зөв үү?

Тэгэхээр та намайг биш харин сургаал номыг маань дага. Сургаал ном цаг ямагт тантай хамт байна, тиймээс намайг биечлэн дагахын шаардлага үгүй. Хэрэв бясалгалын дэвшил хөгжилд тань тухайлан хувийн зөвлөгөө хэрэг болвол надтай утсаар ярьж асуух юм уу захидал бичиж болно. Өнөө үед Багштайгаа үргэлж хамт байхын шаардлага байхгүй, та Тайваньд юм уу миний хаа байгаа тэр газар хүрээд очиж болно. Миний бие бол та нарт намайг харах боломж олгохын тулд байгаа гадаад бүрхүүл, гэр орон, ажлын байр төдий юм. Хэрэв би зөвхөн сүнсэн биеэ л хэрэглэдэгсэн бол та нар ерөөс намайг олж харж чадахгүй, намайг сонсож чадахгүй. Тэгэх юм бол би яаж та бүхэнд энэ илгээлтийг дамжуулж чадах юм бэ? Тийм болохоор би бие цогцсоо ашиглахаас өөр аргагүй, тийм биз дээ? Мөн намайг явчихаар та нарт хэн ч байхгүй болчихно гэж айх хэрэг байхгүй. Та нарт цаг үргэлж хэн нэг хүн байх болно. Чин сэтгэлтэй, боломжийн өндөр түвшинд хүрсэн хүн бол намайг одоо харж байгаа шигээ гэрт нь хувилгаан биеэр ирэхийг харж ч хүртэл чадна. Багш өөр дээр чинь ирэхийг харна, шаардлагатай цагтаа Багшийг хэзээ ч гэсэн олж үзнэ. Бие махбодонд татагдаж зууралдах хэрэггүй.” [13]

А. Багш аа, хэрэв надад хүнд өвчтэй ямар нэг найз, хэн нэгэн хүн байвал шавийн хувьд би танаас энэ хүнд тусална уу гэж гуйвал та тусалж болох уу, эсвэл та сургаал номыг тань дагадаг хүмүүст л зөвхөн тусалдаг уу?

Б. Багш бол таны дотны хайрт хүн болгонд тусална, гэхдээ мөн үйлийнх нь үр ба яавал түүнд ач тустай вэ гэдэгт нь тохируулдаг. Ямар ч атугай гуй, гэхдээ үр дүнг нь Багшийн хүчинд даатгаад орхи. [52]

## *Амьд сэрүүн Багшийг хайрлахуй*

Багшийг хайрлах хайр нь хувиршгүй, зөвхөн өөрчлөгдөж хөгжиж байдаг. Эхэндээ та Багшийнхаа биеийг хайрлана, харин хожим биеэрээ байх үгүй хамаагүй бүхнийг хайрлах болно. Та илүү хүлцэнгүй болж, алагчлал үгүй хайрыг улам илүү мэдэрнэ. Хайрлаж байна гэдгээ мэдэлгүйгээр хайрлах болно. Бүр аяндаа л тийм таатай сайхан байх болно. Та юуг ч хайрласан, намайг л хайрлаж байгаа хэрэг. Багшийн дэргэд байхдаа та өөрийгөө нэн чөлөөтэй, илүү хөгжингүй, Багшдаа хайрлагдаж байгаагаа илүүтэй мэдэрнэ. Та өөртөө илүү итгэлтэй болж, үнэ цэнээ илүүтэй сайн ойлгоно. Та энэ хүнийг танд хэзээ ч хор хүргэхгүй, зөвхөн хүч чадлаа хөгжүүлэхэд тань л тусална, харин хэзээ ч хариу нэхэхгүй гэдгийг мэднэ. Хэний ч зүрх сэтгэлийг уярааж чадах хайр гэвэл энэ байна. Энэ хайр хэзээ ч үгүй болохгүй, төрөл арилжин нэг амьдралаас нөгөөд шилжих үед ч алга болдоггүй юм. Та авшиг нэгэнт хүртмэгц үүрд хамт байна. Та хаа ч явлаа гэсэн энэ хайр тантай хамт байгааг мэдэрнэ. Тийм учраас гэрэлд ойр байх дуртай удган эрвээхэй шиг та энэ хайрын хамт байхдаа жаргалтай байх болно.

Багшийн үл үзэгдэх тэр агуу их гэрэлд хүн бүхэн дуртай байдаг, яагаад гэвэл энэ гэрэл нь цангаж ундаассан сүнсэнд маань хэрэгтэй болгоныг нь, энэ ертөнцөөс хангаж чадахгүй байгаа бүхнийг өгч чаддаг. Сэтгэл ханамжийг мэдэрье гэвэл Багшийн ойр суу. Багшийн гадаад үзэмжийг нь бус, харин дотоод сайхныг нь хайрла.

Миний тухай бодохоороо та нар инээмсэглэдэг, тийм биз? Та аз жаргал, асар их амгалан баяслыг мэдэрдэг. Гэтэл ертөнцийн хайр бол таныг цаг үргэлж энэ ертөнцөд уяж хүлээсэлдэг. Хэрвээ та надад татагдвал та миний явж байгаа тэр зүгт явна, хэрэв өөр хэн нэгэнд татагдвал тэдний явж байгаа зүгт явна. /инээлдэв/ Заримдаа энэ нь таныг зовлон гамшиг,

үзэн ядалт, атаа хорсол зэрэг элдвийн уяа хүлээсэнд оруулдаг. Багшийг хайрлах нь огт өөр юм. Та Багшийг хэдий чинээ их хайрлана, төдий чинээ их эрх чөлөөтэй болж, урьд өмнө нь мэддэг ч үгүй байсан тал бүрийн эрх чөлөөг олж авна. урьд нь та нийгэм, үзэл баримтлал, зан уламжлал, гэр бүлийн уяагаар хүлээтэй байсан хэрэг. Одоо бол ямар ч хүсэл, дадал, ямар ч доорд хүсэл тачаал таныг уяж хүлж чадахгүй. Үйлийн үртэй хутгалдуулдаг доорд хүсэл болох ертөнцийн хайр дурлал ба эрхэм дээд хайр хоёрын ялгаа үүнд л оршино. Та бүхэн намайг хайрла, гэхдээ хэзээ ч гэсэн орхиж болно. Ялгаа нь энэ юм, та нар айх хэрэггүй." [22]

## *Их Багш нарын зам мөр*

Манай дэлхий одоо хуучин цагийнхтай харьцуулбал илүү дээр болжээ, яагаад гэвэл Дэлхий дээр өчнөөн Багш бууж ирээд бидэнд соёл иргэншлийн олон олон агуу их хууль ёсыг зааж сургасан байна. Бид сайжирч дэвшсэн. Тийм учраас дэлхий ертөнц маань мянган жилийн өмнөхтэй харьцуулбал илүү соёл иргэншилтэй, улам гэрэл гэгээтэй, илүү ая таатай болсон байна. Бидний ойлголт ухамсрыг дээшлүүлсэн өчнөөн олон Багш нарын ач буянаар ийм болсон хэрэг. Тэд хэдийгээр ердөө цөөн хэсэг хүнд зааж сургасан ч гэлээ үлдээсэн сургаал номлол, хэлбэлзэл, үр нь ургасаар, ертөнц даяар өгөөжөө өгч, бүх хүн төрөлхтний ухамсрыг дээшлүүлжээ. Тийм учраас л манай дэлхий өдрөөс өдөрт улам улам сайжирсаар байна." [27]

"Их Багш энэ Дэлхийд залрахуйд билиг увдисыг нь зөвхөн шавь нар нь хүртэж гэгээрээд зогсохгүй хамаг хүн төрөлхтөн ариусч, ухамсар нь тодорхой түвшинд өөдлөн дэвшдэг. Ингэж манай дэлхийг олон олон Багш адисласан тул дэлхий маань өнөөгийн байгаа шигээ илүү сайн сайхан болсон билээ. Хэдий тийм боловч ухамсар нь бурханлаг түвшинд хүрч чадаагүй байна. Орчлон ертөнцийн бусад олон гаригийн

ухамсрын түвшинд хүрч чадаагүй л байна." [31]

"Хэрэв бид эртний Багш нарын хүрсэн тэр оргилд хүрье гэвэл тэдний адил замналыг дагах ёстой. Маш амархан. Энэ нь та эмч болъё гэвэл их сургуульд орж, хичээлийн хөтөлбөрийг нь дагах хэрэгтэй байдагтай адил. Төгссөн эмч нар таныг хэрхэн яаж эмч болохыг зааж сургана. Үүнтэй адилаар Христтэй адил болохын тулд бид тэр аргаар нь хичээллэж, дотоодын гэрэл ба Эзэн Бурханы Дуу хоолойтой холбогдох ёстой. Би харин та бүхэнд энэ аргыг мөнгө болон бие сэтгэлээ зориулах ямар ч нөхцөл, болзол шаардалгүй чөлөөтэй өгч чадна. Өөрийгөө үүнд зориулъя гэх сэтгэл л байвал болчихно. Зав боломж, сайн дураараа өдөр бүр чин сэтгэлээсээ бясалгая гэсэн үнэн сэтгэл байвал болчихно. Шаардагдах зүйл ердөө л энэ. [4]

Урьдын Багш нарын үлдээсэн сургаал дадлагыг бид яагаад хадгалж хямгадаж чадаагүй вэ? Бид хүч чармайлт тавиагүй юм уу хүсээгүй учраас ийм болсон юм биш. Бидний хүч барагдаж, ахуй амьдралд ядарч зүдэрч, эцэж цуцсанаас болсон хэрэг. Энэ соёл иргэншлийн байнга өсөн нэмэгдэж байгаа хэм хэмжээнд зөвхөн амьдралаа залгах гэж л бид заримдаа маш их ажиллах хэрэгтэй болдог. Түүнчлэн бидний дурыг татах зүйлс бүр ч илүү "соёлжсон" өнөө үед бид өөрийгөө хүндэтгэх үзэл, билгүүн ухаанаа буцаан олж авъя гэвэл бүр илүү "соёлжсон" аргаар өөрсдийгөө хамгаалах ёстой болж байна. Яагаад гэвэл бид заримдаа ахуй амьдрал, дарамт шахалтын эргүүлэгт орчихоод, өөрсдийгөө алдчихаад байх шиг байна. Гэхдээ бид бие махбод, хүсэл эрмэлзлээ алддаггүй, харин өөрийнхөө эзэн байж чадахаа больдог. Тийм учраас Библид *"Бүх дэлхий ертөнцийг олж авсан атлаа өөрийгөө алдаж гээчихвэл ямар хэрэг байх вэ?"* гэсэн байдаг. *(Матвей, 16:26)*

Бид сүнсээ алдаж гээх гэдэг нь юу гэсэн утгатайг үнэн хэрэгтээ ойлгодоггүй. Бид "Юу? Би юугаа ч алдаагүй. Харин ч өдөр бүр улам улам их юмтай болж байна" гэж боддог. Хэрвээ

ажил олгогч тань таныг тушаал дэвшүүлэх юм уу та дахиад нэг хүүхэдтэй болохоор шийдлээ гэхэд таны үүрэх ачаа л жаахан нэмэгдэж байгаа хэрэг. Зарим ачааг тэвчиж үүрээд, заримыг нь баярлаж үүрээд. Ингээд материаллаг үйл ажиллагаанд хэдий чинээ их орооцолдоно, өөрийгөө төдий чинээ алдаж, төдий чинээ бага мэдэх болно. Ер нь та өөрийнхөө тухайд чухам юу мэдэх ёстой вэ? Тэгэхээр бид чинь ертөнцийн хамгийн хүчирхэг төрөлтөн юм шүү дээ. Ариун судрууд цөм энэ тухай өгүүлсэн байдаг. Буддын шашны ном бичгүүдэд хүний амьдрал хамгаас нандин үнэтэй гэдэг. Лалын шашны судар бичгүүдэд бид бол газар дэлхий дээрх зочид гэж айлддаг. Энэ бүхэн нь бидний орон гэр өөр газарт бий, бид бол бие махбодоосоо хавьгүй илүү зүйл гэсэн утгатай. [4]

Гэхдээ үүнд итгэх нь хангалттай биш. Та оршихуйн дээд түвшнийг нээж танилцахын тулд, сэтгэхүй ба амьдрахуйн эрхэм дээд байдлыг хэвшүүлэхийн тулд, хувийн дасгал сургууль маягийн зүйлийг дагаж, эргэцүүлэн тунгаах чадвар болон билиг ухаанаа ашиглах ёстой болно. Таны дотоод хүч хүссэн бүхнийг тань бүтээж өгнө. Та тэр цагт Эзэн Бурханыг ухаарч ойлгон “Эзэн Бурхан надаар хийлгэж байна” гэж хэлэх бөгөөд Есүс “Би болон миний Эцэг нэг” гэснийг давтан хэлж чадна. Тэгсэн цагт бид өнчрөл ганцаардал, зовлон бэрхшээлийг мэдрэхээ болино.” [4]



Энэ дэлхийн хэл ярианаас гадна түүнээс илүү агуу гоо сайхан Хэл бас байдаг. Тэрхүү Хэл, Аялгууг сурмагц бид бусад бүх хэлийг, түүний дотор хүн төрөлхтний хэлүүд болон хамаг амьтны хэлийг ойлгоно.

~ Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай ~




1998 оны 12 сард Шрайн Танхимд "Дуу хөгжмөөр энх тайван эв нэгдэлд хүрэхүй" сэдэвт гайхамшигт гала концерт болсон бөгөөд орлогыг нь Стар Лайт Хүүхдийн сан, Гэгээн Жүүдийн хүүхдийн эрүүл мэнд, эрдэм шинжилгээний эмнэлэгт хандивлав. Их Багш Чин Хайн уярам яруу, ухаан хайрласан яруу найргийн бүтээл Холливуудын нэрт уран бүтээлчид, дэлхийд алдартай хөгжмийн зохиолчдын тоглолттой хослон үй олон хүний зүрх сэтгэлийн гүнд энх тайван, энэрэл хайрын илгээмжийг хүргэлээ.

# Авшиг

Цаглашгүй Их Багш Чин Хайн тавьсан лекцээс

Авшиг гэдэг бол ердөө л оюун санааг нээх гэдгийг заасан үг юм. Бид ил, далд элдэв барцад тотгорт автсан байдаг. Тиймээс авшиг гэдэг бол билгүүн ухааны маань үүдийг нээж, түүгээр дэлхий ертөнц болон өөрсдийн маань "Мөн Чанар" гэгч зүйлийг адислахын тулд ертөнцөд нэвтрүүлэх үйл явц юм. Гэхдээ жинхэнэ "Мөн Чанар" маань билгүүн ухаан, сүр жавхлан дотор мөнхөд орших тул түүнийг адислах хэрэг байхгүй." [58]

"Авшиг хүртэнэ гэдэг нь шинэ эмх журмаар шинэ амьдрал эхэлж байна гэсэн үг. Энэ нь Багш таныг Гэгээнтнүүдийн хүрээнд харьяалагдахыг зөвшөөрч хүлээн авсныг илэрхийлж байгаа юм. Тэр үеэс эхлэн та жирийн хүн байхаа больж, яг л их сургуульд элсэнгүүт л дунд сургуулийн сурагч биш болдогтой адил та өндөр дэсэд хүрсэн хэрэг. Эрт

цагт үүнийг “усан баталгаа буюу Багшийн авралд багтах” гэж хэлдэг байжээ.” [39]

## *Авшиг хүртэхүй*

Авшиг хүртэх үедээ бид тийм ч цэвэр ариун байдаггүй ч дотоод дахь Эзэн Бурханы хүч болон Багшийн авралаар угаагдан ариусдаг. Шоронгийн хаалгыг цөмлөн гарах үедээ бид дуу аялгуу сонсож, гэрэл гэгээ харна, учир нь тэдгээр нь материаллаг ахуйн чанадад байдаг юм. Тийм учраас үүнийг гэнэтийн буюу агшин зуурын гэгээрэл гэдэг. Энэ нь авшиг хүртэх үед бид Дээд ертөнцүүдтэй холбогдож цаашид тэднээс салж тасрахгүй болсныг илтгэж байгаа юм.

Нарлаг сайхан өдөр гэртээ байж байна гэж төсөөлөөд бодъё. Та хаалгаа онгойлгохгүй бол нарыг олж үзэж чадахгүй шүү дээ. Үүнтэй адилаар Эзэн Бурханы гэрэл ба аялгуу байнга оршиж байдаг ч бид төрөл төрлөөс тээж ирсэн үйл, урьдаас тогтсон үзэл баримтлал, бодлынхоо шоронд хоригдчихоод түүнийг олж үзэж, сонсч дуулдаггүй байна. Авшиг хүртэх үед Багш бидэнд нэгэнт бүр мөсөн гадагш нэвтрэн гарах боломж олгодог юм. Гэхдээ өмнө маань нээж таних олон олон түвшин байдаг учраас бид цаашаа үргэлжлүүлсээр байх хэрэгтэй болно. Авшиг хүртэх нь зөвхөн эхлэл, гэхдээ маш мундаг эхлэл гэж хэлж болно. Учир нь хүмүүсийн олонх нь хамгийн доод хүрднээсээ бясалгаж эхлээд дараа нь дээд хүрдэнд хүрдэг, энэ нь арван жил ч шаардаж мэднэ. Харин бид бол дээд хүрднээсээ эхэлдэг. Биднийг гэрэл харуулахын тулд Багш бүх хүчийг толгойн оройд татаж авчирдаг юм. Энэ бол (Багш билгийн нүдээ зааж байна) Бурханы Оронд хүрэх хаалга бөгөөд та бүхэн олон орд харшаар дайрч гарах болно. [38]

Энэ аргыг дамжуулах үедээ бид юу ч ярьдаггүй, харин та нар хамгийн сайн гэгээрлийг олж авна. Та урьд өмнө нь танд хэзээ ч байгаагүй зүйлийг олж авах бөгөөд урьд өмнө хэзээ ч

мэдэрч байгаагүй маш хөнгөн, тун амгалан, хэчнээн сайхан, огт гэм зэмгүй байдлыг мэдэрнэ. Үүнд л авшиг хүртэхийн ач холбогдол оршдог юм. Загалмайлагч Ионн Есүст анх (усан баталгаа) авшиг хүртээхэд Тэр тагтаа шиг бууж ирэх гэрэл олж үзсэн гэдэг. Тийм учраас таныг адислаж чадна гэж нотолж буй хүнээр адислуулбал, тэр хүн чинь ядаж л энэхүү тагтаа мэт бууж ирэх гэрэл эсвэл Библид дурдсан том гал дөл шиг гэрлийг харуулж, та Эзэн Бурханы аянга мэт дуу хоолойг, их усны чимээг сонсох ёстой. Тэгэх юм бол та авшиг хүртлээ гэдэгтээ итгэж болно." [5]

Та Эзэн Бурханы дуу хоолойн дотоод хэлбэлзлийг хоёр чихнийхээ оролцоогүйгээр сонсоно. Эзэн Бурханы гэрлийг хоёр нүднийхээ туслалцаагүйгээр харна. Энэ тухай би ярьж чадахгүй. Үг хэл, ухаан бодол нь Эзэн Бурханы буюу сүнсний хүрээнд (хязгааргүй зүйл) биш харин тархи ба материйн хүрээнд (хязгаарлагдмал зүйл) харьяалагдана, Бидний сэтгэлгээ нь мэдээлэл, боловсрол, өөр бусад хүмүүсийн сэтгэлгээгээр нөхцөлдсөн байдаг. Бидний сүнс ба Эзэн Бурханы мөн чанар бол аяндаа өөрөө үүсч, өөрийнхөөрөө оршдог, дэмжин туслагч цэвэр ариун зүйл. Ингэхлээр нийгэм, сэтгэлгээ, гүн ухаан, хэлний нөлөөнд орсон бүх зүйл оюун ухаанд хамаатайгаас биш билиг ухаанд хамаагүй. Тийм учраас би үүнийг огт чимээгүй л дамжуулж чадна. Тийм болохоор л бид үүнийг сэтгэлээс сэтгэлд, зүрхнээс зүрхэнд уламжлах гэж нэрлэдэг юм. [4]

## *Авшиг хүртэхийн ач тус*

Авшиг хүртсэний дараа дотоодын гэрэл маань бидэнд жинхэнэ Бурханы Орныг харуулахын тулд, биднийг жинхэнэ гэрт маань хүргэж өгөхийн тулд урагшаа нэвт гийгүүлнэ. Тэгмэгц бид энэ ертөнцөд хэзээ ч мэдэрч үзээгүй тийм их аз жаргалтайгаар өөрсдийн оршихуйн жинхэнэ төлөвийг олж авна. Бид урьд өмнө нь хөгжүүлэх гэж оролдоод, хэзээ ч

гүйцэлдүүлж чадаагүй тэр бүх буянтай сайхан чанаруудаар бялхах болно. Бидэнд угаас байдаг ч өдий хүртэл ашиглаж чадаагүй байсан билгийн ухааныг маань ариун номын чимээгүй үг сургаал ахин амилуулж өгнө. Тэр үед бид хамгийн сэтгэл хангалуун хүмүүс болох бөгөөд энэ ертөнцийн юу ч тийм үр нөлөө амлаж чадахгүй билээ." [57]

"Авшиг хүртсэний дараа та бүхэнд дотоодын тусламж, хамгаалалт мөн гадна талын холбоо харилцаа ч бий болно. Дотооддоо гэдэг нь, та бясалгаж байхдаа Багшийгаа өөрт тань яаж тусалж байгааг харах юм уу гэрэл гэгээ олж үзэж, өөрийгөө нэн аз жаргалтай, аятай сайхан байгааг мэдрэх болно. Та билиг ухаан тань өдрөөс өдөрт хэрхэн өсөн хөгжиж, хайр энэрэл тань хязгааргүй их болон өргөжин дэлгэрч буйг мэдэрнэ. Тэр үед та энэ аргыг нэн ачтай, тустай амжилттай байна гэдгийг ойлгож ухаарна. Түүнээс биш таныг ингэ тэг, нүдээ аниад итгэ гэчихээд ямар ч нотолгоо өгөхгүй тэр болгонд яаж итгэх юм бэ? Бид танд нотолгоо өгөх ёстой. Та ч нотолгоо шаардах ёстой. Нотолгоог та авшиг хүртэх үедээ тэр дороо, хожим нь бол өдөр бүр үргэлж авч байх болно. Танд хүндрэл бэрхшээл тохиолдох, осолд орох юм уу хэнд ч хандах боломжгүй үед ид шид гайхамшиг тохиолдохыг биеэр үзэж мэднэ. Тэр үед та Эзэн Бурханы хүч чадлыг ухаарч мэднэ. Тэр үед та Эзэн Бурханд хайртайгаа  мэднэ. Тэгээд та Эзэн Бурхан таныг хайрлаж хамгаалж байдгийг мэдэх болно. Үүнээс өөрөөр та яаж мэдэх юм бэ? Эзэн Бурхан байдгийг бид яаж мэдэх вэ? Бид Түүнийг харахгүй юм бол, хэрэгцээтэй үед тусламж, хамгааллыг нь олж үзэхгүй юм бол Эзэн Бурханы хэрэг юу байна? Биднийг гэх хэн нэгэн буй гэдгийг бид мэдрэх хэрэгтэй. Арьяабалын бясалгалын аргаар бясалгасны дараа та Эзэн Бурханыг Христосын шашинтныхаа хувьд харин ч бүр илүү шүтэх болно. Учир нь бид Эзэн Бурханы мэддэг бүхнийг мэдэж, адислалын хүч, хамгааллыг амьдралынхаа агшин бүрт харж, мэдэрч, ахуй дээр ойлгох болно. [40]

# *Шавилахуй*

Шавь нар цаг үргэлж Эзэн Бурханыг санан дурсаж байх ёстой бөгөөд тэгвэл Эзэн Бурхан хаа сайгүй байх болно. Бид орчныхоо хүмүүсийг харж, тэдний тухай бодож, идэх хоол, унших номоо хуваалцах замаар тэдний үйлийн үрээс авч байдаг. Бид ингэж хүмүүсийг адислан үйлийн үрийг нь багасгаж байдаг юм. Харанхуйг хөөж, гэрэл гэгээ дэлгэрүүлэх гэж бясалгал хийдгийн маань учир энэ билээ. Бидэнд үйлийн үрээсээ өгч байгаа хүмүүс бол азтай адислагдсан улс, бид ч тэдэнд туслахдаа баяр жаргалтай байдаг юм. Бид зөвхөн өөрсдийнхөө төлөө бус бидэнтэй таарч тохиолдох хэний ч төлөө бясалгаж байгаа билээ. Тийм учраас бидний хөгжил дэвшил удаан байдаг юм. Түүнээс биш, бид тэр даруйдаа Бурханы Орон луу явчих юм, тэгвэл хэн энэ ертөнцийг адислах юм бэ? Тийм учраас бид өр төлөөсөө дуусгаж, мөн ертөнцийг адислахын тулд энд байж байх ёстой. Тэгээд ч бид цөм өөр хоорондоо холбоотой. Зам харгуй, нисэх онгоц болон орон байшинг маань барьж байгуулж буй тэр бүх хүмүүс биднээс адис хүртэж байдаг. Цалингаас тань аяндаа суутгагддаг нийгмийн даатгал болон бусад даатгалын татвартай л адил юм. Үүнээс зайлсхийх боломж байхгүй! Өөрөөр бас ингэж бодож болно. Хэрэв та аятай сайхан амьдаръя гэж бодвол улсад тань бий болж буй шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээнд ихээхэн мөнгө үрэх хэрэг гарна. Энэчлэн биднийг бясалгахаар хүмүүс бясалгалын маань үр дүн, буянгаас хар аяндаа хүртэх эрхтэй болдог юм. Чухам ингэж байж л, тав зургаан үеийнхэн тань гэтэлж чаддаг ба гэр бүл болон анд нөхөд тань нас нөгчих үедээ адислал хүртдэг. Энэ хүмүүс танд тусалж дэмждэг байсан учраас, та тэднийг хайрлаж, тэд ч таныг хайрладаг учраас та тэдэнтэй барилдлагатай байдаг юм.” [29]

“Шавь нар маань гадаад улс оронд санаандгүй тааралдах үедээ, хаа нэгтээ юм уу гудамжинд өөр шавь нартай учрах үедээ бие биенээ ах дүү гэдгээ мэдэрдэг бөгөөд энэ хүнд итгэж болно гэдгийг мэдэж байдаг юм. Тэд энэ хүн өөрт нь тусална, өөрийг нь хайрлана, үгүй ядахдаа л хорлохгүй гэдгийг мэддэг юм. Хэрэв дэлхий даяараа ийм болчихвол юу болно гэж та бодож байна? Мэдээж бидэнд алдах осолдох юм гаралгүй яах вэ, хувь хүний зан чанар ч гэж бий, гэвч бид өөр хоорондоо итгэлцэж болно, бидэнд хайр энэрэл бий гэдгийг мэднэ. Бид бусдад хайр энэрэл өгч чадахаа мэднэ. Үүн дээр бид нэг нэгэндээ итгэлтэй байдаг юм. Хэрэв бид ийм дэлхийг бий болгох юм бол Бурханы Оронд очихын ч хэрэггүй, яг эндээ үлдэцгээнэ. Иймд бид Нирванаар эхлээд дэлхий дээр үлдэнэ гэсэн үг. Болох л зүйл.” [36]

“Бид жинхэнэ мөн чанараа, дотоод гэрэл гэгээгээ, доторх агуу их сүр жавхлангаа олж үзлээ. Бусадтай ярилцах үед маань биднээс билгүүн ухаан ундран гарах бөгөөд өөрийгөө илүү мэдлэгтэй болж, үнэхээр гэгээн чанартаа ойрхон байгааг мэдэрдэг юм. Гэхдээ л, сэрэмжтэй байхгүй бол агуу сүр жавхлангаа мартагнаж, билэг ухаанаа ашиглалгүй, хуучин дадал зуршилдаа буцаж унасан мэт санагдах үе гарна. Тиймээс ч, чухам бид өөрөө өөрийнхөө Багш гэдгээ санаж байх, зам мөрөөсөө хэдийд гарчихав гэдгээ үргэлж хянаж, шалгаж байхын тулд сахил санваар болон оюун санааны өдрийн тэмдэглэл байдаг юм шүү. [49]

Та өөрийгөө хэр агуу их болгож чадах тэр хэмжээгээрээ та агуу их юм. Бусдын тусыг бүтээх ба өөрийн хөгжил дэвшлийн төлөө агуу их чанараа хэдий чинээ их ашиглана, та төдий чинээ агуу их байдаг. Харин та Эзэн Бурханыг олж үзэхгүй, өөрийн Бурхан чанараа ухаарч мэдэхгүй, Бурханы Орноо ойлгохгүй байвал намайг битгий буруутгаарай. Үүнд та өөрийгөө л буруутгах ёстой. Өөрийн агуу сүр жавхлангаа ухаарч мэдэхийн тулд найдах ёстой тэр хүн нь та өөрөө юм

шүү. Би гагцхүү зам мөрийг л зааж өгдөг. Би хэчнээн агуу байх хамаагүй. Хэрэв та өөрийнхөө сүр хүчийг нээж, түүнийг ашиглахыг хичээхгүй юм бол үүнээс ямар ч ашиг тус олж чадахгүй шүү. Мэдэв үү? [49]

“Угтаа, бид хэн ч байсан, юутай ч байсан, хэзээд сэтгэл хангалуун байхын тулд, мөн сэтгэл зүрхээ нээж чадаад юунд ч хүлээцтэй тэвчээртэй хандаж байхын тулд, цаашлаад хамаг амьтнаас зөвхөн бурхан чанарыг мэдрэн хэнийг ч дорд үзэхгүйн тулд амар амарлингуйг олох гэж нөр их хичээнгүйлэн бясалгадаг.“ [44]

“Аръяабалын номын цогцыг бясалгагч хүн энэ ертөнцийг орхисны дараа өөрөө хүн төрөлхтний зовлон зүдгүүрийг хөнгөлөх гэж Будда болж эргэн ирэхийг хүсэхгүй л юм бол энэ ертөнцөд эргэж төрөх албагүй. Учир нь Аръяабалын номын цогцыг бясалгагч хүнд очиж болох хавьгүй илүү гайхамшигт, онц сайхан ертөнц олон бий. Түүнд зовлонгоор дүүрэн энэ ертөнц хэрэггүй. Тэрбээр Аръяабалын номын цогцыг бясалгасны дараа билгүүн ухаан, хэлбэлзэл нь гэгээнтнүүдийн хэмжээнд хүрч, түүнийг Бурханы Орны ялгуун тансаг орчинд амьдрах шалгуурт багтаадаг.” [41]

“Намайг халамжлах гэж цаг үргэлж бүү хичээгээд бай. Манай зочид, ах, эгч нар, халамж хэрэгтэй өөр бусдад үйлчилцгээ. Боллоо. Цөмөөрөө л надад санаа тавих шалтаг хайх юм, гэтэл би та нарын хэний чинь ч дотор оршдог гэдгийг та нар ойлгохгүй байна. Та нар бие биедээ санаа тавибал надад санаа тавьж байгаатай л адилхан. Анхаарал халамжийн чинь өчүүхэн хэсэг л надад болно. Бүгдээрээ та нар намайг асрах гэсний хэрэггүй, намайг дарж алах нь байна! (Инээлдэв) Та нарын хайр халамж ихдээд намайг сандаргаж байна, гэтэл тэнд байгаа бусад ах дүү нарт маань хэн ч санаа тавихгүй байдаг. Тэд чинь бас л би, та нар намайг л тоохгүй шоовдорлоод хаячихсан байна шүү дээ. Тэр хүний юу мэдэрч байгааг би мэдэрч байна.

Та нар мэдрэхгүй байгаа бол харин би мэдэрч байна. Тийм учраас та нар тэдэнд санаа тавихгүй байгаагаараа миний санааг зовоож байна гэсэн үг. Учир нь би энэ тухай мэдчихээд санаа зовдог юм." [59]

А. Авшиг хүртээх гэдэг нь тухайн хүнийг адислахыг хэлдэг, энэ нь түүний хувьд шинэ боломж нээж өгдөг гэж хэлж байна уу?

Б. Үнэн чанартаа бид бүгдээрээ ертөнцөд хамгийн агуу их нь юм. Бид хамгийн агуу хүчирхэг эх сурвалжаас ирсэн юм. Тийм учраас бид хамгийн агуу нь. Бид чинь мод, чулуу эсвэл юу санаанд орсноосоо үүссэн байж таарахгүй. Юутай ч, авшиг хүртээх явцад бид ертөнцийн өдөр тутмын ажлаас болж дэндүү завгүй байснаас мартчихсан тэр хамгийн агуу их байр сууриа агшин зуур шууд санаж олно." [58]

А. Танаас авшиг хүртсэн хүн мөнхөд таны шавь болж үлдэх үү? Шавийн хийх ёстой зүйл юу вэ?

Б. Шавийн ажил бол Багш болох явдал. Тийм болохоор та үүрд миний шавь байхын хэрэг байхгүй. Тэр ч бүү хэл та ер нь миний шавь болох шаардлага ч байхгүй, яагаад гэвэл та угаасаа Багш юм, гагцхүү та үүнийгээ мэдэхгүй байгаа хэрэг. Иймд би танд өөрийгөө дахин яаж ухаарч таних вэ гэдгийг хэлж өгч байгаа юм. Ердөө л энэ. [51]

А. Өөр Багшаас авшиг авсан хүнд Та авшиг хүртээх үү?

Б. Болно, гагцхүү би түүнийг илүү өндөр түвшинд илүү түргэн хүргэж чадна гэж тэр хүн үнэхээр итгэж байвал тэгж болох юм. Түүнээс биш, хэрэв Багшдаа маш их хоргодож, маш их итгэдэг бол тэр Багштайгаа үлдсэн нь дээр. Хэрэв та Багшийгаа хамгийн сайн нь гэж хэдийн итгэдэг бол түүнийгээ битгий соль. Хэрэв та эргэлзэж тээнэгэлзсэн хэвээр, мөн миний дээр ярьсан гэрэл гэгээ, дуу аялгууг олж хүртэж чадахгүй байгаа бол туршаад үзэж болно. Яагаад гэвэл гэрэл ба аялгуу бол жинхэнэ Багшийн үндсэн шалгуур юм. Танд агшин зуур гэрэл гэгээ болон дуу аялгуу дамжуулж чадахгүй байгаа хүн бол жинхэнэ Багш биш гэдгийг хэлэхэд

харамсалтай байна. Бурханы Оронд очих замд гэрэл болон аялгуугаар тоноглогдоно. Яг л далайд шумбах үед хүчилтөрөгчийн баг зэргийг өмсөх ёстой болдогтой адилхан юм. Юм бүхэнд өөр өөр зориулалтт бий. Тийм учраас гэгээн хүмүүсийг тойрсон гэрлийн цагариг дүрсэлсэн байдгийг та нар харж байгаа. Энэ бол гэрэл юм. [42]

А. Хүүхдүүд таны аргаар яаж бясалгаж болох вэ?

Б. Хэрвээ эцэг эх нь авшиг хүртсэн бол зургаан настай хүүхэд хагас авшиг хүртэж болно. Хэрэв тэд арван хоёр настай, эцэг эх нь мөн авшиг хүртсэн бол бүрэн авшиг авч болно. Хэрэв эцэг эх нь авшиг хүртээгүй бол арван зургаан нас хүртлээ хүлээх хэрэгтэй болно. [54]

## *Таван сахил*

“Яг одоогийн агшинд бидний билгийн нүд өмнө төрөлдөө хийсэн нүгэл хилэнц болон харанхуй мунхаг байдлаас үүдсэн барцадаар бохирдсон байгаа. Энэ барцадыг арилгахын тулд бидэнд мэддэг хүний гар хэрэгтэй. Бидэнд, бүгдийн маань дотор оршиж байдаг Эзэн Бурханы агуу их хүч хэрэгтэй бөгөөд “цоргыг” нь нээнгүүт л тэр нь гадагшаа ундран гарч ирнэ. Энэ нь дүүрэн устай боловч цорго нь эвдэрчихсэн их савтай адилхан юм. Хэрэв та хүсч байвал би энэ цоргыг ямар ч үнэ хөлс гэхгүй, таны зүгээс өөрийгөө ариусган, буянт амьдралаар амьдарч, мацаг хоол идэхээс өөр ямар ч нөхцөл болзол нэхэхгүйгээр засч өгч болно. Өнөөдрийн өдрөөс эхлэн дахиж мах амсахгүй, амьтны амь хөнөөхгүй, худал хэлж, хулгай хийхгүй зэрэг андгай өгөх ёстой. Энэ нь “Амьтныг бүү хөнөө, бүү худал хэл, садар самуун бүү яв, бүү хулгай хий, согтууруулах ундаа бүү уу, мөрийтэй тоглоомоор бүү тогло, мансууруулах бодис бүү хэрэглэ” гэж өгүүлсэн Библид байдаг арван сахил, жирийн Буддын шашинтны таван сахилтай адилхан юм. [6]

## *1. Сэрэл мэдрэлтэй амьтны амийг бүү хөнөө.*

"Амь хөнөөхөөс татгалзах нь мөн амьтны мах идэхгүй байх утгатай. Учир нь бид өөрсдөө амьтан алахгүй байлаа ч гэсэн бид махыг нь идэхийн тулд өөр хүмүүс амьтныг алах болно. Энэ бол дам аллага. Бид таван сахилыг сахиж чадахгүй бол бид дахин хүн болж төрж чадахгүй.[2]

Мах идэхэд амьтны үхэх үедээ амсаж мэдэрсэн үзэн ядалт, гомдол хорслын хэсэг нь бидний ухамсарт үлдэж бид таагүй хэцүү байдлыг мэдрэх нь гарцаагүй. Тийм учраас бид шөнө хар дарж зүүдэлдэг, харин амьтад биднийг хармагц айж зугтаадаг. Мөн түүнчлэн идсэн маханд байх энэ уур хорсол, үзэн ядахуйгаас болоод бид өвчин тусахаараа эдгэрч илааршихад амаргүй болдог." [11]

А. Амьтны өөх тостой зүйлийг яагаад идэж болохгүй гэж? Бяслагийг иддэг шүү дээ, гэтэл бяслаганд өөх тос байдаг.

Б. Яагаад гэвэл бяслагийг сүүгээр хийдэг, гэтэл өөхийг алсан амьтнаас гаргаж авдаг. Сүүг нь авахын тулд бидэнд үнээ алахын хэрэг байхгүй бөгөөд сүүгээр нь бид бяслаг, цөцгийн тос зэргийг хийж болно. Ялгаа нь үүнд байгаа юм.[56]

А. Үр тогтоогүй өндгийг идэж болох уу?

Б. Үгүй, яагаад гэвэл өндөг бол хагас амьтай байдаг, хэрэв бололцоо олговол тэр нь тахиа болно. Түүнээс гадна өндөг сөрөг хүч, хий биетнийг өөртөө татдаг. Тийм учраас хэрэв бид өндөг идэх юм бол энэхүү сөрөг хүчинд бохирдоно. Хар, цагаан домч нар юм шүглэсэн хүнийг эмчлэхдээ өндөг ашигладгийг та бүхэн мэдэж байгаа байх. Тийм учраас өндөг идэхгүй байх нь тун зүйтэй юм. [39]

А. Хэрвээ мацаг хоолны дэглэм баримтлахыг хүссэн хүн мэдэхгүйгээс юм уу санаандгүй мах идчихвэл яах вэ? Энэ нь түүнд яаж нөлөөлөх вэ?

Б. Тэгэх юм бол гэдэс тань жаахан өвдөх байх. Гэхдээ та өдөр бүр арай илүүхэн бясалгал хийвэл асуудалгүй. Бид үүнээс байнга зайлсхийх боломжгүй. Мацаг хоол нь бидэнд угаас байдаг энэрэн нигүүлсэх сэтгэлийг өргөжүүлэх зорилготой. Үүнийг улам лавшруулж, бялхтал дүүргэн, бүхий л амьд амьтан, дорой буурай бүхэнд түгээх, хайрын үр суулгах, мөн энэрэн нигүүлсэх сэтгэлээ сайжруулахын тулд юм. Гэвч бид санамсаргүйгээр ямар нэг юм хийчихлээ гэхэд биднийг хэн ч буруутгаж чадахгүй. Эзэн Бурхан л лав тэгэхгүй. [54]

## *2. Худал бүү ярь.*

## *3. Өөрийн биш юмыг бүү ав.*

"Бидний биш ямар нэг юмыг зөвшөөрөлгүй буюу урьдчилж хэлэлгүй авбал энэ нь хулгай болно. Бид хүний цаг зав хийгээд хүч тамирыг хулгайлж бас мэднэ. Ийм төрлийн хулгайг та бүхэн сайн мэднэ. Жишээ нь, найз чинь таны утас руу залгаад, хэдэн цагийн турш яриад салахгүй, та бүр ядарч сульдсан ч өрөвч, элдэг зангийн улмаас сонсохоос өөр аргагүй болж "Аа, тийм, тийм..." гээд тасалчихаж чадахгүй байх нь бий. Тэр байтугай уйтай ярианаас нь болоод түүний юу ярьж байгааг нь ч ойлгохгүй. Энэ бол бас л хулгай юм. Үр ашиггүй юм ярьж байхын оронд цаг заваа Эзэн Бурханыг танин мэдэхэд зориулах нь хамаагүй дээр. [4]

## *4. Бэлгийн зохисгүй харилцаанаас татгалзах.*

"Бэлгийн ханамжийг хэт эдлэх нь бие махбодыг тань зүдрээж, өөрийн болон хүн төрөлхтний тусын тулд, төгс гэгээрэлд хүрэхийн төлөө хадгалж хямгадвал зохих сэтгэл санааны хүчийг шавхана. Хямгадах нь үлэмж буянтай хэрэг

болно. Ердөө л энэ. Бэлгийн зохисгүй харилцаа гэдэг нь дэндүү олон амраг юм уу хэт олон эхнэр, нөхөртэй байхыг хэлнэ. Энэ нь хүч тамирын тань нөөцийг шавхаж барагдуулна.” [50]

“Энэ их энгийн зүйл. Хэрэв нөхөртэй бол хоёр дахь нөхрийн тухай бодох хэрэггүй гэсэн үг. Амьдралаа улам эгэл жирийн болгож, сэтгэл санаа үймрүүлсэн маргаан, зөрчилгүй байлгах хэрэгтэй. Ийм зүйлс нь бусдыг гомдоодог. Бид бусдыг сэтгэл санааны хувьд ч зовоож болохгүй. Бид зөрчил тэмцлээс зайлсхийж, бусдыг ялангуяа ойр дотныхоо хүмүүсийг бие, сэтгэл санаа, мэдрэлийн хувьд зовоохгүйг хичээх ёстой. Хэрэв танд нууц амраг байдаг бол эхнэр юм уу нөхөртөө битгий хэлээрэй. Хэрэв та хэлчих юм бол энэ нь бүр ч их зовооно. Яаралгүй, үймээн шуугиан гаргалгүйгээр үүнийгээ шийдэх хэрэгтэй. Түүндээ нүглээ наманчлах хэрэггүй. Заримдаа хүмүүс гэр бүлээс гадуур явдалд ороогцолдчихоод түүнийгээ гэртээ очоод эхнэр, нөхөртөө илчлэн хэлэх нь асар шударга, асар ухаалаг хэрэг гэж боддог. Энэ бол утгагүй явдал, олигтой хэрэг биш. Та хэдийнээ алдаа хийчихээд тэр хог новшоо гэр орондоо чирч ирж, гадны хүмүүсийг баясгах хэрэг юу байх вэ? Хэрэв тэр чинь энэ талаар мэдэхгүй бол тэгж их гутрахгүй шүү дээ. Мэдвэл сэтгэл нь өвдөнө. Тийм учраас бид энэ асуудлаа шийдвэрлэж, дахин давтахгүйг хичээх хэрэгтэй. Ердөө л энэ.”[42]

А. Та ижил хүйстнүүдийн харилцааг эсрэг хүйстнүүдийнх шиг хүндэтгэдэг үү?

Б. Би үнэндээ мэдэхгүй юм байна. Би аль алинд нь мэргэшсэн биш. (Инээлдэв) Танд миний хэлж чадах зүйл бол, та өөрийгөө юунд бие цогцостойгоо адилтгаж, ижил хүйстэн юм уу эсрэг хүйстнээ сонирхогч гэж нэрлээд байдаг хэрэг вэ? Ах дүүс минь, бид бол бие цогцос биш, бид бол ариун сүнс юм шүү. Бид бол биелсэн хайр, бид тэр чигтээ билгүүн ухаан, бид бол ертөнцийн бүх төрөлтнүүдийн Төгс Дээд Багш нар юм. Өөрийгөө юунд юмстай адилтгаж, ангилж, унаган, дорд үзнэ вэ? Энэ бүхэн чинь дамжин өнгөрөх түр

зуурын зүйл төдий юм. Өөрийгөө Эзэн Бурхан гэдгийг танин мэд, гэгээрэлд хүр. [47]

## *5. Мансууруулах бодис хэрэглэхээс татгалзах.*

"Мансууруулах бодис гэдэгт архи дарс, мансууруулагч зүйлс болон хүнийг донтуулж, боол болгон, бодит ухаарлыг бүрхэгдүүлж, ууpаг тархины эд эсийг гэмтээн, юмыг саруул ухаанаар харж, сэтгэж, үйлдэх чадварыг доройтуулагч аливаа зүйлс хамаарна. Энэ бүхэн мансуурлагч бодис юм." [51]

"Тамхинаас яваандаа гарч болох бөгөөд ер нь тамхи татахыг цээрлэх хэрэгтэй. Бид Эзэн Бурханы хүч чадалд мансуурах ёстой болохоос биш, иймэрхүү чанаргүй зүйлээр орлуулах ёсгүй юм. Урьд нь бид нэг л сэтгэл хангалуун биш, ямар нэг зүйлийг хүсээд байдаг атлаа тэр нь чухам юу вэ гэдгийг мэдэхгүйгээсээ болоод хорио цээргүй болохоор эсвэл магадгүй учир мэдэхгүйн улмаас үүнийг хэрэглэж байжээ. Бидний сэтгэл нэг л хоосон оргиж, мөнгө зоосоор элбэг дэлбэг, тохилог соёлтой амьдарч байсан ч аз жаргалгүй байдаг. Бид сэтгэл хангалуун биш болохоороо тамхи, мансууруулах бодис, мөрийтэй тоглоом, секс гэх мэтчилэн ханамж өгч болох бүхнийг хайна. Бид үүгээр сэтгэлээ хангаж чадна гэж боддог, гэтэл бид илүү ихээр хэрэглэх тусмаа улам ихээр тамираа барж, хоосон, утга учиргүй байдлыг мэдэрнэ. Хэдий чинээ их хэрэглэнэ, төдий чинээ ихээр шунах болно, мөн бие махбод хийгээд бодол сэтгэлээрээ төдий чинээ гутаан доромжлогдсон санагдана. Жинхэнэ "мансуурал" л энэ бүхнийг орлож таны сэтгэлийг хангах бөгөөд та энэ бүхнийг ахиад хэрэглэхийг хүсэх ч үгүй болно." [6]

А. Хэрэв би эмчийн зааврaар эм хэрэглэдэг бол мацаг хоолтон болж, авшиг хүртэж болох уу?

Б. Бололгүй яах вэ, яагаад болохгүй байх вэ? Эм бол мансууруулах бодис биш. Мансууруулах бодис гэдэгт

би танай улс оронд хориглодог зүйлийг хэлж байна. Би ч бас үүнийг та нарын өөрсдийн тусын тулд хориглодог, учир нь эдгээр нь таны амьдралыг сүйтгэж, асар их мөнгө төгрөг үрэгдүүлж, таныг золгүй донтон болгоно. Гэтэл та нар чинь энэ Дэлхий дээгүүр Хаан мэт, Эзэн Бурхан мэт алхаж, дотоодынхоо агуу их хүч чадал, билиг ухаанаар бүх ертөнцийг адислаж байх ёстой юм. [46]

А. Согтууруулах бодисыг эмэнд хэрэглэдэг атал бид яагаад ууж болохгүй вэ?

Б. Ууж согтуурах нь ухаан санаанд хор нөлөөтэй. Энэ нь ухаан санааг бүрхэгдүүлэн будилуулж, тодорхой хэмжээгээр мэдрэл алдуулдаг. Тийм учраас гадна талдаа энэ ямар ч сайхан үйлчлэл үзүүлдэг байгаад надад сонин биш. Учир нь согтууруулах ундаа уураг тархийг хорлодог. Гэтэл гэгээрэлд хүрье гэвэл бидэнд бодох сэтгэх тогтолцоо маань хэрэгтэй. Бид хэр зэрэг л мэдээгээ алдана, төдий чинээ их будилж, эрүүл саруул сэтгэн бодох чадваргүй болно. [6]

А. Жимс, жимсгэнэ, хүнсний ногооны химийн бодисыг яах вэ?

Б. Ээ, Бурхан минь. Та туйлширч байна. Давстай усаар угаагаад ид. Тэгэхгүй бол та өлсөж үхнэ шүү, тийм биз дээ? 50

А. Авшиг хүртээх өргөдлийн хуудсан дээр бусад хүнийг эмчлэх гэж оюун санааны хүчээ хэрэглэж болохгүй гэж бичсэн байна. Та үүнийг тайлбарлаж өгнө үү? Миний амьдардаг газар хүмүүс гараараа болон өөр бусад төрлийн эмчилгээ хийдэг юм.

Б. Хэрэв та эмч байя гэвэл эмчилгээгээ хийх хэрэгтэй. Харин та бүх юмыг мэдье гэвэл, түүний дотор анагаахыг ч мэдье гэвэл бүх юмыг бүрэн төгс мэдтэлээ эмчилгээг түр зуур орхих хэрэгтэй. Тэгвэл та анагааж чадна. Эмчлэхгүйгээр эмчилнэ. Хүмүүс таныг хараад л эдгэрнэ. Та элдэв мутрын байрлал үзүүлж, эсвэл хүмүүсийн соронзон талбайгаар оролдож бусниулах ч хэрэггүй. Та өнөөдөр нэг хүнийг анагаачихдаг юм гэхэд маргааш түүнийг өвчлөхгүй гэж баталж чадах юм уу? Та ойлгож байна уу? Энэ бол бүрэн

төгс эмчилгээ биш. Үүнээс гадна хүн оюун санаагаар эмчлэгчийн ачаар эдгэрвэл өөрийнхөө дотоод анагаах хүч чадвартаа итгэхийн оронд тэр эмчид л найдах болно. Ингэх нь өвчтөн хийгээд эмчийн аль алинд нь их аюултай юм. Өвчтөн эмчдээ итгэнэ, эмч нь биеэ илүү тооно. Тийм болохоор хүмүүсийг эмчлэх хамгийн сайн арга бол гэгээрэх явдал болно. Эмчлэхгүйгээр эмчилнэ. Эмчилж буйгаа мэдэхгүйгээр эмчилнэ. [28]

А. Оюун санаагаар анагаах нь бясалгагчийн дэвшилд саад болно гэж та чухам юуг хэлж байна вэ? Хүн рейки гэдэг аргаар гараараа эмчилдэг байвал болох уу?

Б. Хэрэв та төгс гэгээрэлд хүрье гэж хүсч байгаа бол бусдын үйлийн үрд хутгалдах ёсгүй. Яагаад гэвэл ингэж эмчилснээрээ та оюун санааны хүчээ алдаж, материаллаг талд байсаар байх болно. [56]

А. Өдөр бүр хоёр цаг хагас бясалгал хийх нь зайлшгүй хэрэгтэй юу? Яагаад?

Б. Бид хоёр цаг хагас бясалгал хийх ёстой, яагаад гэвэл бид сүнсээ болон халдвар авсан хэсгээ маш их хэмжээний рашаанаар угааж ариусгахад энэ хэрэгтэй. Жишээ нь, та ажлаасаа гэртээ ирэхдээ бүх биеэрээ бохирдоод ирвэл танд хоёр галлоноос багагүй ус хэрэгтэй болно. Бид өдөр бүр ертөнцтэй харилцаж, өөр бусдаас халдвар авч байдаг. Бидний эргэн тойронд байгаа хүн бүхэн, мөн зайлшгүй хийдэг нүгэл маань бидэнд нөлөөлж байдаг. Жишээ нь, амьсгалж байхдаа бид үл үзэгдэх өчнөөн амьтныг хөнөөж байдаг, ногоо идэхдээ ногооны амийг хөнөөж байдаг. Тийм болохоор хоёр цаг хагас гэдэг бол бидний сүнсийг угаах тэрхүү хоёр галлон ус гэсэн үг. Хэрэв та бүтэн хагас галлон усаар угаавал, яах вэ, болж л байна, гэхдээ та бүрэн дүүрэн цэвэршиж чадахгүй. Гэтэл маргааш бүр бохиртчихоод ганцхан галлон усаар угаана. Өдөр бүр ингэж дутуу угаагаад байвал, нэг л өдөр муухай үнэр ханхлах болно. (Инээлдэв.)[6]

А. Авшиг хүртэхийн тулд сахивал зохих таван сахилыг сахихгүй бол юу болох вэ?

Б. Сахихгүй байна л гэсэн үг. Би яах вэ дээ? Дахиад оролдоод үзэх хэрэгтэй, за юу? Хэрэв та үүнийг өөрт чинь болон өрөөл бусдад сайн, оюун санааны зулзаган модыг тань хашиж, хамгаална гэж үзэж байгаа бол сахь. Тэгвээс бид дөнгөж ургасан зулзаган модоо гэмтээхгүй. Түүнээс биш, өөрийн тань ухамсраас гадна таныг буруутгах, танд ямар нэг зүйл хийх хэн ч байхгүй. Тийм болохоор энэ сахилыг сахин мөрдөхийг хичээ, уначих юм бол босоод дахин оролдоорой. [51]

А. Гуань Инь бясалгалын аргыг ондоо аргатай хольж хутгаж болохгүйн учир юу вэ?

Б. Хамгийн дээд зэргийн үр дүнд хүрэхийн тулд миний сургаалыг нэгэн үзүүрт сэтгэлээр барьж, төвлөрөх хэрэгтэй. Хэрэв та миний сургаал болон мөнгө төгрөг дээр зэрэг бясалгах юм уу, өөр бусад тарни бясалгавал мэдээж сэтгэл хоёрдох болно. Энэ бол зүй ёсны зүйл. Би дарангуйлагч биш, би зөвхөн та бүхэнд юу сайн гэдгийг л хэлж байна. Та юу ч хийхийг хүслээ гэсэн бүх анхаарлаа түүндээ төвлөрүүлэх ёстой. Хүмүүс намайг та нарт ийм ч юмыг, тийм ч юмыг хориглодог гэж боддог. Үгүй шүү, үгүй. Миний та нарт хэлж байгаа бүхэн бол гагцхүү сайн зөвлөгөө, багшийн үүрэг юм. Харин та бүхэн өөрсдөө л сонголтоо хийнэ гэдэг нь мэдээж шүү дээ. Та нар миний зөвлөгөөг дагахгүй байж болно. Та нар өөрсдийнхөө үйлдэл, бясалгалын үр дүн, амжилтыг хариуцна. Харин би бол та нарт юу сайн болохыг хэлэх үүрэг хариуцлагатай. За юу? Миний та нарт хэлж байгаа бүхэн бол материаллаг зүйлийн занганаас мултрах, бие сэтгэлийг хясагч тэр хүчнээс дээш гарах, өөрийгөө уураг тархи хэмээх компьютер болон энэ бие цогцсоос илүү агуу зүйл гэдгээ ойлгож ухаарахыг эрмэлзэгч бясалгагчдын эрин дамжсан билиг ухааны охь шим юм. Тэгэхлээр энэ бүхэн бол

оюун санааны зам мөрийг тань хурдасгах нууц арга, нууц томьёо шиг зүйл болно. Та нарын сонголтоос л болно. Эрх чөлөөний зам мөр бол үүрэг хариуцлагын зам, хувийн хариуцлага, сахилга батын зам юм. Тиймээс би хэзээ ч, юуг ч тулган хүлээлгэдэггүй, зөвхөн зөвлөдөг. [59]

## *Мацаг хоол*

"Эзэн Бурханы төлөвлөж бүтээсэн амьд бүхнийг бид хүндэтгэнэ. Амьтай бүхэн үхэл хийгээд зовлонг эсэргүүцэн тэмцдэгийг бид өөрсдийн жишээн дээр харж байна. Тийм учраас бид амьтныг алж хөнөөх юм уу, алж хөнөөж байгааг харахад тэд зовж шаналан, зугтан зайлахыг оролдож буй нь ажиглагдана. Энэ нь Эзэн Бурхан тэднийг амьдрах хүслэнгийн зөн совинтой болгож төрүүлсэн гэсэн үг. Хэрэв бид хөндлөнгөөс оролцож, амийг нь хороовол бид Эзэн Бурханы хүсэл зоригт саад болж байгаа хэрэг. Бид амьтан болгонд бидэнд өөрсдөд маань яаж хандаасай гэж хүсдэгтэйгээ адилхан хандах ёстой. Тэгэх юм бол бид өршөөл аврал, урт нас, билиг ухааныг хүртэн адислагдана. *"Юу тарина, түүнийгээ л хурааж авна"*. Бид Эзэн Бурханыг хэзээ ч зовлон зүдгүүртээ буруутгахаа болино. Бид өөрсдийгөө хэдий чинээ хөгжүүлнэ, бие, хэл, сэтгэл төдий чинээ сайн сайхан болно." [21]

"Чадах хэрээрээ л мацаг хоолтон болохыг хичээгтүн, ингэх нь та нарт тустай юм. Бохир заваан газарт ч ургамал ногоогоор хооллох нь дархлаа сайжруулдгийг та бүхэн мэдэж байх ёстой. Мах иддэг хүмүүсийг бодвол мацаг хоолтон өвчин тусах нь бага байдаг. Тэд илүү хамгаалалттай, тайван амгалан, элдэв зүйл бодох нь бага байна. Мацаг хоолны сайн тал үүнд оршдог юм. Зөвхөн энэрэнгүй нигүүлсэнгүй сэтгэлд хамаг учир байгаа юм биш. Өөр бусдын амь насыг хохироохгүй бол бидний амь нас ч аюулд өртөхгүй гэдгийг бид мартчихаад байдаг. Энэ бол учир шалтгаан, үр дагавар буюу үйлийн үрийн

хууль юм. Хэрэв бид бусдыг өршөөн энэрвэл, тэд ч биднийг өршөөж энэрэх болно.” [4]

“Миний идэх хоолны төлөө өөр нэгэн амьтан зовон тарчлахад хүрсэн гэж бодохгүйгээр хоолоо идэх хэчнээн сайхан билээ. Мацаг хоол идэх үндсэн гол шалтгаан нь энэ юм. Амьдралынхаа хэв маягийг та нар сонго, тэгэхдээ өөрөө өөртөө ч, өрөөл бусдад ч аль болох бага зовлон зүдгүүр учруулахаар сонгоорой. [59]

А. Та цагаан хоол хэрэглэх тухай, тэр нь дэлхийн амар амгаланд ямар хувь нэмэр оруулж чадах талаар ярьж өгч болохсон болов уу?

Б. Дэлхий ертөнцөд гарч байгаа дайн дажны ихэнх нь өлсгөлөн ба янз бүрийн улс орны хооронд хоол хүнсийг тэгш бус хуваарилсантай холбоотой эдийн засгийн шалтгаанаас үүсдгийг харж байгаа биз дээ. Хэрэв та сэтгүүл уншиж, судалгааны үр дүнтэй танилцвал мал сүргийг махны зорилгоор үржүүлэх нь бүх талаар эдийн засгийн дампуурлд хүргэж байгааг мэдэх болно. Энэ нь гуравдагч орнууд дахь өлсгөлөнгийн шалтгаан болж байгаа юм. Үүнийг би ч хэлж байгаа юм биш. Америкийн иргэд та нар судалгаа хийж, ийм дүгнэлт гаргасан юм.

Хүнс тэжээлийн үйлдвэрлэлийн тухай, *“Шинэ Америкийн хоол хунс”* гэдэг номыг уншаарай. Энэ номын зохиогч нь мөхөөлдөсний үйлдвэрийн саятан эзний хүү, тэрээр цагаан хоолтон болж, гэр бүлийнхээ уламжлал хийгээд бизнесийнх нь эсрэг ном бичихээр энэ бүхнийг орхисон байна. Тэрбээр их хэмжээний мөнгө, нэр хүнд, наймаагаа алдсан ч энэ бүхнийг Үнэний төлөө хийсэн юм. Цагаан хоолны тухай болон мөн цагаан хоол нь даян дэлхийн амар амгаланд хэрхэн хувь нэмэр оруулж чадах тухай өгүүлсэн бодит мэдээлэл баримтаар арвин бусад ном, сэтгүүл олон бий.

Бид мах үйлдвэрлэхийн тулд үхэр малыг хэчнээн их ураг, ус, эмээр тэжээж бордон гариг дэлхийнхээ нөөц

боломжийг дампууруулсныг харж байгаа биз дээ. Үхэр ганц удаагийн хоол болохоос өмнө маш их хүний хүч, унаа, хөсөг, замын зардал, олон зуун акр газрын нөөц баялгийг гарздан үрдэг. Ойлгож байна уу? Энэ бүх нөөц бололцоог буурай хөгжилтэй орнуудын дунд хуваарилах юм бол бид өлсгөлөнгийн асуудлыг шийдчих байсан билээ. Аль нэг оронд хүнс тэжээл дутагдах юм бол тэр улс ард түмнээ аврахын төлөө бусад орныг байлдан эзлэх магадлалтай, гэтэл энэ нь алсдаа муу үйлийн үр, өшөө авах явдалд хүргэдэг. *"Юу тарина, түүнийгээ л хурааж авна"* гэж Библид сургасныг санацгаа. Хэрэв бид хоолны төлөө амь хөнөөх юм бол бид өөрсдөө хожим төрөлдөө хоолноос болж алуулах болно. Бид ийм ухаантай, соёлжиж иргэншсэн байтал бидний олонх маань хөрш орныхоо зовлон зүдгүүрийн учир шалтгааныг ерөөс мэдэхгүй байгаа нь харамсалтай. Энэ бол бидний идэх шунал дуршлаас болж байгаа юм. Ганц биеэ тэжээхийн тулд бид өчнөөн олон амьтныг алж хөнөөн, өчнөөн олон хүмүүсийг өлсгөн зовоож байна.

Бид ойлгосон ч ойлгоогүй ч энэ гэм буруу ухамсарт маань дарамт болж байх болно. Түүнээс болж бид өмөн үү, сүрьеэ болон ДОХ мэт бусад эдгэршгүй өвчнөөр зовж байдаг. Яагаад АНУ-д өмөн үүгийн өвчлөлт хамгийн их, үүгээр хамгийн их зовдог вэ гэж өөрөөсөө асуу. Америкчууд үхрийн мах маш их идэж байгаагаас болж өмөнгөөр өвчлөх хувь нь дэлхийд хамгийн өндөр байгаа шүү дээ. Тэд махыг бусад ямар ч орноос илүү их идэж байна. Яагаад Хятад болон бусад коммунист оронд өмөн өвчин бага тархсан байна гэж өөрөөсөө асуу? Тэнд мах бага идэж байна. Үүнийг би биш, танай судалгааны үр дүн хэлж байгаа юм шүү. Иймд намайг бүү зэмлээрэй. [30]

А. Гэгээрэхийн тулд мацаг хоолны дэглэмийг хатуу чанд сахих хэрэгтэй юу?

Б. Үгүй, заавал биш. Чи мацаг хоолгүйгээр гэгээрлийг үзэж мэдэрч болно. Гэвч төгс гэгээрэхийн тулд, аз жаргалант байдлаа цаг ямагт хадгалахын тулд бид хамаг амьтны аз

жаргалыг бүрэн дүүрэн хангах ёстой бөгөөд тэдэнд айдас түгшүүр төрүүлж, орчин тойрондоо аймшигт уур амьсгал бий болгохгүй байх ёстой. Энэ нь илүү бүрэн дүүрэн гэгээрэл болно. Мацаг хоол идэх ёс нь дангаараа таныг гэгээрэлд хүргэж, Будда болоход тань тусалж чадахгүй. Адуу, үхэр цөм л ургамлаар хооллодог ч энэ нь тэдгээр амьтад гэгээрчихсэн гэсэн үг биш билээ. Гэхдээ мацаг хоолтны ёс нь бүрэн төгс гэгээрэлд хүрэх агуу их зам мөр болдог юм. [46]

А. Хэрэв би мах идсээр байх юм бол авшиг хүртсэний дараа ямар ч гэсэн гэгээрэх болов уу?

Б. Мах бол энэ ертөнц дээрх хамаг зовлон зүдгүүр, тэмцэл тулааны шалтгаан болдог төдийгүй таны хувьд ч бас тийм юм. Махнаас татгалзах нь манай гаригийн энх амгаланд хувь нэмрээ оруулна гэсэн үг. Хэрэв бид алж хөнөөх шалтааныг эцэслэчих юм бол түүнийхээ үр дагаварт өөрсдөө алагдаж, шархдах явдал үгүй болно. Түүнээс гадна махан хоолноос татгалзах нь “бүү алж хөнөө” гэсэн сахилд шууд бусаар хамаарах үйлдэл болно. Түүнчлэн энэ нь Эзэн Бурханы бүтээл хамаг амьтдад эрх тэгш байдлаар хандах нигүүлсэх сэтгэлийг маань тэжээн тэтгэдэг юм. Тийм учраас амьтны гаралтай бүтээгдэхүүнээс татгалзах нь бидэнд бүхнээс илүү сайн юм. Та махан хоол иддэг байж, авшиг хүртээд гэгээрлээ ч гэсэн дараа нь маш хүнд үйлийн үрийн улмаас нэн их зовох болно. Яагаад гэвэл энэ үйлийн үр нь зайлшгүй арилах ёстой юм. Та бас оюун санааны өндөр түвшинд хүрлээ ч гэсэн бие махбодын ариун бус байдал тань Бурханы Орны төгс ариун байдалтай харшилдаж, гаж нөлөө үүсгэнэ, ойлгов уу? Бие сэтгэлийн байдал ариун бус бол дотоод хүчнийхээ эрчимт чанарыг тэр бүр тэсч гарахад тийм амаргүй. [53]

А. Цагаан хоолтны хүнсэнд загас тохирох уу?

Б. Та загас идмээр байгаа бол идэж болно. Харин та цагаан хоол идэхийг хүсч байвал загас бол ногоо биш шүү.

(Инээлдэв) [30]

А. Ууланд сургаал айлдаж байхдаа Есүс мянга мянган хүнийг загас болон талхаар хооллосон, мөн хурим дээр Есүс усыг дарс болгон хувиргасан...

Б. Асуултын утга нь юу юм бэ? Та үүнийг надад мэдүүлэх гэсэн юм уу? Би үүнийг мэднэ. Надаас мянгантаа асуусан болохоор би мэддэггүй байсан байлаа ч мэдэхээр болсон. Би загас идэж болохгүй гэхэд, харин Библид Есүс үй олон хүнийг загасаар хооллосон гэж бичсэн гэх гэж байх шиг байна. Гэхдээ та энэ нь ямархуу загас байсан гэдгийг бодож үзэх ёстой шүү. Есүс таван мянган хүнийг хоёрхон загасаар хооллосон. Энэ бол хоосон агаараас шидээр бүтээсэн загас байсан юм шүү. [30]

А. Мах их иддэг нийгэмд мах бага иддэгээсээ илүү их түрэмгий чанар байдаг мэт танд санагддаг уу?

Б. Тийм ээ, та Энэтхэгийг мах илүү их иддэг өөр улс оронтой харьцуулаад үзэж болно. Мөн бусдыгаа бодвол мах их иддэг шашны бүлгийн түрэмгийллийн хэмжээг харьцуулаад үз, тэгвэл та ялгааг нь мэднэ. Түүнчлэн махчин амьтан нь өвсөн тэжээлт амьтнаас илүү түрэмгий байдгийг ч ажиглаж болно. Амьтны аймагт ч дээрх холбоо уялдаа буйг харж болно. [30]

# Бясалгал

Цаглашгүй Их Багш Чин Хайн тавьсан лекцээс

Бид яагаад бясалгал хийх ёстой вэ? Бурханы Орон, Эзэн Бурханы Вант Улс буюу дээд ертөнцөөс сургаал номлол хүлээн авахын тулд сэтгэл санаагаа амирлуулах гэж тэр юм. Бид цаг үргэлж “Надад билиг ухаан хайрла, надад түүнийг, үүнийг өгч хайрла” гэж гуйж залбирдаг боловч Эзэн Бурхан бидэнтэй ярьж харилцах гэхээр бид дандаа л зав чөлөөгүй байдаг учраас Түүнд боломж олддоггүй. Бид яриад, гуйгаад байхаас биш сонсдоггүй. Ойлгож байна уу? Тэгэхээр бясалгал гэдэг маань сонсох цаг юм. Зүйрлэвэл, та нар надад асуулт тавьсан бол хэсэг зуур чимээгүй, нам гүм байх хэрэгтэй, тэгвэл би та нарт хэлэхийг хүссэнээ, та нарын мэдэх хэрэгтэй зүйлийг хэлэх боломжтой болдогтой адил. Тийм биш үү? Бясалгал ч үүнээс өөрцгүй. Чимээгүй суугаад мэдээ хүлээж авна. Тэгэхгүй бол Эзэн Бурхан та нарт хэлэх түм буман юм

байна, харин та бүхэн үүнийг нь сонсох завгүй. Та нар ярьж хөөрч, залбирч, дуулж, сөхөрч мөргөж, эрхи тоолоод дэндүү зав чөлөөгүй. Энэ бүгдийг хийж болно л доо. Би энэ бүгдийг ашиг тусгүй гээгүй байна. Энэ бүгд тун сайн, гэхдээ л Эзэн Бурханд бидэнтэй харилцах боломцоо өгөхийн тулд бид хэсэг зуур нам болох ёстой.” [13]

“Бидний дотоод ертөнц хэзээ ямагт амар амгалан байдаг. Гагцхүү бид үүнийг гадна талаасаа хайж, зав чөлөөгүй болмогц дотоодынхоо энэ жинхэнэ амар амгаланг мартаж, амьдралдаа хүнд бэрх, ая таагүй зүйлтэй учирдаг. Хэрвээ бид яаж ийгээд цаг хугацаа, чин сэтгэл гарган сууж чадвал, эсвэл зүгээр л өөрсдийгөө тайвшруулаад дотроосоо эрж хайвал энэ аз жаргал амар амгалангаа дахин олж чадна. Бясалгалын жинхэнэ утга учир үүнд л оршдог. Бид заавал орон гэрийнхээ хамгийн нам тайван газарт л суух албатай биш. Бид хаа дуртай газраа, автобус хүлээж байхдаа ч юм уу, автобусаар ажилдаа явж байхдаа эсвэл ажил дээрээ суугаад дотор маань үүрд мөнхөд байж байдаг жинхэнэ оюун санаагаа тайван эрж болно. Яагаад гэвэл бид гэдэг чинь бие цогцос ч биш, сэтгэл ч биш юм. Хийж байгаа зүйл маань бид биш, сурч байгаа зүйл маань бид биш, толгойгоо эргүүлүүлж өөрсдийгөө гээд итгэчихсэн зүйл бид биш билээ. Үүнийг тайлбарлахад амаргүй. Би үүнийг ердөө л тов тодорхой ойлгодог, мөн түүнчлэн манай олон бясалгагч нар үүнийг бас ойлгож мэддэг юм.

Бид “Би” гэнэ үү, “хатагтай Смит” гэнэ үү, хэн ч гэж нэрлэдэг байсан, өөрийгөө ядаж оюун ухааны түвшинд үнэхээр танин шинжвээс бид бол энэ биш юм байна гэдгээ тов тодорхой ойлгох болно. Бид хэрэв өөрсдийгөө ийм маягаар ойлгох юм бол бидэнд угтаа оршихуй байхгүй юм. Хэрэв бид өөрийгөө өндөр эрдэм боловсролтой нэгэн, эсвэл амьдралын бэрхшээл цөхрөлтэй тулгарч хорссон нэгэн, эсвэл хайр энэрэлтэй нэгэн, өдий төдий амжилтандаа сэтгэл ханасан нэгэн гэх мэтээр бодох юм бол энэ бүхэн цөм жинхэнэ “Бид” биш. Төрөхөөс маань өмнө бидэнд эрдмийн зэрэг зиндааны мэдлэг, номонд дурлах цэцэн ухаан, ууртай зан, энэрэнгүй

сэтгэл, таагүй болон аятай таатай зүйлсийн тухай мэдрэмж зэрэг байгаагүй. Тиймээс энэ бүхэн цөм бидний өсч бойжих зуураа цуглуулсан мэдлэг, дадал төдий юм.” [58]

“Бүгд л бясалгал яаж хийдгийг мэддэг, гэхдээ та бүхэн буруу зүйлийг л бясалгаад байдаг. Зарим хүн сайхан бүсгүйг, зарим нь мөнгө зоос, зарим нь бизнесийг бясалгадаг. Бүх сэтгэлээрээ хамаг анхаарлаа нэг зүйлд төвлөрүүлэх бүрт тэр нь бясалгал болдог. Тухайлбал, би анхаарлаа гагцхүү дотоодын хүч, энэрэл, хайр, Эзэн Бурханы нигүүлсэнгүй уг чанарт хандуулдаг. Гэвч нам гүм газарт завилж суух төдийгөөр үр дүн олж авдаг юм биш. Эхлээд та энэхүү дотоодынхоо хүчтэй холбогдсон байх ёстой, тэгвэл дотоодын жинхэнэ Мөн Чанар тань бясалгаж өөрийгөө сэрээх болно. Энэ бол бидний бясалгал юм. Бид эгэл хүний тархи толгой, Мөнх бус ойлголтоор бус харин дотоодынхоо жинхэнэ Мөн Чанарыг сэрээж, түүгээр бясалгуулах ёстой. Тэгэхгүй бол та суугаад л мянга түмэн юм бодоод байхаас биш шунал хүслээ номхотгож чадахгүй. Харин та өөрөө нэгэнт сэрчихсэн бол таны дотоодын жинхэнэ мөн чанар, дотоодын тань Эзэн Бурханы хүч бүхнийг хяналтандаа авна. Жинхэнэ бясалгал гэж юу болохыг гагцхүү жинхэнэ Багшийн уламжилсан дамжлагаар сэрснийхээ дараа л та мэдэх болно. Эс бөгөөс энэ нь бие, сэтгэлтэйгээ тэмцэлдэж, цагаа гарзадсан хэрэг төдий болно. [4]

## *Бясалгалын жинхэнэ утга учир*

*“Эцэг Бурхандаа залбирч мөргөхийн цагтаа та нууц танхимдаа орж, нууцхан гэгч залбирагтун, тэгмэгц Эцэг чинь үүнийг хараад илэрхий ивээн тэтгэх болно.” (Матвей, 6 : 5)*

“Гэтэл бид сүм хийдэд л очиж, бүхэнд ил мөргөж байх юм чинь яаж ч нууцгайхан мөргөж чадах вэ дээ. Ингэх ёсгүй, өөрөөр хийх хэрэгтэй байж мэднэ. Библид биднийг балар мөргөл шашинтан юм уу хуурамч дүр эсгэгч нар шиг чанга дуугаар мөргөж залбирч болохгүй гэж сургаж байна. Тэгэхлээр

нууцлагдмал танхимд нууц нь байх нь ээ. Бид сүм хийдэд очиж чанга дуугаар маш их мөргөж залбирч, хүн бүхэн сонсовч, Эзэн Бурхан л харин сонсдоггүйн учир энэ байж. Тиймээс залбирал хүслийн маань ихэнх нь биелдэггүй ажээ. Бид Библид заасныг дагадаггүйгээс ийм болсон. Хэрэв бид Библид итгэдэг юм бол түүнийг илүү анхааралтай судлах ёстой. 30

Гэхдээ энэ нь цаг үргэлж л Эзэн Бурханыг зөвхөн бодоод суугаад бай гэсэн үг биш. Харин Эзэн Бурхантай нэгдэн нийлж, Эзэн Бурхантай нэгэн цогц болж, хэзээ ямагт түүний ухамсарт орших ёстой. Эзэн Бурханы Вант Улс гэж үүнийг л хэлээд байгаа юм. Хэрэв та ням гаригт хаая сүм хийдэд очдог бол энэ чинь Эзэн Бурханы Вант Улсыг хайх бас нэг арга мөн боловч магадгүй тийм ч их үр дүнтэй арга биш байх. Учир нь Есүс Бурханы Орон нь ажиглалтаар олддог бус харин бидний дотор оршдог гэсэн билээ. Хэрэв тийм юм бол бид яах ёстой вэ? Бурханы Орон ажиглалтаар ирдэггүй, тэр нь юу гэсэн үг вэ гэхээр бясалгалаар ч ирдэггүй гэсэн үг, гэвч бид бясалгах ёстой. Бясалгал бидэнд үүнийг илүү их ухаарч мэдрэх боломцоо олгоно. Бурханы Орон бясалгалаар бүтээгдэхгүй боловч бясалгал хийсний үрээр бид дотооддоо угаас орших Бурханы Орныг ухаарч ойлгож авдаг.” 30

“Бид бясалгаснаар Эзэн Бурханы таалалд багтдаг, бид Эзэн Бурханы хүч чадал, Түүний үг хэлтэй холбогдох ёстой гэж бид итгэдэг. Библид айлдахдаа:

*“Анх эхлээд Авиа оршин байсан бөгөөд Авиа нь даруй Эзэн Бурхан байв, тэрхүү Авиа нь Эзэн Бурхантай хамт байв "*
*(Жон, 1:1) гэж дурдсан байдаг.*

Иймд Эзэн Бурханы Хүч чадал, хэлбэлзлийг илэрхийлэгч тэр авиа, дотоодын хэлбэлзэл болох тэр авиаг бид бясалгадаг юм. Яагаад гэвэл бид бол Эзэн Бурханыг агуулагч сүм бөгөөд Эзэн Бурхан ийм маягаар бидэнтэй ярьдаг юм. Тэр бидэнд гэрлийн хэлбэрээр үзэгдэж, бидэнтэй дууны хэлбэрээр

ярьдаг. Гэрэл үзэх үедээ бид өөр олон юмыг үздэг. Үг сонсох үедээ бид өөр олон юмыг сонсдог. Бид Эзэн Бурханаас шууд ирж буй сургаал номыг сонсоно. Бид чухам үүнийг л бясалгадаг юм. Хэрэв та чадалтай Багштай бол бясалгах үед бэрхшээл учирвал Багшдаа дотроо мөргөж залбирч болно, эсвэл та Эзэн Бурханаас дэндүү хол байгаа бол танд зууч хэрэгтэй байж болох юм. Та одоохондоо алхаж гишгэхэд нь эцэг эхийнх нь дэмжлэг шаардлагатай жаахан хүүхэд шиг сул дорой байгаа. Харин хожим та өөрөө ганцаараа явж чадна. Таны зорилго бол өсөж бойжоод өөрөө бие дааж явах болохоос биш цаг ямагт л эцэг эхдээ найдаад байх биш гэдгийг та мэдэж авах ёстой." [24]

## *Хэрхэн яаж бясалгах вэ?*

"Ердөө л анхаарлаа мөнгө зоос юм уу өөр юмс уруу биш харин чиглүүлэх хэрэгтэй тэр зүг үрүү нь, Эзэн Бурхан луу хандуул. Бясалгах чадвар танд угаасаа байж байдаг. Түүнээс биш, хэрэв танд ямар ч анхаарал байхгүй байсансан бол та ажил бизнесээ явуулж, үр хүүхдээ асарч халамжилж чадахгүй байхсан билээ. Тэгэхээр ердөө л анхаарлаа Бурханы Орон луу шилжүүл. Цаг нь болохоор бид танд тов тодорхой заавар өгнө. Ном уламжлахад цаг их ордоггүй, харин өмнөх, дараахи үйл явцыг тайлбарлаж өгөхөд цаг хэрэгтэй байдаг юм. Энэ нь эндээс Бурханы Орон хүрэх замд, ухамсрын янз бүрийн түвшинд таныг юу хүлээж байгааг танд мэдүүлэх зорилготой. Тийм учраас энэ нь цаг хугацаа шаарддаг юм. Түүнээс биш та ердөө нүдээ анингуутаа л тэр дороо гэгээрч болно." [30]

"Бясалгах үед энерги тань нээлттэй байдаг тул болгоомжтой бай. Гэхдээ танд энерги нь амьд, эдүгээ амьд сэрүүн Багш байгаа бол Тэр таныг ийм нөлөөнөөс хамгаалж чадна. Хэрвээ бид соронзон орон нь дээгүүр ертөнц үрүү явчихсан өнгөрсөн үеийн Багшаас суралцах гэвэл тэднээс аврал хамгаалал хүсэхэд жаахан бэрхшээлтэй байх болно. Бид

орчныхоо нөлөөнд сайн муу гэлгүй өртөх хандлагатай байдаг. Иймд бид өөрсдийн юм уу бусдын ахуй ойлголтын алийг мэдэрч буйгаа яг найдвартай мэдэх аргагүй. [61]

А. Бясалгалыг хаана хийж болох вэ?

Б. Хаа дуртай газраа. Цэцэрлэгт, автобусанд, онгоцонд ч болно. Харин машин барьж байхдаа хэрэггүй. Тэгээгүй нь дээр! (Инээлдэв.) Бясалгалын хоёр төрөл байдаг: нэг нь дотоодын гэрэл гэгээ ажих, нөгөө нь бурханлаг хөгжим аялгуу ажих. Сүүлчийнхийг нь ганцаараа байж бясалгах хэрэгтэй болно. Тэр нь дээр. Авшиг хүртээх үед би бүгдийг тайлбарлаж өгнө. [56]

А. Өдөрт хэдий хугацаагаар бясалгах ёстой вэ?

Б. Энэ нь та Эзэн Бурханд хэр хурдан хүрье гэж хүсч байгаагаас хамаарна. Жирийн хүмүүсийн хувьд бол хагас цагаас нэг цаг байж болно. Миний буурьтайхан шавь нарын хувьд бол наад зах нь хоёр цаг хагас, гурван цаг бясалгана. Цаашлаад, үүнд бүр сурч дадсаны хойно бол та ярьж байсан ч, явж байсан ч, унтаж ч байсан цөм бясалгал болдог. Тэр байтугай унтаж байхдаа ч та Бурханы Орныг үзэж, дээд төрөлтнүүдтэй харилцаж чадна. [48]

А. Бясалгах үедээ өдөр тутмын амьдралынхаа нөлөөнд автахгүйгээр бодол санаагаа хэрхэн төвлөрүүлэх вэ?

Б. Бясалгал хийдэг болоод хэсэг хугацаа өнгөрсний дараа энэ аяндаа болно. Хүч чармайлтгүйгээр болчихно. Та тэр байтугай бодож байна уу, үгүй юу гэдгээ ч мэдэхгүй. Та зүгээр сууж байхад л болчихно. Гэрэл ирнэ, аялгуу ирнэ, харин та өөр юуг ч анзаарахгүй. Үүнээс гаръя гэсэн цагтаа л гарч, бүх юмыг анзаарч эхэлнэ. Ойлгов уу? Энэ бол маш амархан. [46]

А. Бясалгаж байх үедээ бид юу бодох ёстой вэ?

Б. Юу ч бодохгүй. Бид цаг үргэлж хэт их юм бодож байдаг атлаа бясалгах үедээ бас юм бодох учир юу байна? Гэхдээ

бидний бодол болон санаа сэтгэлийг амар тайван болгох арга бий. Авшиг хүртэх үед би зааж өгөмз. Бид хамт сууж хэсэг ярих хэрэгтэй болно. Харин жинхэнэ авшиг хүртээх үед би ч тэр, бусад нь тэр юу ч ярьдаггүй, тэгээд нам гүмийн дунд та өөрийнхөө уг чанарыг олж авна. [55]

А. Шизофрени болон хүнд гуниг гутрал гэх мэт сэтгэцийн өвчнөөр өвдөж байсан хүн бясалгалаар хичээллэх нь зөв үү?

Б. Болно, болно. Энэ зүгээр. Энэ нь сэтгэл санааг тань өргөж, аз жаргалтай болгоно. Эзэн Бурханыг олж харахгүй, Түүний хайр энэрлээс тусгаарлагдсан байгаа учраас л хүн гуниг гутралд ордог. Эзэн Бурхантай холбогдож, Түүний оршихуй болоод хайр энэрлийг мэдэрвээс дахин гуниг гутрал амсахгүй болно. Ер нь бид Эзэн Бурханаас тусгаарлагдаад Түүнтэй уулзахыг хүсч мөрөөдөж байдаг учраас бүгд л их бага хэмжээгээр гуниг гутралд автаж байдаг. Их мөнгө хөрөнгөтэй, сайн эхнэр, нөхөртэй байлаа ч гэсэн ялгаагүй энэ дэлхий дээр бүрэн дүүрэн жаргалтай байж чаддаггүй. Үргэлж л ямар нэг зүйл дутагдаад буйг мэдэрч байдаг. Биднийг жаргал цэнгэлтэй болгоно гэж боддогоос бид хаая бас гаж буруу зүйлийг хийдэг. Энэ бол бидэнд Эзэн Бурханы хайр дутсанаас болж байгаа юм. Тийм учраас авшиг хүртэж Эзэн Бурхантай холбогдохоороо бид буруу зүйл хийхээ болино. Бидний хувьд Эзэн Бурханы дэмжлэг тусламж шууд ирэх учраас сахил сахих, дайснаа хайрлахад илүү амар хялбар болно. [8]

А. Бясалгал хийх гэж агуйд очих хэрэггүй, харин ертөнцөд амьдрах, алхах зуураа бясалгах ёстой юм гэж та хэлсэн. Энэ тухайд тодруулж ярьж өгнө үү?

Б. Ертөнцөөс зайлсхийлгүйгээр, ертөнцөд амьдрах зуураа хэрхэн бясалгаж болохыг та авшиг хүртсэнийхээ дараа ойлгоно. Ертөнцийн агуу их энергийг бясалгал хийх болон өдөр тутмын ажил үйлстэйгээ нэгтгэж чадна. Та энэ энергийг арай илүү ухамсартайгаар хуримтлуулж, амьдралынхаа явцад үүнийг түгээн, манай дэлхийг

адислана. Түнээс биш, зөвхөн өөрийгөө адислах гэж л бясалгахын хэрэг алга. Хэрвээ бид өөрсдийгөө жинхэнэ ёсоор таньж мэдчих юм бол даян дэлхийг адислаж чадна. Авшиг хүртэж, гэгээрсний дараа бидний хийсэн ажил бүхэн өнгөц гадна талаасаа илүү гүн гүнзгий утга учиртай болж, бид урьдынх шигээ үүргээ биелүүлсэн төдий байх бус, харин баяр хөөртэй ажилладаг болно. Тэгээд бид багахан ажиллаад бүр улам их хувь нэмэр оруулж чаддаг болно. Би бол их жижигхэн хүн, бас тун жаахан иддэг, мөн бага унтдаг гэдгийг та нар харж байгаа, гэтэл та бүхэн намайг маш их идэвхтэй гэж ярьдаг биш үү. Энэ бол тэр агуу их энергиэс болж байгаа юм. Хэрвээ юу ч хийхгүй бол би баларна. (Инээлдэв) [58]

А. Бясалгал бидний хүсэл шунал, хэрэгцээ шаардлагыг багасгадаг гэж та хэлсэн, гэтэл би хэчнээн сэтгэл хангалуун байсан ч маш их хүсэл, хэрэгцээтэй хэвээр байх юм? Яагаад гэдгийг та тайлбарлаж өгч болох уу?

